


ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нийгмийн ажилтны гарын авлага



ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Нийгмийн ажилтны гарын авлага

ННА 66
ДАА 351
З-703

Энэхүү номыг Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэвлэв.
Худалдахыг хориглоно.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар,
Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
(976) -11-70136990
info@hudulmur-halamj.gov.mn

Эмхэтгэн боловсруулсан: ХНХЯ-ны ахлах мэргэжилтэн С.Рэгзэн
Хамтран ажилласан: ХХҮЕГ-ын мэргэжилтэн Б.Нэргүй

Гарын авлагын 25, 40, 45, 50, 51, 81, 84, 95, 97 дугаар хуудасны
зургийг Монгол-Оросын хамтарсан 3-р дугаар сургуулийн
11-р ангийн сурагч Э.Цацрал зурав.

ISBN: 978-99978-53-14-1

ГАРЧИГ

Өмнөх үг	4
Оршил	5
Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээ хийх арга зүй, аргачлал	8
Нэг. Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө	8
Хоёр. Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	24
Нэг. Үндсэн хэрэгцээ	24
А.Гэр, байшингийн өмчлөл	24
1. Орон сууц, газар өмчлөл	24
2. Эрүүл ахуй, аюулгүй байдал	31
Б. Хоол хүнс, хэрэглээ	43
3. Хүнсний хэрэглээ	43
4. Хүнсний бус хэрэглээ	45
В. Санхүү, ажил эрхлэлт	48
5. Өрхийн санхүү	48
6. Өрхийн ажил эрхлэлт	52
Хоёр. Чадавх, боломж	58
Г. Эрүүл мэнд	58
7. Эрүүл мэндийн хэрэгцээ	58
8. Эрүүл мэндийн хяналт, үйлчилгээ	59
Д. Боловсрол, технологи	72
9. Сургуульд хамрагдалт	72
10. Мэдээлэл, харилцаа холбоо	74
11. Нийгмийн халамж	75
12. Нийгмийн даатгал	84
Гурав. Ёс суртахуун, хүндлэл	93
Ё. Гэр бүл, нийгмийн харилцаа	93
13. Гэр бүлийн харилцаа	93
14. Нийгмийн харилцаа	99
Хавсралт	103
Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний загвар	104
Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж	106
Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт	118
Зорилтот өрхийн хөгжлийн ахиц дэвшил	121
..... Сум/дүүрэг, аймаг/нийслэлийн зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл тайлан	122
..... Сум/дүүрэг, аймаг/нийслэлийн зорилтот өрхийн хөгжлийн ахиц дэвшлийн нэгтгэл	123
Сум/дүүрэг, аймаг/нийслэлийн зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөний үр дүнг үнэлэх маягт	124
Аймаг, дүүргийн хэмжээнд хөтөлбөрт хамруулах өрхийн тооны доод хязгаар*	126
Ашигласан материал	127

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн Нийгмийн бодлогын хүрээнд “Гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна” гэж заасан билээ.

Монгол Улсын төр иргэн бүрийнхээ санаа бодол, оролцоо, дэмжлэгт тулгуурлан айл өрх, хүн бүрийг өөдрөг, гэгээлэг амьдралтай байлгахын төлөө чармайлт гарган ажиллаж байна. Энэ ч утгаараа төр, засгийн бодлого, үйл ажиллагаа бодит биеллээ олоход айл өрх, гэр бүлийн гишүүн бүрийн хичээл зүтгэл, идэвх оролцоо нэн чухал юм.

Иймд Засгийн газраас гэр бүл, хүний хөгжлийг хангах, өрхийг чадавхжуулахад чиглэсэн олон арга хэмжээ авч байгаагийн нэг нь “Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө” билээ. Энэхүү төлөвлөгөө нь хүнд нөхцөлд амьдарч буй зорилтот өрхийн нөөц боломжийг нээн илрүүлэх, мэргэжил, боловсролоо дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах, нийгэм, хамт олны дунд орж хөгжих, хөдөлмөр эрхлэх зэргээр амьжиргааг дээшлүүлэхэд туслах зорилготой юм.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд өрх, иргэн, төр, төрийн бус байгууллагын удирдлага, ажилтан бүхий л талын оролцоо маш чухал юм. Тухайлбал, өөрсдөө бие даан хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай эдгээр өрхийн гишүүдийг сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх замаар дэмжин тусалж, бусдын адил нийгэм, хамт олны дунд хөгжих боломжийг бүрдүүлэх, хууль тогтоомжийн хүрээнд үзүүлж буй хөгжлийн дэмжлэг, үйлчилгээг өрх, гэр, хүн бүрт хүргэх нь төрийн албан хаагч бүрийн үүрэг байх ёстой. Нөгөө талаас өрх, гэр бүлийнхээ өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийг өөрийн сэтгэлийн тэвчээрээр даван туулах хүсэл эрмэлзэл хүн бүрт байх ёстой.

Талуудын хүсэл эрмэлзэл, үүрэг хариуцлагын эцсийн үр дүн нь хэдэн өрхийн амьжиргаа дээшилснээр хэмжигдэнэ. Иймд энэхүү гарын авлагыг хэрэглэгч Та бүхнийг олон өрхөд хөгжлийн гарцыг олоход тусалж, амьдралын зөв дадал хэвшилд сурах, аз жаргалтай, инээд баясал дүүрэн амьдралтай болоход тус нэмэр оруулж чадна гэдэгт эргэлзэхгүй байна. Түүнчлэн Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх энэхүү гарын авлага нь Таны өдөр тутамд хэрэглэгдэх ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна.

Тус гарын авлагыг боловсруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Швейцарийн хөгжлийн агентлагийн хамт олонд болон хамтран ажилласан бүхий л байгууллага, хүмүүст талархал илэрхийлье.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА**



Б.НЯМДАВАА

ОРШИЛ

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, олон нийтийн соёл, амьдралын хэв маяг сүүлийн 20 жилд өөрчлөгдөн шинэчлэгдэж, макро түвшний олон үзүүлэлт сайжирч байгаа хэдий ч ядуурал төдийлөн буурахгүй байна. Үндэсний Статистикийн хорооны мэдээллээр 2014 оны байдлаар манай орны ядуурлын хамралтын хүрээ 21,6 хувь байна.

Ядуурал нь өөрөө өргөн хүрээтэй, салбар дундын зохицуулалт шаардсан асуудал бөгөөд ядуурлыг зөвхөн орлогын хэмжүүрээр бус, мөн нийгмийн харилцаа, чадавх болон оролцооны байдлаар тодорхойлох шаардлагатай юм. Орлогын талаас нь тодорхойлохдоо хүний наад захын хэрэгцээ хангагдах байдлыг авч үздэг бол, хүний өөрийн чадавх талаас нь уншиж бичих, урт удаан эрүүл энх амьдрах, чөлөөтэй шилжин суух, нийгмийн амьдралд хувь нэмэр оруулах зэрэг ойлголт багтдаг. Харин нийгмийн харилцааны талаас тухайн хувь хүн өөртөө байгаа боломж нөөцийнхөө хүрээнд үйл ажиллагаа явуулж чадахгүй байхыг тухайлбал, бусадтай нийгмийн харилцаанд орж чадахгүй байх, хүн өөрөө өөрийгөө болон нийгэм түүнийг ядуу хэмээн үздэг байх, гадуурхагдах, төрөөс хүртэх халамжийн болон эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахгүй байх, хоол тэжээлийн доройтол, бараа үйлчилгээний дутагдал, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадваргүй байх зэрэг олон төрлийн хязгаарлалт багтдаг. Энэ бүгд нь өнөөгийн өрхийн ядуурлын үндэс болж буй юм.

Нийгмийн хөгжлийн чиг хандлага нь аливаа бодлого, үйл ажиллагааг нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлд чиглүүлэх явдал гэж үзэх болсон. Иймд тухайн өрхийн нөхцөл байдлыг судлан, нөөц боломж, чадавхийг нь өрхийн гишүүдийн оролцоотой тодорхойлж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой хөгжлийн төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлэх замаар тухайн өрхийн амьжиргааг сайжруулах, ядуурлаас гаргах явдал чухал болж байна. Түүнчлэн өрхийн гишүүдэд ядууралд орохоос зайлсхийх, ядууралд хүргэж болох хүчин зүйлтэй тэмцэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зөвлөгөө өгөх, дэмжин туслах үйлчилгээг хөгжүүлэх асуудлыг хамтад нь авч үзэх шаардлагатай юм.

Монгол Улс 2016 оны жилийн эцсийн байдлаар 869.9 мянган өрхтэй болжээ. Эдгээр өрх, түүний гишүүд нь өөрийн гэсэн харилцааны онцлог, нөөц боломж, чадавхтай бөгөөд энэ нь амьжиргааны түвшний ялгааг бий болгох нөхцөл болж байна. Түүнчлэн, тухайн өрхийн амьдарч буй орчин, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, орлогын эх үүсвэр, ам бүлийн байдал, өрхийн гишүүдийн эрүүл мэнд, боловсролын байдал зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

Ядуурал, ажилгүйдэл зэрэг нь аливаа өөрчлөлтийн сөрөг үр дагавар учраас нийгмийн хөгжил хангагдсан тэр цагт л асуудал шийдвэрлэгдэнэ гэж үздэг. Гэтэл иргэд, гэр бүл өөрсдийн хүч боломжийг дайчлан тодорхой хэмжээний бэрхшээл, хүндрэлийг даван туулах, өрх гэрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн наад захын асуудлыг нийгмийн үйлчилгээний тусламж дэмжлэгтэйгээр шийдвэрлэх боломжтой гэдгийг орхигдуулаад байгааг анхаарах хэрэгтэй болсон байна. Иймд өнөөгийн нийгмийн хөгжлийн онолын чиг хандлага нь гэр бүлийг чадваржуулснаар өрх, гэр бүл нь үндсэн хэрэгцээгээ хангахын тулд өөрийн

нөөц боломжийг ашиглан, нийгмийн асуудлуудаа шийдвэрлэх, тохиолдсон бэрхшээлээ даван туулах чадвартай болно гэж үзэж, үйл ажиллагааг ч мөн үүнд чиглүүлж байна.

Иймд Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 26 дугаар тушаалаар Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах, түүнд хяналт шинжилгээ хийх арга зүйг батлан хэрэгжүүлж байна.

Нэг.

ЗОРИЛТОТ ӨРХИЙН
ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

НЭГ. ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Засгийн газраас 2012-2015 онд хэрэгжүүлсэн “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд нийгмийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг багцлан хүргэж, тэдний сөрөг дадал, хэвшлийг нь нийгмийн ажилтны оролцоо дэмжлэгтэйгээр өөрчлөхөд чиглэсэн “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г 55,0 мянга гаруй өрх бүрт боловсруулан хэрэгжүүллээ. Үүний үр дүнд хөтөлбөрт хамрагдсан 17,0 мянган өрх буюу нийт өрхийн 30 гаруй хувийнх нь амьжиргаанд эерэг өөрчлөлт гарсан байна.¹

Иймд тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлага, сургамжид үндэслэн зорилтот өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүдийг ажил хөдөлмөртэй болгох, хүүхэд, ахмад настан зэрэг бусад гишүүдийг нь боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамруулах, гэр бүлийн боловсрол олгох, зарим сөрөг дадал зуршлыг нь өөрчлөх зэргээр нийгмийн үйлчилгээг өрхөд багцлан хүргэх зорилгоор Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор баталж, 2016-2020 онд хэрэгжүүлэхээр болсон.

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад ашиглагдах нэг гол хэрэгсэл бол “Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө” юм. “Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө” нь өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж, чадавхид тулгуурлан, өрхийг хөгжүүлэх, амьжиргааг сайжруулах зорилготой үйл явц юм. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр өрхийн гишүүд өөрсдийнхөө төлөө идэвх санаачилгатай ажиллах, амьдрах хүсэл эрмэлзэлтэй болж, өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхийн зэрэгцээ тэдний гэр бүлийн харилцаа сайжирч, улмаар нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдэж, нийгэмд эзлэх байр суурь өсөх юм.

Өрхийн ахуй нөхцөл, амьдрах орчин, эрүүл мэнд, боловсрол, нийгэм, эдийн засгийн байдлыг харгалзан үзэж, бодит хэрэгцээнд тулгуурласан, өрх бүрийн онцлогт тохирсон хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх нь маш чухал. Энэ нь иргэд, олон нийтийн бэлэнчлэх, идэвхгүй сэтгэлгээг өөрчлөх, аливаа асуудлын талаар тэдэнд эерэг зан үйлийг төлөвшүүлэх, ядууралд хүргэж буй язгуур шалтгааныг арилгах ач холбогдолтой.

Хөгжлийн онолоор бол, хөгжил хүний эрэлт хэрэгцээнээс эхэлж, харин эрэлт хэрэгцээ нь хөгжлийн зорилго, тэмүүллийг бий болгодог. Abraham Maslow (Mahbubul Islam, 2009)-ийн “Хэрэгцээний онол”-оор бол эрэлт хэрэгцээ хүмүүсийг хөгжилд уриалан дуудаж, өдөөж байдаг аж. Энэхүү онолыг Maslow 1940-1950-иад оны үед дэвшүүлж байсан ч одоог хүртэл хүний хөгжил, хүмүүсийн төлөөх хөгжилд чухал байр суурь эзэлсэн хэвээр байна. Маслоугийн

¹ Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, 2014 он, НХҮЕГ

онолоор бие физиологийн болоод аюулгүй байдлын хэрэгцээ хангагдаагүй цагт хэзээ ч дээд түвшний 3 хэрэгцээг хангаж чаддаггүй байна. Ийм ч учраас үндсэн хэрэгцээ болоод аюулгүй байдал бүрэн хангагдаагүй өрх, гэр бүл, нийгэмд гэмт хэрэг, хүчирхийлэл, хууран мэхлэлт, ялгаварлал, гадуурхал зэрэг сөрөг үзэгдлүүд амь бөхтэй оршсоор байдаг байна.

Зураг 1: Abraham Maslow-ийн хэрэгцээний онол-Эрэлт хэрэгцээний 5 түвшин



Нийгэм ядуурлаас ангид, хууль эрхзүй мөрддөг, тав тухтай, амар амгалан, сайн сайхан аж байдлыг бий болгохын тулд хөгжлийн үйл явцад өрх нэг бүрийн гишүүдийг оролцуулж, тэдний хэрэгцээ, чадавх болон харилцаанд суурилсан үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх хэрэгтэй.

“Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-нд орлогыг орлуулан тооцох аргачлалын дагуу өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаж, мэдээллийн сангийн бага хэрэглээтэй бүлэгт орсон, хэрэв ийм судалгаа хийгдээгүй бол сум/хорооны түвшинд нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатайг нь тогтоож, Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар баталгаажсан өрхөөс сонгон хамруулна. Тухайн орон нутгийн онцлогоос хамаарч бичил уурхай эрхэлж байгаа, хорих ангиас суллагдсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, согтуурах мансуурах өвчтэй, эдгэшгүй хүнд өвчтэй, шилжин суурьшсан, хүнд нөхцөлд байгаа хүүхэдтэй, гэр оронгүй тэнэмэл иргэнтэй зэрэг нийгмийн тулгамдсан асуудалтай өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн бага хэрэглээтэй өрхийг сонгох нь зүйтэй юм.

“Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г сонгогдсон өрхийн гишүүд тухайн сум, хорооны нийгмийн ажилтантай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ. Нийгмийн ажилтан тухайн өрх, өрхийн гишүүд өөрсдийн нөхцөл байдлаа үнэлж, хөгжлийн зорилго, зорилт, түүнд хүрэх арга замаа тодорхойлох, төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд туслан дэмжих үүрэгтэй оролцоно. Мөн нийгмийн ажилтан өрх бүртэй тулж, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх, холбогдох

байгууллага, ажилтантай холбон зуучлан, орон нутгийн засаг захиргааны болон салбарын байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж, хамтран ажиллана.

“Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө” нь дараах үндсэн хэсэгтэй: Үүнд:


- Өрхийн хөгжлийн зорилго (тухайн өрхийн 3-5 жилийн хүсэл эрмэлзэл, мөрөөдөл), зорилт (тухайн өрхийн ойрын буюу 1-2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа)
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөө буюу төлөвлөлт
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Өрхийн хөгжлийн үйл явцад өрхийн бүх гишүүдийн идэвх санаачилга, оролцоо
- Өрхийг хөгжүүлэх, сайжруулах талаарх нээлттэй, уян хатан бодлого, хөтөлбөрүүд, хамтын ажиллагаа

“Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хүний эрх, хөгжлийн зарчмыг эрхэмлэн дээдлэх;
- Жендэрийн тэгш байдлыг хангах;
- Хот суурин газар, орон нутгийн нөхцөл байдал, нийгэм, эдийн засаг, соёл, уламжлалыг тусгах;
- Өрхийн гишүүдэд сайхан амьдрах хүсэл эрмэлзлийг төрүүлэхүйц байх;
- Өрхийн гишүүн бүрийн онцлог хэрэгцээ, нөөц боломж, чадвар, оролцоонд тулгуурлах;
- Өрх, олон нийтэд эерэг зан үйлийг төлөвшүүлэн хэвшүүлэх;
- Өрхийг чадваржуулах, иргэдийг мэдлэг чадвартай болгох;
- Орон нутгийн нийгмийн ажилтан, салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг хангах;
- Салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах, сайн туршлагыг дэмжин нэвтрүүлэх.


“Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь дараах үе шаттай (Зураг 2) байна. Үүнд:

Зураг 2: Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үе шат



Өрхийн хөгжлийн гурвалжин: Зорилтот өрхийн хөгжлийн гурвалжин нь өрхийн үнэлгээнд ашиглагдах бөгөөд өрхийн хөгжлийн эрэлт хэрэгцээний гурван түвшинг илэрхийлнэ (Зураг 3). Нэгдүгээр түвшин нь өрхийн “Үндсэн хэрэгцээ” болох орон байр, хоол хүнс, хэрэглээ, санхүү, ажил эрхлэлтийг, хоёрдугаар түвшин нь өрх, өрхийн гишүүдийн “Чадавх, боломж”-ийг буюу тухайн өрх үндсэн хэрэгцээгээ хангахад шаардлагатай чадавх, боломж бий эсэхийг тодорхойлно. Гуравдугаар түвшин нь “Ёс суртахуун, хүндлэл” буюу тухайн өрхийн нийгэмд эзлэх байр суурь, гэр бүлийн үнэ цэнэ, нийгмийн харилцаа, оролцоо гэсэн талыг илэрхийлнэ. Өрхийн хөгжлийн гурвалжин нь 3 түвшин, 7 бүлэг, 14 асуудлын 38 үзүүлэлтийг багтаасан.

Зураг 3: Зорилтот өрхийн хөгжлийн гурвалжин



Өрхийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрийн ойлголт, тодорхойлолтыг Монгол Улсын хууль тогтоомж, “Хүн ам, орон сууцны тооллого”, “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа”, олон улсын байгууллагуудаас гаргасан стандарт зөвлөмж болон Монгол Улсад хийгдэж байгаа бусад холбогдох хүн ам, нийгэм, эдийн засгийн судалгааны ойлголт, тодорхойлолттой нийцүүлсэн болно.

Өрхийн суурь үнэлгээ: Өрхийн хөгжилд өрхийн гишүүд нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдахгүй байх, ажил хөдөлмөр эрхлэхгүй байх, орлогогүй байх, идэвхгүй залхуу байх зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Ялангуяа, ядууралд өртөөд байгаа өрхүүдэд ядууралд хүргэж байгаа шалтгаан, үр дагаврыг ойлгуулах, тэдний боломж, чадавхийг нь тодорхойлох, идэвхжүүлэх замаар зөв зан үйлийг хэвшүүлэх, амьжиргааг нь дээшлүүлэх арга хэмжээнд өөрсдийнх нь оролцоог дэмжих шаардлагатай байна.

Сонгогдсон өрхүүдийн суурь үнэлгээг жил бүрийн 5 дугаар сарын 1-ны дотор “Өрхийн хөгжлийн гурвалжин”-г ашиглан өрхтэй хамтран хийнэ. Харин нийгмийн ажилтан өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны мэдээллийн сангаас тухайн сонгогдсон өрхийн шаардлагатай үндсэн мэдээллийг нэмж авна.

Үнэлгээг хийхдээ сонгогдсон өрхүүдийг оролцуулсан сургалт-семинар зохион байгуулна. Сургалт-семинарын явцад үнэлгээ хийх, өрхийн хөгжлийн зорилго, зорилт дэвшүүлэх, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хянах-үнэлэх арга зүйд суралцана.

Эдгээр өрхийн гишүүдийн онцлог нь ихэвчлэн боловсрол, мэдлэг бага, идэвх санаачилга, оролдлого сул, нийгэм, хамт олноос тусгаарлагдмал байдаг. Иймд тэдний онцлогт тохирсон сургалтын аргыг ашиглаж, аль болох хялбар аргаар ойлгуулах нь чухал юм. Иймд өрхийн үнэлгээг “Өрхийн сургалт үнэлгээ”-ний аргаар хийнэ.

Өрхийн сургалт үнэлгээний зорилго нь тухайн өрхөд тохиолдож буй асуудлыг дүрслэн харах, шалтгаан ба үр нөлөөнд дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэхгүй бол ямар хор нөлөөтэй болохыг ойлгуулах, түүнийг шийдвэрлэх арга замыг хамтран тодорхойлоход оршино.

Сум, хорооны ажлын хэсгээс томилсон Хамтарсан баг Өрхийн сургалт үнэлгээ зохион байгуулж, түүнтэй холбоотой бэлтгэл ажлыг хангана. Энэ хүрээнд дараах ажлыг зохион байгуулах ёстой:

- Сонгосон өрхүүдийг бүлэгт хуваах, нэрсийн жагсаалт гаргах
- Өрхөд зар хүргэх
- Өрхийн сургалт үнэлгээ явуулах байр, танхимыг бэлтгэх
- Өрхийн сургалт үнэлгээ явуулах багш нарыг сонгож, сургалт үнэлгээ явуулахад бэлтгэх, сургалт явуулах
- Өрхийн дэвтрийг нээж, ашиглахад бэлэн болгох
- Сургалтад ашиглах материалыг олшруулж бэлтгэх, ялангуяа, өрхийн хөгжлийн гурвалжинг оролцогчдын тоогоор бэлтгэх

Ерөнхийдөө нэг удаагийн сургалтад 15-20 өрхийг хамруулж болох ба хэт олон бол сургалт үр дүн багатай болох талтай.

Сургалт үнэлгээнд насанд хүрэгчид болох эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллийг оролцуулах хэрэгтэй ба боломжтой бол гэр бүлээр нь оролцуулбал илүү ач холбогдолтой. Эдгээр хүмүүсийг багтаасан нэрсийн жагсаалтыг бэлтгэнэ.

Орон нутгийн нөхцөл, боломжид тохируулан хугацааг товлож, сургалт явуулах байрыг бэлтгэнэ. Сургалт болох байр нь дулаан цэвэр байх, багш болон оролцогчид ойр дотно харилцах боломжийг бүрдүүлсэн, хичээлийн үзүүлэн хүн бүрт харагдаж байхаар сандал ширээг засаж бэлтгэсэн байна.

Хүснэгт 1. Өрхийн сургалт үнэлгээ явуулахад шаардлагатай зүйлс

№	Зориулалт	Шаардлагатай зүйлс	Тоо, хэмжээ
1.	Сургалт явуулах	Багц үзүүлэн	1-2 багц
2.	Үнэлгээ хийлгэх	Өрхийн хөгжлийн гурвалжин	Оролцогчийн тоогоор
3.	Үнэлгээг тэмдэглэх	Үзэг харандаа	Оролцогчийн тоогоор
4.	Оролцогчдыг бүртгэх	Оролцогчдын бүртгэлийн хуудас	1-2 ширхэг
5.	Мэдээлэл, арга зүй авах	Сургагч багшийн гарын авлага	Багшийн тоогоор

Нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдийн оролцоотой сургалтыг зохион байгуулна. Үүний тулд сургалт үнэлгээний өмнө Хамтарсан багийн гишүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулна. Сургалтад хамрагдсанаар хамтарсан багийн гишүүд үзүүлэн, гарын авлагатай танилцаж, өөрийгөө бэлтгэх ёстой.

Өрхийн сургалт үнэлгээ нь өрхийн хөгжилд нөлөөлж буй асуудлуудын талаар ойлголт, мэдлэг өгөх, мэдлэг дээр нь тулгуурлан өрхийн нөхцөл байдлыг өөрсдөөр нь үнэлүүлэх, асуудлын шалтгаан, үр дагаврыг тодорхойлох гэсэн 3 чухал үйл явцыг нэг цаг хугацаанд хийх сургалт үнэлгээ хосолсон шинэлэг арга юм.

Иргэд өрхийн сургалт үнэлгээнд хамрагдан өрхийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлс болон нийгмийн суурь үйлчилгээний ач холбогдлыг ойлгосноор үйлчилгээг өөрсдөө очиж авдаг болохын зэрэгцээ өөрсдөөс хамаарах зүйлсийг хийж эхлэх юм. Өрх, гэр бүлийн хөгжлийн төлөөх үйл явцад иргэдийн идэвх оролцоо, санал санаачилга нэн чухал байдаг. Энэхүү сургалт үнэлгээгээр өрхийн гишүүдэд эерэг зан үйлийг хэвшүүлэх, өөрөө өөрсдийнхөө төлөө чармайдаг болгох эрмэлзлийг бий болгохыг зорьдог.

Иргэд нийгмийн суурь үйлчилгээг өөрсдөө очиж авдаг болсноор өрхийн гишүүн бүр эрүүл саруул бие бялдартай, боловсролтой иргэн болоход сайнаар нөлөөлөөд зогсохгүй үйлчилгээний байгууллагын ачааллыг багасгаж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ач холбогдолтой юм.

Багш сургалт үнэлгээг удирдан явуулахдаа Өрхийн хөгжлийн гурвалжин дахь 14 үзүүлэлтийг багтаасан багц үзүүлэнг ашиглана. Ингэхдээ дараах 3 үйл явцыг үзүүлэн бүр дээр хийнэ. Үүнд:

- Оролцогчдод шинэ ойлголт мэдлэг өгөх, сэдэл төрүүлэх: Багш үзүүлэнг бүх оролцогчдод харагдахуйц зөв барьж асуулт тавьж, оролцогчоос хариулт авна. Багш үзүүлэнд тулгуурлан харилцан ярианы аргаар сонирхол төрүүлэхээр тайлбарлаж шинэ мэдлэг, мэдээлэл өгнө.

- Мэдлэг мэдээлэл дээр нь тулгуурлан тухайн асуудал өрхөд ямар байгааг өөрсдөөр нь үнэлүүлж, Өрхийн хөгжлийн гурвалжинд тэмдэглүүлэх: Багш үнэлгээг хэрхэн хийх талаар тайлбарлаж өгнө. 14 үзүүлэлтийг 38 шалгуураар дүгнэнэ. Үнэлгээг хийхдээ үзүүлэлтүүдийг багтаасан Өрхийн хөгжлийн гурвалжин бүхий үнэлгээний хуудсыг ашиглана. Өрхийн нөхцөл байдлыг 1-3 оноогоор үнэлэн, "Өрхийн хөгжлийн гурвалжин" үнэлгээний хуудас ашиглан тэмдэглэнэ. Үнэлгээний дүнг Лайкерт²-ийн хэмжээсийг ашиглан гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, үзүүлэлт нэг бүрт харгалзан "Хангалтгүй буюу 1", "Дунд зэрэг буюу 2", "Хангалттай буюу 3" гэсэн онооны аль тохирохыг өгөх замаар үнэлгээг хийнэ. Өрхөд тухайн үзүүлэлт хамааралгүй буюу тухайн асуудалд хамааралтай гишүүн байхгүй бол үнэлгээ хийгдэхгүй байж болно
- Тухайн асуудал яагаад хангалтгүй буюу хэрэгжүүлэхгүй байгаа шалтгааныг ярилцах: Багш үзүүлэн бүр дээр мэдлэг мэдээллээ өгөөд, өрхийн үнэлгээг хийлгэсний дараа тухайн асуудлыг яагаад сайн хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан, үр дагаврыг оролцогчидтой ярилцана. Оролцогчдын хэлсэн шалтгааныг нэг бүрчлэн сайн тэмдэглэж авна. Энэхүү тэмдэглэлийг өрх бүрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, өрхөд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхэд ашиглана.
- Өрхийн үнэлгээг хийлгэсний дараа тухайн асуулгыг сайжруулахгүй, хэвшүүлэхгүй бол ямар хор холбогдолтой болохыг сайн ярилцаж, өрхийн гишүүдэд эерэг зан үйлийг хэвшүүлэх, нөхцөл байдлаа сайжруулах хүсэл, сэдлийг төрүүлэх юм.

Сургалтын үеэр иргэдийн хийсэн үнэлгээ тухайн өрхийн бодит байдалтай нийцэхгүй байж болно. Иймд сургалтын дараа нийгмийн ажилтан болон Хамтарсан багийн төлөөлөл өрхөд хүрэлцэн очиж, нөхцөл байдалтай танилцан, үнэлгээг дахин нягтлах нь зүйтэй.

Үзүүлэлт нэг бүрээр хийсэн үнэлгээний дүнг нэгтгэн, Хүснэгт-д нөхөж бичнэ. Үүний дараа асуудал бүрээр болон нэгдсэн Үнэлгээний дундаж утгыг тооцно. Үнэлгээг ингэж тооцсоноор чухам аль асуудалд тухайн өрх нэн тэргүүнд анхаарах шаардлагатайг тодорхойлдог ач холбогдолтой. "Үнэлгээний дундаж утга"-ыг жигнэсэн дундаж ашиглан тооцно. Үнэлгээний дундаж утга нь хангалттай (2.5-3.0), дунд зэрэг (1.9-2.4), хангалтгүй (1.8 ба түүнээс доош) гэсэн хэмжээстэй байна.

$$\text{Үнэлгээний дундаж утга} = \frac{3*Y_1 + 2*Y_2 + 1*Y_3}{Y}$$

Энд: Y_1 => Хангалттай үнэлгээ авсан үзүүлэлтийн тоо
 Y_2 => Дунд зэрэг үнэлгээ авсан үзүүлэлтийн тоо
 Y_3 => Хангалтгүй үнэлгээ авсан үзүүлэлтийн тоо
 Y => Өрхөд хамааралтай нийт үзүүлэлтийн тоо ($Y=Y_1+Y_2+Y_3$)

2 Аливаа үзэгдэл юмс, үйл ажиллагааны субъектив тал болох үзэл бодол, хандлага зэргийг тоогоор шууд илэрхийлэхэд төвөгтэй байдаг. Ийм шинжийг хэмжихэд ашигладаг хэмжээсийг "Лайкертийн хэмжээс" гэнэ.

Хөгжлийн түвшин үнэлэх оноог дараах байдлаар тооцно. Үүнд:

$$\text{Хөгжлийн түвшин үнэлэх оноо} = \frac{3*Y_1 + 2*Y_2 + 1*Y_3}{Y * 3} * 100$$

Хүснэгт 2: Зорилтот өрхийн ерөнхий үнэлгээ

	Эрэлт хэрэгцээний түвшин	Нийт үзүүлэлтийн тоо	Өрхөд хамааралтай үзүүлэлтийн тоо	Үүнээс:			Үнэлгээний дундаж утга
				Хангалттай "3"	Дунд зэрэг "2"	Хангалтгүй "1"	
1	Үндсэн хэрэгцээ	16					
	А Орон байр	7					
	Б Хоол хүнс, хэрэглээ	4					
	В Санхүү, ажил эрхлэлт	5					
2	Чадавх, боломж	15					
	Г Эрүүл мэнд	5					
	Д Боловсрол, технологи	5					
	Е Нийгмийн хамгаалал	5					
3	Ёс суртахуун, хүндлэл	7					
	Ё Гэр бүл, нийгмийн харилцаа						
ДҮН		38					
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		Үнэлгээний дундаж утга					
		Хөгжлийн түвшин үнэлэх оноо					

Өрх бүрийн Хөгжлийн түвшин үнэлэх оноог ашиглан өрхийн хөгжлийн бүлгийг дараах байдлаар тодорхойлно.

Хүснэгт 3: Зорилтот өрхийн хөгжлийн түвшний ангилал

	Хөгжлийн түвшин	Үнэлэх оноо
1	Заавал хөгжих өрх	60, түүнээс доош оноотой
2	Хөгжлийн төлөөх өрх	61-80 оноотой
3	Хөгжлийг дэмжигч өрх	81-90 оноотой
4	Хөгжлийг бүтээгч өрх	91-ээс дээш оноотой

Жишээлбэл, нэг өрхийн хувьд дээрх аргачлалын дагуу ерөнхий үнэлгээг гаргая. Уг өрх тав хүртэлх насны хүүхэдгүй гэж үзвэл:

Хүснэгт 4: Зорилтот өрхийн үнэлгээний жишээ тооцоо

	Эрэлт хэрэгцээний түвшин	Нийт үзүүлэлтийн тоо	Өрхөд хамааралтай үзүүлэлтийн тоо	Үүнээс:			Үнэлгээний дундаж утга
				Хангалттай "3"	Дунд зэрэг "2"	Хангалтгүй "1"	
1	Үндсэн хэрэгцээ	16	16	1	6	9	1.50
	А Орон байр	7	7	1	3	3	1.71
	Б Хоол хүнс, хэрэглээ	4	4	0	2	2	1.50
	В Санхүү, ажил эрхлэлт	5	5	0	1	4	1.20
2	Чадавх, боломж	15	14	1	9	4	1.79
	Г Эрүүл мэнд	5	4	0	2	2	1.50
	Д Боловсрол, технологи	5	5	1	3	1	2.00
	Е Нийгмийн хамгаалал	5	5	0	4	1	1.80
3	Ёс суртахуун, хүндлэл	7	7	0	2	5	1.29
	Ё Гэр бүл, нийгмийн харилцаа	7	7	0	2	5	1.29
НИЙТ		38	37	2	17	18	
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		Үнэлгээний дундаж утга			1.57 буюу Хангалтгүй		
		Хөгжлийн түвшин үнэлэх оноо			52.25 буюу Заавал хөгжих өрх		

Хөгжлийн зорилго, зорилт дэвшүүлэх: Нийгмийн ажилтан өрх бүртэй хамтран, үнэлгээний дүнд тулгуурлан, тухайн өрхийн 3-5 жилийн хугацааны хөгжлийн зорилго, зорилт, түүнд хүрэх боломж, давуу, сул тал, аюул занал, сорилтуудыг тодорхойлно.

Зорилтот өрхийн хөгжлийн зорилго бол урт хугацааны туршид тухайн өрхийн хүрэхийг тэмүүлж буй үр дүн буюу ахиц дэвшил юм. Эдгээр өрхийн хувьд амьжиргаагаа дээшлүүлж, амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр орлоготой болох нь нийтлэг зорилго байж болох юм.

Зорилт бол энэхүү зорилгодоо хүрэхийн тулд ойрын ирээдүй (дунд хугацаа буюу 1-2 жил)-д төлөвлөн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүнд гарах үр дагавар буюу үр нөлөө юм. Зорилт нь хэд хэд байж болох ба тухайн өрхөд тулгамдсан буюу бага үнэлгээтэй асуудал тус бүрийн хувьд дээшлүүлэх, ахиулах зорилт дэвшүүлэх шаардлагагүй. Ойрын хугацаанд хэрэгжих боломжтой, амьжиргаанд хамгийн их нөлөөлөхүйц 3-4 асуудлыг сонгон авах нь зүйтэй.

Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах: Өрхийн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлсны дараа нийгмийн ажилтан өрхийн гишүүдтэй хамтран хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна. Өрхийн хөгжлийн төлөвлөгөө

боловсруулах ажлын зорилго нь зорилтот өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, чадавхийг нь өрхийн гишүүдийн оролцоотой тодорхойлж, хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой хөгжлийн төлөвлөгөөг хамтран боловсруулах замаар тухайн өрхийн амьжиргааг сайжруулах юм.

Төлөвлөгөөг боловсруулахын тулд тухайн өрхийн хөгжлийг зөвхөн эдийн засаг, орлого талаас нь бус нийгмийн харилцаа, хүний чадавх болон оролцооны байдлаар тодорхойлох хэрэгтэй юм. Орлогын талаас нь хүний наад захын хэрэгцээ хангагдсан байдлыг авч үздэг бол хүний хувийн чадавх талаас нь унших, бичих, урт удаан, эрүүл энх амьдрах зэрэг ойлголт багтдаг. Харин нийгмийн харилцааны талаас тухайн хувь хүн өөртөө байгаа боломж, нөөцийнхөө хүрээнд үйл ажиллагаа явуулах, нийгмийн амьдралд хувь нэмрээ оруулах, үзэл бодлоо илэрхийлэх чадварыг авч үздэг.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг ийнхүү олон талаас нь харж боловсруулснаар зорилтот өрхийн гишүүдийн бэлэнчлэх, идэвхгүй сэтгэлгээг өөрчлөх, тэдэнд эерэг дадал хэвшлийг төлөвшүүлэх, ядууралд хүргэж буй шалтгааныг арилгах зэрэг ач холбогдолтой.

Зорилтот өрхийн гишүүдийг өрхийн амьжиргааг үнэлэх сургалт-семинарт оролцсоны дараа нийгмийн ажилтан өрх бүрт хүрэлцэн очиж, сургалтын үеэр хийсэн үнэлгээг баталгаажуулан, хөгжлийн төлөвлөгөөг тухайн сонгосон өрхийн гишүүдтэй хамтран боловсруулна. Төлөвлөгөөг боловсруулахад өрхийн гишүүд голлох үүрэгтэй оролцох ба нийгмийн ажилтан түүнд тусална.

Өрх бүрийн хөгжлийн төлөвлөгөө нь дээр тодорхойлсон зорилго, зорилтоос гадна дараах үзүүлэлттэй:

- Үйл ажиллагаа: Энэ нь дээр тодорхойлсон зорилго, зорилтод хүрэх арга зам байна. Үйл ажиллагаа нь хэд ч байж болох хэдий ч хэт олон байх нь оновчтой биш болохыг анхаараарай. Өрхийн гишүүдээс чухам хэн хэнийг тухайн үйл ажиллагаанд хамруулахаа нэр зааж оруулбал төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэлэх, улмаар сум/хорооны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулахад ач холбогдолтой.
- Хугацаа: Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусгах эцсийн хугацааг бичих нь оновчтой. Байнга хэрэгжүүлэхээр бол “Жилийн турш”, тодорхой хугацааг хамрах бол сар, улирлаа бичих хэрэгтэй.
- Хариуцах эзэн: Тухайн үйл ажиллагааг хэн хэрэгжүүлэхийг нэр зааж оруулна. Энэхүү төлөвлөгөө нь нэгэнт тухайн өрхийг хөгжүүлэхэд чиглэсэн учир өрхийн гишүүдийг аль болох түлхүү оруулах нь зүйтэй юм.
- Санхүүгийн эх үүсвэр: Бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хөрөнгө, санхүү шаардлагагүй юм. Тухайлбал, өрхийн гишүүдийн дадал хэвшил, зан үйлийг өөрчлөх, төрөөс үнэгүй үзүүлдэг үйлчилгээнд хамруулах зэрэгт хөрөнгө мөнгө зарцуулахгүй. Харин амьдрах орчин, ариун цэврийн байгууламжаа сайжруулах, өрхийн аж ахуй, үйлдвэрлэл эрхлэх, зарим төлбөртэй эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдах зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн бол хөрөнгийн эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэхээ заавал тусгана.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах санхүүжилтийг тухайн

орон нутгийн төсөвт тусгуулах³ асуудлыг сум/дүүргийн Засаг дарга, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нийгмийн ажилтнууд хариуцна. Шаардлагатай бол тусгайлсан хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлж болно.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх: Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь өрх, өрхийн гишүүд өөрсдөө байх ба гишүүн бүр хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвх, санаачилгатай оролцоно.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сум/хороо, аймаг/дүүргийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдсан “Ажлын хэсэг буюу Хамтарсан баг” голлох үүрэг гүйцэтгэнэ. Хамтарсан баг нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж болно. Үүнд:

- сум/хорооны Засаг дарга
- нийгмийн (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн болон хөгжлийн) ажилтан
- тухайн баг/хорооны хамран сургах тойргийн сургуулийн менежер/нийгмийн ажилтан
- цэцэрлэгийн эрхлэгч
- албан бус боловсролын арга зүйч
- сум/хорооны эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгийн эмч/эрүүл мэндийн нийгмийн ажилтан
- цагдаагийн хэсгийн байцаагч
- багийн засаг дарга/хэсгийн ахлагч
- нийгмийн даатгал хариуцсан ажилтан
- сум/хорооны төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн зэрэг салбар дундын уялдаа холбоог хангахуйц төлөөлөл бүхий 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байж болно.

Мөн хэрэгжилтийг хангахад сум/хорооны удирдлага, холбогдох салбарын ажилтнууд идэвх санаачилгатай байж, төр, хувийн хэвшил, олон улсын болон донор байгууллагын хамтын ажиллагааг хангаж ажиллана.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх: Хөгжлийн төлөвлөгөө дэх үйл ажиллагаа бүрийн хэрэгжилтэд өрхийн гишүүд болоод нийгмийн ажилтан хяналт тавьж, ажиллана. Өрх нийгмийн ажилтантай хамтран, хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналтыг улирал тутам, харин хэрэгжилтийн үнэлгээг жилийн эцэст хийж, амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа болоод тохиолдсон бэрхшээл, тэдгээрийг даван туулсан арга зам, сургамжийн талаар тодорхойлж, дараагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана. Өөрөөр хэлбэл, хяналт-шинжилгээний дүнд үндэслэн хөгжлийн зорилт болоод төлөвлөсөн үйл ажиллагааг засварлан тодотгож

3 Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсөв боловсруулах журам”-ын дагуу Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу төсөвт байгууллага, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн санхүүжих улсын төсөвт байгууллагын төсвийн захирагч нар төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор сум/дүүргийн Засаг даргад хүргүүлдэг.

болно.

Нийгмийн ажилтан хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, өрхийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа хүчин чармайлт, оролцоог дүгнэнэ. Ингэж дүгнэснээр өрхийнхөө хөгжлийг ахиулахад идэвх санаачилга, манлайлалтай байсан өрх, гэр бүлүүдийг тодруулах, урамшуулах, бусдад туршлагыг нэвтрүүлэх, сургамжаас суралцах ач холбогдолтой.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тайлагнах: Нийгмийн ажилтан өрх бүрийн болоод сум/хорооны өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайлан, ахиц дэвшлийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ны дотор гаргаж, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь орон нутгийн хэмжээний тайланг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлнэ.

Тайланд хийсэн ажлыг тоочихоос илүү өрхийн хөгжлийн суурь буюу эхний үнэлгээ, эцсийн үнэлгээнээс хэрхэн өөрчлөгдсөнийг тооцож, түүнд нөлөөлсөн хүчин зүйлд дүгнэлт хийх хэрэгтэй.

Үүний тулд өрхийн суурь болон тайлант үеийн үнэлгээний дундаж утгуудыг харьцуулан, статистик шинжүүр (test)-ээр шинжиж, өөрчлөлт гарсан эсэхэд дүгнэлт өгнө. Хэрвээ статистик шинжүүрээр ач холбогдолтой (буюу $p < 0.05$ эсвэл $p < 0.001$) гэж үнэлэгдвэл өрхийн хувьд эрэлт хэрэгцээний түвшингээр болон асуудал бүрээр үнэлгээнд ахиц дэвшил гарсан гэж үзнэ.

Хүснэгт 5: Зорилтот өрхийн хөгжлийн ахиц, дэвшлийн жишээ тооцоо

	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний дундаж утга			Өөрчлөлт	
		Суурь үе	Тайлант үе	Статистик ач холбогдлын түвшин	Абсолют	Хувийн жингийн
1	ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ	1.50	2.06	0.002837**	+0.56	37.3%
	Орон байр	1.71	2.29	0.030020**	+0.58	33.9%
	Хоол хүнс, хэрэглээ	1.50	2.00	0.181690	+0.50	33.3%
	Санхүү, ажил эрхлэлт	1.20	1.80	0.070484***	+0.60	50.0%
2	ЧАДАВХ, БОЛОМЖ	1.79	2.36	0.075815***	+0.57	31.8%
	Эрүүл мэнд	1.60	2.40	0.070484***	+0.80	50.0%
	Боловсрол, технологи	2.00	2.25	0.391002	+0.25	12.5%
	Нийгмийн хамгаалал	1.80	2.40	0.070484***	+0.60	33.3%
3	ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ	1.29	2.00	0.008237**	0.71	55.0%
	Гэр бүл, нийгмийн харилцаа	1.29	2.00	0.008237**	0.71	55.0%
	ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ УТГА	1.57	2.16	0.000124*	+0.59	37.6%
	ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ОНОО	52.25	72.07	-	+19.82	37.9%

Тэмдэглэгээ: * бол $p < 0.001$ буюу 99 хувийн ач холбогдолтой, ** бол $p < 0.05$ буюу 95 хувийн ач холбогдолтой, *** бол $p < 0.10$ буюу 90 хувийн ач холбогдолтой утга гэж үзнэ.

Дээрх тооцооноос харахад, тухайн өрх түвшингээрээ “Заавал хөгжих өрх”-д суурь үнэлгээний үед хамрагдаж байсан бол тайлант үед “Хөгжлийн төлөөх өрх” болж хөгжлийн түвшин ахисан байна. Үзүүлэлтүүдийн хувьд, санхүү, ажил эрхлэлт болон боловсрол, технологи гэсэн асуудлын хувьд ахиц дэвшил гараагүй, харин бусад асуудлын хувьд ахиц гарсан гэж дүгнэнэ.

Өрхийн хөгжлийн ахиц дэвшлийн өөрчлөлтийг тодорхойлсны дараагаар эрэлт хэрэгцээний түвшин, шалгуур үзүүлэлт бүрээр “Ахиц дэвшил гарсан”, “Хэвээрээ байсан”, “Буурсан” гэж бүлэглэн, тайлбар дүгнэлтийг бичнэ. Мөн өрх бүрт танилцуулж, дараагийн төлөвлөгөө, үйл ажиллагаанд ашиглана.

Хоёр.

ЗОРИЛТОТ ӨРХИЙН
ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ХОЁР. ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өрхийн хөгжлийн үнэлгээнд нийт 38 шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар ашигласан:

1. Үндсэн хэрэгцээ-16	2. Чадавх боломж-15	3. Ёс суртахуун, хүндлэл-7
Орон байр-7 Хоол хүнс, хэрэглээ-4 Санхүү, ажил эрхлэлт-5	Эрүүл мэнд-5 Боловсрол, технологи-5 Нийгмийн хамгаалал-5	Гэр бүл, нийгмийн харилцаа-7

НЭГ. ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ

1. ОРОН СУУЦ, ГАЗАР ӨМЧЛӨЛ



А.Гэр байшингийн өмчлөл

Өрх бүр өөрийн гэсэн орон байрандаа халуун бүлээрээ, тав тухтай амьдрах эрхтэй билээ. Гэвч харамсалтай нь өрхийн хөгжил, амьжиргааны түвшний байдлаас болж, орон байрны янз бүрийн нөхцөлд амьдарч байна. 2014 онд Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд хамрагдсан 11.2 мянган өрхийн 70.4 хувь нь гэрт,

27.2 хувь нь байшинд, үлдсэн 2.4 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байсан байна. Өмчлөлийн хувьд 79.8 хувь нь өөрийн, 11.4 хувь нь бусдын байранд, 8.8 хувь нь түрээсийн орон гэрт амьдарч байсан байна.

Энэ үзүүлэлтийн хувьд амьдарч байгаа орон байрных нь өмчлөл талаас нь илүү анхаарах хэдий ч нөхцөл, чанар, ашиглалтын байдалд анхаарах хэрэгтэй. Асуудлыг ерөнхийд нь дараах байдлаар ойлгоно. Үүнд:


- Өөрийн эзэмшлийн гэдэгт өрхийн өөрөө барьсан, худалдаж авсан, хувьчилж авсан сууц хамаарна.
- Бусдын эзэмшлийн гэдэгт түрээстэй болон түрээсгүйгээр амьдарч байгаа бүгд орно.
- Сууцны зориулалтын бус/орон гэргүй гэдэгт хүн амьдрах зориулалтын бус байшин, түүний хэсэг буюу өрөө тасалгаа (зориулалтаараа аж ахуйн нэгж байгууллага байхаар зориулагдсан гэх мэт), вагончик, байшингийн дээвэр, хонгил, орц, дулааны шугам сүлжээ буюу траншейн, уул хад, гудамж зэрэгт амьдарч буй өрх, хүн амыг хамруулна.

Өөрийн эзэмшлийн хашаа, байшин, орон сууцыг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр та хөрөнгөө барьцаалах, зарах зэргээр эргэлтэд

оруулж, өрхийн эдийн засгаа сайжруулах боломжтой болно. Хашаа байшин, орон сууцыг хувийн өмчлөлд бүртгүүлэх дараах материалыг бүрдүүлэн Улсын бүртгэлийн байгууллагад хандана. Үүнд:

- Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /өргөдөлд хэдэн онд хэн барьж, бий болгосон, одоо хэдэн хүний хамтын өмч болох, эд хөрөнгийн хаяг, байршил, хэмжээ, үнийг тодорхой бичиж, гарын үсгээ зурсан байна/
- Газар эзэмших болон өмчлөх эрхийн гэрчилгээ эсхүл газар өмчлүүлэх шийдвэр, хянан баталгааны дүгнэлтийн хуулбар
- Кадастрын зураг /эх хувь/. Кадастрын зурагт бүртгүүлэх гэж буй эд хөрөнгө тусгагдсан байна.
- Өмчлөгчдийн иргэний үнэмлэх, насанд хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар
- Хашаа байшин, хувийн сууцыг 4 талаас нь бүтэн харагдуулж авсан фото зураг/A4 цаасан дээр нааж тайлбар бичих, нэг хашаанд 2 ба түүнээс дээш байшинтай бол нэг зурагт бүгдийг нь багтааж авах/
- Хашаа байшин, хувийн сууцны план зураг /талбайн хэмжээг тусгах/
- Тэмдэгтийн хураамж /эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,01 хувиар тооцох/
- Мэдүүлэг бөглөнө.

Мэдүүлэгт дээр дурьдсан нотлох баримтууд болон тэмдэгтийн хураамж тушаасан баримтыг хавсарган хүлээлгэн өгч, буцах хуудас /тасалбар/ авна. Мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 9 хоногт бүртгэнэ.



Б. Газар өмчлөл/эзэмшил

Монгол Улсын иргэн бүр хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээний болоод аж ахуйн зориулалтаар газар өмчлөх эрхтэй буюу тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг “Газар өмчлөх” гэж ойлгоно. Мөн иргэн өөрийн өмчилсөн газраа гэрээнд заасан зориулалт, нөхцөл,

болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд эзэмшүүлэх эсвэл ашиглуулах боломжтой. Өрх, иргэн хуулийн хүрээнд газрыг өмчлөх, эзэмших, ашиглах аль нэг зөвшөөрлийг авсан байх ёстой.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд зааснаар иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь түүний байршил, зориулалтаас хамааран дор дурдсан хэмжээтэй байна:

Хүснэгт 6. Иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ

	Иргэнд өмчлүүлэх газрын байршил	Хэмжээ /га/
1	Нийслэлд	0.07 хүртэл га
2	Аймгийн төвд	0.35 хүртэл га
3	Сумын төв, тосгонд	0.5 хүртэл га
4	Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад/	0.07 хүртэл га

Иргэнд газрыг дараахь зориулалтаар өмчлүүлнэ:

- гэр бүлийн хэрэгцээний;
- аж ахуйн зориулалтаар.

Иргэнд дараах газрыг эзэмшүүлнэ:

- газар тариалангийнхаас бусад зориулалтаар хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэрийн газар /гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг/, бэлчээр, ойн болон усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар, зам, шугам сүлжээний газраас бусад газарт ;
- газар тариалангийн талбай болон атаршсан газарт.

Иргэн, хуулийн этгээд нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас батлагдсан загварын дагуу дараах тохиолдолд өргөдөл гаргаж, холбогдох бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

а. Шинээр газар эзэмших, ашиглах бол

- иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- эзэмших, ашиглах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, байршил, зааг, хэмжээ зэргийг тусгасан нэгж талбарын тойм зураг;
- хамтран эзэмшигч, ашиглагчдын иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын тодорхойлолт /гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тохиолдолд/.

б. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх бол

- газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ /эх хувиар/;
- газар эзэмших, ашиглах гэрээ /эх хувиар/;
- кадастрын зураг /эх хувиар/;
- газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/;
- газрын төлбөр төлсөн тухай баримт;
- талуудын иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- газар эзэмших эрх шилжүүлэх тухай нотариатаар гэрчлүүлсэн гэрээ /хэрэв тухайн нэгж талбарыг хамтран эзэмшдэг бол хамтран эзэмшигчдийн

зөвшөөрлийг гэрээнд тусгасан байна/;

- хэрэв хамтран эзэмшигчид байгаа бол тэдгээрийн иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- хэрэв эзэмшиж буй газраа бусдад хэсэгчлэн шилжүүлж байгаа бол кадастрын зургийн хуулбар дээр зай хэмжээг тавьсан тойм зураг.

в. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах;

- газар эзэмших эрхийн гэрчилгээ /эх хувиар/;
- талуудын иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- газрын төлбөр төлсөн тухай баримт;
- хэрэв тухайн нэгж талбарыг хамтран эзэмшдэг бол хамтран эзэмшигчдийн зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.

г. Газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгах бол

- иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ /эх хувиар/;
- газар эзэмших, ашиглах гэрээ /эх хувиар/;
- кадастрын зураг /эх хувиар/;
- газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт /эх хувиар/;
- газрын төлбөр төлсөн тухай баримт;

д. Газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгах, газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах бол

- иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн хуулбар;
- газрын төлбөр төлсөн тухай баримт;
- үрэгдүүлснийг нотлох баримт;
- эрхийн гэрчилгээний үнэ төлсөн баримт.

Дээрх гэрчилгээг улсын бүртгэлд бүртгүүлснээр худалдах, барьцаалах зэргээр эдийн засгийн эргэлтэд орох боломж бүрдэнэ.

Газар өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материал:

- Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /өргөдөлд тухайн газрын хаяг, хэмжээ, үнэ, нэгж талбарын дугаар, хэдэн хүн хамтран өмчилдөг тухай тодорхой бичиж гарын үсгээ зурсан байна/;
- Газар өмчлүүлэх тухай шийдвэр /эх хувь/;
- Хянан баталгааны дүгнэлтийн хуулбар;
- Кадастрын зураг /эх хувь/;
- Өмчлөгчдийн иргэний үнэмлэх, насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээний хуулбар;
- Үйлчилгээний хураамж /үнэ төлбөргүй/;
- Мэдүүлэг бөглөнө.

Мэдүүлэгт дээр дурдсан нотлох баримтуудыг хавсарган хүлээлгэн өгч, буцах хуудас /тасалбар/ авна. Мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 9 хоногт бүртгэнэ.

Газрын талаарх түгээмэл асуулт, хариулт

Асуулт 1. Баянгол дүүрэгт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрын нөөц байхгүй гэсэн. Бусад дүүргүүдэд хандахад өөр дүүргийн иргэдийн хүсэлтийг хүлээн авахгүй гэх юм. Энэ зөв үү?

Хариулт: Та нийслэлд иргэний бүртгэлтэй тохиолдолд аль ч дүүргийн нутаг дэвсгэрт газар өмчлөх хүсэлтээ гаргаж болох бөгөөд тухайн дүүргийн газрын алба нь харьяаллын бус гэсэн үндэслэлээр татгалзах үндэслэлгүй юм.

Асуулт 2. Ах дүү, хамаатан саднаараа шинээр өмчлүүлэх газарт нэг дор газар өмчлөн авч болох уу?

Хариулт: Хуулиар хязгаарласан, хориглосон хэм хэмжээ байхгүй тул боломжтой. Харин ийнхүү сонголт хийх бодит боломж өмчлүүлэх газрын нөөцөөс ихээхэн хамаарна.

Асуулт 3. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг л удаа газрыг үнэгүй өмчлүүлнэ гэж байгаа. Гэтэл өөр аймаг, суманд газар өмчлөн авсан эсэхийг хэрхэн хянах вэ?

Хариулт: Газрын үндэсний мэдээллийн сан байгуулагдаж, цахим сүлжээний тусламжтайгаар хэн, хаана, хэдий хэмжээний газар өмчлөн авсан болохыг аль ч аймаг, нийслэл, дүүргийн газрын алба иргэний бүртгэлийн гол баримт болох регистрийн дугаарыг үндэслэн хянах боломжтой учир олон удаа газар үнэгүй өмчлөн авах боломжгүй юм.

Асуулт 4. Гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд үнэгүй эзэмшүүлэх хүнсний ногоо тарих 0.1 хүртэлх га газар хашааны газартай нь зэргэлдээ байж болох уу. Мөн энэ газраа иргэн өмчлөн авах боломжтой юу?

Хариулт: Газрын тухай хуулийн 29.5-д заасны дагуу тухайн сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан тохиолдолд хашааны газартайгаа зэргэлдээ байж болно. Мөн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд өмчлүүлж болохоор тусгагдсан тохиолдолд иргэд хүсвэл зохих үнээр нь өмчлөн авч болно.

Асуулт 5. Аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрын дээд хэмжээг тогтоосон гэсэн. Энэ нь ямар хэмжээтэй байдаг юм бэ? Энэ хэмжээнээс илүү бол хэрхэх вэ?

Хариулт: Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор дээрх хэмжээг дараахь байдлаар тогтоосон. Үүнд: аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын дээд хэмжээ (га-гаар) Эзэмшүүлэх газрын ашиглалтын зориулалт /Аймагт, Улаанбаатар бүс/ 1. Үр тариа, тэжээлийн ургамал тариалах 3000 хүртэл 200 хүртэл 2. Төмс, хүнсний ногоо, бусад ургамал тариалах 50 хүртэл 5 хүртэл 3. Байгалийн хадлан бэлтгэлийг дагнан эрхлэх 1500 хүртэл 100 хүртэл 4. Дотоодын хэрэгцээндээ зориулан хадлан бэлтгэх 400 хүртэл 50 хүртэл 5. Хот, тосгон, бусад суурины газрын хилийн заагийн гаднах уурхайн эдэлбэр ашиглагчдад эзэмшүүлэх газрын хэмжээ 5000 хүртэл 6. Хот, тосгон, бусад суурины газрын хилийн заагийн доторх уурхайн эдэлбэр ашиглагчдад эзэмшүүлэх газрын хэмжээ 25.0 хүртэл. Эдгээр хэмжээнээс илүү гарган эзэмшиж байгаа газрыг дахин хуваарилалтад хамруулна.

Асуулт 6. Зуслангийн газраа өмчлөн авч болох уу?

Хариулт: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд иргэдэд өмчлүүлэхээр тусгагдсан тохиолдолд зөвхөн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх боломжтой. Нийслэлийн хувьд 2014 оноос эхэлж зуслангийн газар өмчлүүлэх үйл ажиллагааг зарим газруудад эхлүүлсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг www.umch.ub.gov.mn сайтаас аваарай.

Асуулт 7. Малчин өрх нь өвөлжөө, хаваржааныхаа газраа эзэмшихийн зэрэгцээ аймаг, сумын төвд хашааны газар өмчлөн авч болох уу?

Хариулт: Малчин өрх нь хот айлаар өвөлжөө, хаваржааныхаа газрыг дундаа хамтран эзэмшихийн зэрэгцээ тухайн аймаг, сумын төвдөө гэр бүлийн хамтын хэрэгцээндээ хуульд заасан хэмжээний газраа нэг удаа үнэгүй өмчлөн авах эрхтэй.

Асуулт 8. Манайх хөдөө багийн төвд хашаа, байшинтай юм. Газрыг нь өмчлөн авах боломжтой юу?

Хариулт: Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7.1-д гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршлыг тогтоохдоо хот суурин газруудад буюу нийслэл, аймгийн төв, сумын төв, тосгоны эдэлбэр газарт өмчлүүлэхээр тогтоосон байдаг. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар тосгон гэдэг нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг ойлгох тул танай багийн төв энэхүү шаардлагыг хангаж байгаа тохиолдолд та бүхэн саналаа сумын Засаг даргаараа уламжлуулан сумынхаа Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгуулсан тохиолдолд багийн төвд газар өмчлөн авах боломжтой.

Асуулт 9. Одоо эзэмшиж байгаа газар нь 0.07 га-гаас илүү бол дахин хуваарилалтад оруулна гэж үнэн үү?

Хариулт: Газар эзэмших, ашиглах эрх үүссэн бөгөөд аливаа зөрчилгүй, тогтвортой суурьшсан гэр хороололд байгаа хашааны газрын хэмжээ нь хуульд заасан 0.07 га-гаас 25 хувиас хэтрээгүй бол одоо эзэмшигчид нь үнээр нь худалдаж өмчлүүлэх, харин 25 хувиас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд хуульд заасан хэмжээний газрыг нь үнэгүй өмчлүүлж, бусад хэсгийг дахин хуваарилалтад хамруулж өмчлүүлэх газрын нөөцөд авах бодлогыг Засгийн газраас барьж байгаа болно.

Асуулт 10. Газрын байршил, газар доорх инженерийн шугам сүлжээтэй холбогдсон мэдээллийг хаанаас авах вэ?

Хариулт: Харьяалах аймаг, дүүргийн газрын албанаас үйлчилгээний зохих хураамж төлсний үндсэн дээр сонирхсон мэдээллээ зурагаар болон бусад хэлбэрээр гаргуулан авч болно.

Асуулт 11. Улаанбаатар хотын гэр хороололд хашааны газар эзэмшиж байгаа иргэдийн газрын хэмжээ нь ихэвчлэн 0.03 га байгаа. Иймд зөрүү болох 0.04 га-га өөр газраас өмчилж болох уу?

Хариулт: Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7.2-т Нийслэлд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын хэмжээ нь 0.07 га хүртэл байна гэж заасны зэрэгцээ хуулийн 5.1.4-т гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлнэ гэж заасан тул танд зөвхөн одоо эзэмшиж байгаа 0.03 га газрыг нэг л удаа өмчлүүлнэ. Харин та хүсвэл эзэмшиж байсан 0.03 га газраа хүлээлгэн өгч, улмаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэдэд өмчлүүлэхээр тусгагдсан, бусдын эзэмших эрх үүсээгүй газраас 0.07 га-даа хүргэн газар өмчлөн авч болно.

Эх сурвалж: фэйсбүүк хуудас Land Owner LLC / Ланд Овнер ХХК

Үнэлгээ хийхэд анхаарах асуудал:

- Хэрвээ өрхийн тэргүүлэгч эсвэл насанд хүрсэн хэн нэг гишүүн дээрх зориулалтын аль нэг хэлбэрээр газар өмчилж авсан бол “Өрх газар өмчилж авсан, зориулалтын дагуу бүрэн ашигладаг” гэж тооцно. Өмчилсөн газраа бусдад гэрээгээр эзэмшүүлдэг эсвэл ашиглуулдаг байж болно
- Өрхийн тэргүүлэгч эсвэл насанд хүрсэн хэн нэг гишүүн өмчилсөн газартай боловч зориулалтын дагуу огт ашигладаггүй бол энэ ангилалд хамаарна. Хэрэв өрхийн тэргүүлэгч эсвэл насанд хүрсэн хэн нэг гишүүн өмчилсөн газаргүй боловч хуулиар зөвшөөрсөн хүрээнд эзэмшдэг/ашигладаг газартай бол энэ хэсэгт хамааруулна.
- Тухайн өрхийн гишүүдээс газар өмчилсөн нэг ч хүн байхгүй бөгөөд мөн хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд газар эзэмшдэг нэг ч гишүүн байхгүй бол “Өрх өмчилсөн/эзэмшдэг газаргүй” ангилалд хамрагдана.

Дараах асуултаар үнэлгээг хийнэ. Үүнд:


А. Гэр байшингийн өмчлөл

- Өөрийн эзэмшлийн гэр, байшинд амьдардаг бол 3
- Бусдын эзэмшлийн гэр, байшинд/айлд амьдардаг бол 2
- Сууцны зориулалтын бус гэр, байшинд амьдардаг/орон гэргүй бол 1 гэж үнэлнэ.

Б. Газар өмчлөл, эзэмшил

- Өрх газар өмчилж авсан, зориулалтын дагуу бүрэн ашигладаг бол 3
- Өрх өмчилсөн газартай, гэхдээ зориулалтын дагуу ашигладаггүй бол 2
- Өрх өмчилсөн болон эзэмшдэг газаргүй бол 1 гэж үнэлнэ.

2. ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ



А. Ариун цэврийн байгууламж (бие засах газар, бохир усны цооног, хог хаягдлын сав, зориулалтын гар угаагуур)

• Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай гэдэгт ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдсон, эсвэл битүү тунгаагуур болон соруулдаг бохир усны цооногийн аль нэгийг байрлуулсан бөгөөд агааржуулагчтай нүхэн эсвэл био жорлон,

зориулалтын гар угаалтуур, хог хаягдлын савтай байхыг хэлнэ.

- Шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжид энгийн нүхэн жорлон, хээрийн нөхцөл, нийтийн нүхэн жорлон, бохир усны цооногийг хамруулж ойлгоно. Энэ тохиолдолд өнгө үзэмж сайтай, халдваргүйжүүлэлт тогтмол хийдэг, ялаа орохоос хамгаалсан тортой, гэрэлтүүлэгтэй, хогийн сав байрлуулсан, шал гишгүүрийг тогтмол угааж цэвэрлэдэг, хаалгатай, элдэв хог хаягдал хийгээгүй байхыг шаардана.

Хэрвээ өрх төвлөрсөн усан хангамж бүхий орон сууцанд амьдардаг бол үнэлгээ хийхгүй байж болно.

Үндэсний статистикийн хорооны 2013 оны судалгаагаар Монгол Улсын нийт хүн амын 27 хувь нь шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хэрэглэж чадахгүй байгаа дүн гарчээ. Хөдөө орон нутагт нийт хүн амын 25 хувь нь ариун цэврийн байгууламжгүй учраас «Нүхэн жорлон, муу усны цооног»-ын техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг 2016 оноос мөрдөж эхэлсэн байна.

Уг стандартыг төвлөрсөн болон бие даасан ариутгах татуургын системд холбох боломжгүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын ахуйн хэрэгцээнд хэрэглэх зориулалттай нүхэн жорлон, угаадасны нүхний зураг төсөл зохиох, барьж ашиглах, хяналт тавихад мөрдөнө. Уг стандартад дараах тодорхойлолтыг хэрэглэсэн байна. Үүнд:

Жорлон, угаадасны нүхийг хэрэглэгчийн зориулалтаар нь

- Насанд хүрэгчид
- Хүүхэд
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настанд зориулсан бүхээгтэй гэж ангилж байна.

Стандартад эрүүл ахуйн болон хүрээлэн буй орчин, галын аюулгүйн шаардлагыг тусгайлан заасан. Тухайлбал, хүрээлэн буй орчны шаардлагад “нүхэн жорлон, угаадасны нүх ашиглагч, эзэмшигч нь тэдгээрийн ашиглалтын явцад ил задгай болон газрын доорх усны эх үүсвэр, хөрс, агаарыг бохирдуулахгүй байх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгаль орчинг хамгаалах нөхцлийг хангахаар төлөвлөж, байгуулж ашиглана” гэж заасан.

Ус татуургын бие засах газар

- Бохир ус зайлуулах шугам руу урсдаг гэдэгт хүний ялгадас, бохир ус зэргийг цуглуулан, гадагшлуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам хоолойны системд холбогдсон бие засах газрыг хамруулна.

Энэ систем нь бохирыг цуглуулах, шахуургадах, ариутгах, ялгадас бохирыг устгах зориулалттай байгууламжуудаас бүрдэнэ.

- Битүү тунгаагуур руу урсдаг гэдэгт жорлон болон гэрээс хол, газар дор байрлуулсан, ус нэвтэрдэггүй ялгадас, бохирыг хуримтлуулах савтай бохирын хоолойгоор холбогдсон бие засах газрыг ойлгоно. Бохир усан дахь үл уусах хольц болон шимт бодисыг агааргүй орчинд бактерийн тусламжтайгаар эрдэсжүүлэн тунгаах замаар бохир уснаас ялгах тунгаагуур юм. Тунасан лагийг үе үе юүлж цэвэрлэнэ.
- Нүхэн жорлон руу урсдаг гэдэгт бохирын хоолойтой бөгөөд бохирыг ус татуургаар цэвэрлэн газарт ухсан нүх рүү урсгадаг бие засах газрыг ойлгоно.
- Тодорхойгүй газарт гэдэгт бохирыг ус татуургаар урсгаж цэвэрлэдэг бие засах газартай боловч хаашаа урсдаг нь тодорхойгүй/мэдэхгүй байвал үүнд хамааруулна.

Нүхэн жорлон

- Нүхэн жорлон: тав тухтай орчинд бие засах зориулалт бүхий хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн, шингэн ялгадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулах шаардлага хангасан хийц бүхий байгууламж
- Хагас нэвчилтэй жорлон, угаадасны нүх: энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн шингэн ялгадас болон ахуйн хэрэглээнээс ялгарсан бохир угаадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулан нэг удаа ашиглах шаардлага хангасан хийц бүхий байгууламж
- Нэвчилтгүй жорлон, угаадасны нүх: хүчитгэсэн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд хүний өтгөн шингэн ялгадас болон ахуйн хэрэглээнээс ялгарсан бохир угаадсыг цуглуулах, хуримтлуулж зайлуулан давтан ашиглах шаардлага хангасан хийц бүхий байгууламж

Био жорлонд нүүрстөрөгчөөр баялаг материал (хүнсний ногооны хаягдал, сүрэл, өвс, үртэс, үнс) ашиглан хүний өтгөн ялгадсаар үнэргүй, гэм хоргүй бордоо хийх хуурай бие засах газрыг оруулна. Энд зөөж авч явдаг болон суурин зориулалттай жорлонг аль алиныг хамруулна.

Хээрийн нөхцөл гэдэгт ялгадсыг шороогоор булах, эсвэл мод бутан дотор, талд эсвэл суваг шуудуунд бие засдаг тохиолдлыг хамруулна.

Задгай нүх гэдэгт тавцан, гишгүүр, суултуургүй, ялгадас хуримтлуулах энгийн ухсан нүхийг хамруулна (халхавчтай).

Бие засах газар, бохир усны нүхийг гэр, сууцнаас аль болох хол зайд, орон сууц, нийтийн байр, үйлчилгээний газраас 15 метр, ус түгээх цэгийн байрнаас 20 метр, уурхайн болон өрөмдмөл худгаас 150-250 метр, голын эргээс 200-250 метрээс багагүй зайд, татмын гадна ноёлох салхины доод талд барьж ашиглана.

Бие засах газарт тавигдах шаардлага

- Жорлонгийн бүхээгийг ариутгаж, цэвэрлэх боломжтой, ус чийгэнд тэсвэртэй, өвчин үүсгэх мөөгөнцөр, нян бактер, хортон шавж үржихгүй, гэрлийн тусгалаас хамгаалагдсан материалаар доторлосон байх

- Жорлонгийн бүхээг дотор ариутгал цэвэрлэгээний зөвшөөрөгдсөн бодис ба хэрэгслүүдийг бага насны хүүхдийн гар хүрэхгүй газар тавьсан байх
- Үнэргүй, аюулгүй, шал хана нь завсаргүй байх
- Агааржуулагч яндантай байх
- Хаалга бариул, цоожтой байх,
- Хогийн сав, ариун цэврийн цаас тавих
- Тогтмол цэвэрлэж, 7 хоног тутам ариутгаж байх

Угаадасны нүхэнд тавигдах шаардлага

Угаадасны нүх гэж хүчитгэсэн болон энгийн доторлогоотой, тооцоолсон эзлэхүүнтэй нүхэнд ахуйн хэрэглээнээс гарсан бохир угаадсыг хуримтлуулах, зайлуулах, шаардлага хангасан хийц бүхий байгууламжийг хэлнэ.

- Хог шүүх тор, бохир ус соруулах, ухаж лайдахад зориулсан бариул бүхий таглаатай байна.
- Агааржуулалтын 0.5-1.0 метр өндөр яндантай байх, бие засах газрын ойролцоо тусад нь байрлуулна.
- Нүхний ханыг бетон, тоосго, магниум хавтан, чулуу зэрэг ус чийгнээс хамгаалах, стандартын шаардлага хангасан тусгаарлагч материалаар доторлоно.
- Угаадасны нүхний хэмжээ нь урт нь 3.0 м, өргөн нь 2.5 м, гүн нь 3.0 м-ээс багагүй хэмжээтэй байх хэрэгтэй.

Стандартыг хэрэгжүүлэх хүрээнд дараах 4 төрлийн жорлонгийн загварыг баталсан байна. Үүнд:

- агааржуулагчтай сайжруулсан нүхэн
- бага хэмжээний усаар зайлуулах
- бордоожуулах
- хуурайшуулах жорлон багтаж байгаа аж.

Эдгээр дөрвөн төрлийн жорлон соруулдаг бөгөөд бохирыг хөрсөнд нэвчүүлдэггүй учраас хөрсний бохирдлыг бууруулах бүрэн боломжтой аж.

Жорлонгийн өртгийн хувьд барилгын материалаас шалтгаалан 800,000 төгрөгөөс дээш үнэтэй. Ариун цэврийн байгууламж, орчин нөхцөл муу байгаагаас халдварт шар өвчин их гардаг учраас айл өрх бүр хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалъя гэвэл шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хэрэглэхийг мэргэжилтнүүд зөвлөж байна

Хуурайшуулах жорлон нь ялгадсыг суурийн 2 тасалгаанд ээлжлэн хурааж, агааржуулалт болон үртэс, үнс гэх мэт нэмэлт хуурай бодисын тусламжтайгаар угсгуйжүүлж, хатаах технологитой.

- Суурийн эхний тасалгаа нь ялгадсаар дүүрэх үед суултуурын нүхийг сайтар таглан орхиж, нөгөө тасалгааг ашиглана.
- Хоёр дахь тасалгааг дүүрэх үед эхний тасалгаан дахь ялгадас хатаж хуурайшсан байна. Үүнийг суллаж аваад тухайн тасалгааг дахин ашиглаж эхэлнэ. Энэ маягаар ээлжлэн удаан хугацаагаар ашиглана.
- Нүх ухах боломжгүй буюу чулуутай, намагтай зэрэг газар ашиглахад илүү тохиромжтой.
- Угаадас, элдэв хог хаягдал хийхийг хориглоно.
- Зүй зохистой хэрэглэхийн тулд мэдлэг дадал шаардлагатай.

Агааржуулагчтай нүхэн жорлон нь хоолойтой, хөрсний нөхцлөөс хамааран нүхийг энгийн болон хүчитгэж доторлосон ариун цэврийн байгууламж юм.

- Материалын олдоц сайн, барихад хялбар
- Энгийн жорлонтой харьцуулахад үнэр, ялаа эрс бага
- Уламжлалт жорлонтой адил тул хэрэглээ, үйлчилгээ энгийн
- Бүхээгийн эргэн тойронд хаяавч хийх нь нүх рүү бороо, үерийн ус орохоос сэргийлнэ.
- Жорлонгийн дотор хана, шалыг тогтмол угааж цэвэрлэнэ.

Бордоожуулах жорлон нь ялгадсыг үртэс, сүрэл зэрэг нүүрстөрөгчөөр баялаг материалтай хольж ялзруулан үнэргүй, аюулгүй бордоо болгодог жорлон юм.

- Бүхээгт жижиг ширхэгтэй органик материал (үртэс, хар шороо гэх мэт) хийсэн хувинг байрлуулж, бие зассаны дараа ялгадсыг хучиж өгнө.
- Өтгөн шингэнийг тусгаарлах суултууртай тул өтгөн хураах хэсэгт шээхгүй, угаадас хийхгүй байх
- Төрөл бүрийн химийн бодистой ус нь ялгадас задрах явцыг удаашруулдаг тул суултуурыг зөвхөн усаар цэвэрлэх
- Өтгөнийг задралд оруулж, бордоо болгох тул элдэв хог хаягдалтай холихгүй байх
- Өтгөн хураах сав дүүрсний дараа суллах үйлчилгээнд хамрагдаж, ялгадсыг зайлуулна. Энэ үйлчилгээнд тодорхой зардал гарна.
- Айл өрх өөрсдөө бордоо хийхгүй, зөвхөн нэгдсэн үйлдвэрт бордоо хийнэ.
- Хөрс бохирдуулахгүй, үнэргүй, цэвэр тохилог.

Бага хэмжээний усаар зайлуулах жорлон нь ялгадсыг усан хаалт бүхий суултуураас усны урсгалаар хөөх зарчмаар ажилладаг. Усны хэрэглээгээр нь нэг удаад 2-3 литр ус хэрэглэдэг зөөврийн устай, 4 литрээс их хэмжээний ус хэрэглэдэг гүрний худагтай холбогдсон гэж ангилна.

- Бүхээгийг байшин дотор байрлуулж болох тул тохилог
- Ялгадсыг усаар зайлуулах тул үнэргүй, цэвэрхэн
- Соруулах боломжтой тул дахин нүх ухах шаардлагагүй.

Эх үүсвэр: Ариун цэврийн байгууламжийн төрлүүд, ЭМСЯ, WaSH, НҮБ-ын Хүүхдийн сан

Хог хаягдлын савд тавигдах шаардлага

- Хогийн савыг салхины чиглэлийн дор, гэр байшин, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метр зайд байрлуулах
- Гэрт буюу гадаа хогийн сав байрлуулах ба гэрт 5-10, хашаанд 80-120 литрийн багтаамжтай байх
- Хогийн сав нь тагтай, хуванцар, металл материалаар хийгдсэн байх
- Угааж цэвэрлэхэд хялбар байх, тагтай байх
- Хог хаягдлыг ангилж, хогийг 3 хоногоос илүү хугацаагаар хадгалахгүй байх

Гараа хэрхэн зөв угааж, арчих вэ?

- Зориулалтын гар угаалтуурт 1 минутаас доошгүй хугацаагаар гараа усаар сайн норгож, хөөсрүүлэн савандаж, гарын алга, ар, хуруу, хурууны завсар, үзүүрийг үрж угаасны дараа усаар сайн зайлаад, алчуураар хаттал нь сайн арчих бөгөөд алчуураа өдөр бүр угаана.

Бохир гараар дамждаг ямар ямар халдварууд байдаг вэ?

- Менингит, томуу, томуу төст өвчин, гуурсан хоолойн үрэвсэл, нүдний салст эвэрлэгийн үрэвсэл, халдварт саа, гепатит А,Е
- Суулгалт, амаар дамжих бүх халдварууд зэрэг болно

Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байхын тулд өрх ямар дадлыг хэвшүүлэх ёстой вэ?

- Бие засах газраа жил бүр сайжруулж байх, өнгө үзэмж муудахад будаж шохойдох
- Шал гишгүүрийг угааж цэвэрлэх тусгай шүүр, сойзтой байх
- Дулааны улиралд халдваргүйтлийг 14 хоног тутамд 1 удаа хийхдээ хлорын шохойн 10%-ийн цийдмэг уусмалыг ашиглах
- Ялаа орохоос хамгаалсан торыг сард нэг удаа шалгаж, солих
- Агаар чөлөөтэй нэвтрүүлэхийн тулд агааржуулагчийн яндангаар ус хийж, аалзны тор, ялааг арилгах
- Гэрэлтүүлэг хийж, хогийн сав байрлуулах
- Бие засах газрын хаалга, бохир усны таглааг байнга хаалттай байлгах
- Бие засах газар, бохир усны нүхэнд элдэв хог хаягдал (шил, лааз,

хуванцар) хийхгүй байх

Эрүүл ахуй ариун цэврийн шаардлага хангалтгүй байснаар ямар хортой вэ?

- Гэдэсний суулгалт өвчин, халдварт шар, арьс, нүд, шимэгч хорхойн өвчнүүд тархах
- Ахуйн орчин бохирдох



Б.Гэр, байшингийн аюул осол, гамшигт өртөхөөс урьдчилан сэргийлсэн байдал

Өрх гал түймэр, үер ус, хүчтэй салхи шуурга, осол гэмтлээс хамгаалагдсан байх ёстой. Хэрвээ өрх гэр хороололд амьдардаг бол оршин сууж буй газар нь суурьшлын бүс бүхий, өрх, хүн ам оршин суухыг зөвшөөрсөн газар байх хэрэгтэй. Суурьшлын бус газарт оршин суух нь

тухайн өрх, хүн амын аюул осол, гамшигт өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Орон сууцанд амьдардаг өрхийн хувьд ч болзошгүй аюул ослоос хамгаалагдсан байдлыг үнэлнэ.

Амьдарч буй орчин цэвэр, айх аюулгүй, тохилог байх нь хүн бүрийн эрүүл мэнд, хөгжилд нэн тустай. Амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд өрх бүрийн оролцоо чухал юм.

Өрх иргэн дараах байдлаар амьдрах аюулгүй орчныг бүрдүүлсэн байх ёстой.

Гал түймрийн аюулаас хэрхэн сэргийлж, хамгаалах вэ?

- Цахилгааны утас, монтажийг ил хийхгүй байх
- Шатах тэсрэх чанартай бодисыг гэрээсээ хол газар ухаж хадгалах, элс шороогоор далдлах
- Элс, ус болон гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах
- Гэр хашаа, байшингаа тойруулан газрын хөрсийг эргүүлэх
- Галтай зүйл хог хаягдлыг хогийн суваг, хогийн ил цэгт хаяхгүй байх
- Гэр орондоо зул, хүж асаахдаа галын аюулгүй байдлыг хангаж, хяналтгүй орхихгүй байх
- Шингэрүүлсэн шатдаг хийгээр ажилладаг тулга, зуухыг ашиглахдаа аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлан анхаарал болгоомжтой байх (шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах)
- Цахилгаан ашиглалтын дүрэм журмыг сайтар мөрдөж, эвдрэл гэмтэлтэй, зориулалтын бус цахилгаан хэрэгсэл ашиглахгүй байх
- Цахилгаан хэрэгслийг хүчдэлээс салгаж орхих
- Бага насны хүүхдийг харж асрах хүнгүйгээр гэрт нь цоожилж орхихгүй байх

Үер усны аюулаас хэрхэн хамгаалах вэ?

- Үер уснаас хамгаалах далан, суваг, хашлага барих
- Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг байнга сонсох
- Цас, шуурга, бороотой үед хүүхдийг гэрээс хол явуулахгүй байх
- Гэр, хашаа, саравч, орон байрыг үерийн усны зам, голын гольдрол, гуу, жалга, хуурай сайр, ус хальдаг эрэг, татамд барихгүй байх
- Хүүхдийг хараа хяналтгүйгээр гол мөрөн, нуур, цөөрмийн орчимд тоглуулахгүй, орхихгүй байх
- Чухал бичиг баримт, үнэт зүйлсээ үерийн усанд урсах, норхоос хамгаалсан найдвартай газар хадгалах, түүнийг гэр бүлийн гишүүд мэддэг байх
- Цэвэр ус болон хүнсний нөөц, дулаан хувцсыг усанд автахгааргүй орчинд хадгалах
- Гэнэтийн ослын болон эд хөрөнгийн даатгалд хамрагдах
- Өндөр хүчдэл, цахилгааны шугам дор гэр, сууцаа барихгүй байх

Өрх хүчтэй салхи шуурганаас хэрхэн хамгаалах вэ?

Хүчтэй салхи 30 м/секундээс дээш бол онц аюултай, 16-20 м/секунд хүрч 3 цагаас дээш хугацаагаар үргэлжилбэл аюултай үзэгдэлд тооцдог.

- Цаг агаарын урьдчилсан мэдээллийг байнга сонсож, хэрэгжүүлэх
- Хашаа саравч, худаг усыг дулаалж, өвс тэжээлийн нөөцийг бэлтгэх
- Хүчтэй салхи шуурганы үед айж сандралгүй ойр орчмын барилга байгууламж, далдлах газар орж, намдсан үед гарах
- Аюулт үзэгдлийн үед өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, аврах анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, дадлагатай болох
- Хоол хүнс, ундны ус, түлш, анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм тариа, ариун цэврийн хэрэглэл, дулаан хувцас бэлтгэх, гэр мэтийн хөнгөн сууцыг хүнд зүйлээр даруулах
- Өндөр хүчдэл, цахилгааны шугаман дор гэр, сууцаа барихгүй байх

Осол гэмтлээс хэрхэн хамгаалах вэ?

- Хүүхдэд галын аюул, хор хөнөөлийн талаар ойлголт өгч байх
- Хүүхдийг гал, цахилгаан зуух, чийдэн шүдэнз болон цахилгаан хэрэгсэл, разетка (залгуурын суурь)-аас хол байлгах
- Байрны шат, тагт, дээвэр, цонхноос хүүхэд унаж ойчих, гэмтэхээс хамгаалсан нөхцлийг бүрдүүлэх
- Хутга, хайч, үзүүртэй эд зүйлс болон хагархай шил зэргийг хүүхдийн гар хүрэх газраас хол байлгах
- Хорт бодисууд, эм зэргийг хүнсний саванд хадгалахгүй байх, тодорхой хаяглаж хүүхдийн гар хүрэх газраас хол байлгах
- Хүүхдийг гол, нуурын уснаас хол байлгах, усархаг бороотой үед голын усанд оруулахгүй байх
- Хүүхдийг авто замын ойр тоглуулахгүй байх, зам гарцаар болгоомжтой гарч байх зөвлөмжийг өгөх
- Онцгой байдал, нийтийг хамарсан халдварт өвчин тархсан үед хүүхдийг

олон нийтийн газар явуулахгүй байх

- Дулааныг хадгалах зорилгоор түлшний шаталтыг багасгахаар яндан пийшингийн хаалтыг хаах, пийшин зуухыг түлшээр дүүргэж түлэх, авто тээврийн хэрэгслийг асаалттай орхих зэргээс хүн угаартах аюултай тул онцгой анхаарах

Амьдрах орчин хүүхэд, гэр бүлд хэрхэн нөлөөлдөг вэ?

- Хог хаягдал овоолсон, задгай жорлонтой, золбин ноход үүрлэсэн газар нь хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг.
- Нүх жалга, дутуу барьсан барилга ойр орчимд байх нь хүүхэд гэмтэх аюултай байдаг.
- Тоглоомын талбай байхгүйн улмаас хүүхдүүд зам дээр тоглож осолд орох нөхцөл бүрддэг
- Насанд хүрэгчдийн архи, тамхины хэрэглээ, зүй бус авир нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг.
- Тэдний сөрөг зан үйл нь хүүхдүүдэд буруу үлгэр дуурайлал болдог.
- Гудамж, талбай гэрэлтүүлэггүй байх нь хулгай, дээрэм гарах нөхцлийг бүрдүүлж, хүмүүсийн аюулгүй байдалд муугаар нөлөөлдөг.

Иргэд олон нийт хамтарч үр хүүхдийнхээ сайн сайхны төлөө хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхийн тулд юу хийх вэ?

- Гудамж, талбай, хашаагаа цэвэрлэх, тохижуулах, хаягжуулах
- Гэрэлтүүлэгтэй болох, жалга, нүхийг битүүлэх, жижиг гүүр барих
- Хүүхдийн тоглоомын болон биеийн тамирын талбай байгуулах
- Хог хаягдлаа зайлуулах, архидалтын эсрэг аян хөдөлгөөн өрнүүлэх
- Хог хаягдлаа зайлуулах, зүлэгжүүлэх, мод тарих



В.Ундны усны сайжруулсан эх үүсвэр

Олон улсын аргачлал: Төвлөрсөн, төвлөрсөн бус системд холбогдсон сууцны хоолой болон нийтийн ус түгээх байр, гүний худаг, хамгаалагдсан энгийн худаг, хамгаалагдсан булаг, шанд, бороо, цасны ус эсвэл цэвэршүүлж савласан ус (зөвхөн цэвэршүүлж савласан усыг ундандаа хэрэглээд, ахуйн хэрэглээний усаа бусад сайжруулсан эх үүсвэрээс авдаг бол) зэргийг ундны усны сайжруулсан эх үүсвэрт тооцно.

Монгол Улсад мөрдөгдөж буй аргачлал: Төвлөрсөн, төвлөрсөн бус системд холбогдсон сууцны хоолой болон нийтийн ус түгээх байр, усыг зориулалтын машинаар тээвэрлэж авчирдаг нийтийн ус түгээх байр, гүний худаг, хамгаалагдсан энгийн худаг, хамгаалагдсан булаг, шанд, бороо, цасны ус эсвэл цэвэршүүлж савласан ус (зөвхөн цэвэршүүлж савласан усыг ундандаа хэрэглээд, ахуйн хэрэглээний усаа бусад сайжруулсан

эх үүсвэрээс авдаг бол) зэргийг ундны усны сайжруулсан эх үүсвэрт тооцно.

Ус нь юугаар ч сольшгүй байгалийн чухал эрдэнэ бөгөөд хүн усгүйгээр зөвхөн 5 хоног л тэсвэрлэж чадна. Ус хүний биед чухал хэрэгтэй бөгөөд хоногт 2 литрээс доошгүй хэмжээний цэвэр усыг ууж, хоногийнхоо хэрэгцээг хангадаг. Дэлхийн гадаргын 3/2 нь ус байдгийн нэгэн адил хүний биеийн 3/2 нь бас адил ус байдаг. Ус нь:

- Хүний биед орсон тэжээлийн бодисыг уусгагч гол орчин болдог
- Биеийн дулааны солилцоонд оролцдог
- Бодисын солилцооны дүнд үүссэн хорт бодисыг биеэс гадагшлуулдаг.

Ундны усны баталгаат эх үүсвэр гэж юуг ойлгодог вэ?

- Төвлөрсөн систем, хамгаалагдсан гол, нуур булаг шанд, гүний худаг, усан сангаас усаа татсан төвлөрсөн бус систем
- Хамгаалсан гол, нуур, булаг, шандын ус
- Гүний худаг,
- Усан сангийн ус
- Зориулалтын ус зөөх машинаар түгээж буй ус
- Савласан ус

Төвлөрсөн системд холбогдсон гэж төвлөрсөн системд холбогдсон усны шугам хоолойгоор гэрийн доторх гал тогоо, угаалгын өрөө зэрэг өрөөнүүдэд ус түгээдэг эх үүсвэрийг ойлгоно.

Төвлөрсөн бус системд холбогдсон гэж төвлөрсөн бус системд холбогдсон усны шугам хоолойгоор гэрийн доторх гал тогоо, угаалгын өрөө зэрэг өрөөнүүдэд ус түгээдэг эх үүсвэрийг ойлгоно.

Гүний худаг гэж газрын гүний усны нөөцөд хүрэхийн тулд гүнзгий өрөмдөж гаргасан худгийг ойлгоно. Гүний худгийг хийхдээ жижиг голчтой нүхний хажуу талын хөрс нурахаас болон гадаргын урсац нэвчихээс хамгаалж дотор нь суултын яндан суулгасан байдаг. Гүний худгаас усыг салхи, цахилгаан эрчим хүч, дизель түлш, нарны эрчим хүчний төхөөрөмж, эсвэл гар шахуургын тусламжтайгаар шахуургадан гаргадаг. Гүний худгийн нийтийн ус түгээх байрыг энд мөн хамааруулна.

Гар худгийг хамгаалагдсан, хамгаалагдаагүй гэж ялгана.

Хамгаалагдсан худагт гадаргын урсац худагт орохоос сэргийлж өндөрлөсөн, бетон бүүрэгтэй мал амьтан, хог унахаас хамгаалсан ам таглаа бүхий худгийг хамруулна.

Хамгаалагдаагүй худагт 1) гадаргын урсацаас, 2) мал, амьтан орохоос хамгаалаагүй худгийг оруулна. Дээрх хоёрын аль нэг нь байгаа бол уг худгийг хамгаалагдаагүй худаг гэж үзнэ.

Булгийг мөн хамгаалагдсан болон хамгаалагдаагүй гэж ангилна.

Хамгаалагдсан булагт булгийн эх ундарга нь тусгай хамгаалалтад байдаг, засч тохижуулан хашиж хамгаалсан, гадаргын урсац орохоос хамгаалж, тоосго болон бетон хийцээр битүүлсэн ус авах зориулалтын хоолойтой булаг, шандыг хамруулна.

Хамгаалагдаагүй булагт гадаргын урсац болон мал, амьтан орохоос хамгаалаагүй ил задгай буюу засч тохижуулсан хаалт хашлагагүй булаг, шандыг хамруулна.

Хурын ус гэж бороо, цасны усыг дээврээс тосч, сав, цистерн зэрэгт хадгалан хэрэглэдэг усыг ойлгоно.

Зөөврийн усны үйлчилгээ

Зөөврийн машины үйлчилгээнд эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж ус зөөх зориулалтын авто машинаар (цистерн) айл өрхөд зөөвөрлөн түгээдэг үйлчилгээг хамруулна.

Нийтийн ус түгээх байр гэж эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж ус зөөх зориулалтын авто машинаар (цистерн) ус түгээх байранд зөөвөрлөн түгээдэг үйлчилгээг хамруулна.

Ердийн хөсгөөрх зөөврийн ус гэж эрх бүхий байгууллага, хувийн аж ахуйн нэгж болон иргэд хувиараа (гэрээгээр) зориулалтын бус машин болон ердийн хөсгөөр айл өрхөд шууд зөөвөрлөдөг усыг ойлгоно.

Усны ил эх үүсвэр (гол мөрөн, нуур, тойром цөөрөм) гэж газрын гадаргуу дээрх гол горхи, нуур, тойром, цөөрөм, голын салаа болон тогтоол усыг хэрэглэх тохиолдлыг хамруулна.

Савласан ус гэдэгт аж ахуйн нэгж тусгай хяналт, зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн цэвэршүүлэн савласан ундны зориулалтаар бэлтгэгдсэн усыг ойлгоно.



Г.Ундны усны хадгалалт, хэрэглээ

Ундны усны хэрэглээ шаардлага хангасан гэдэгт усыг хоол, хүнсэндээ заавал шүүж юмуу буцалгаж хэрэглэх, амт, өнгө, үнэргүй, тунгалаг, бохирдоогүй, чанарын шаардлага хангасан устай, усыг халдваргүй болгох энгийн аргуудыг хэрэглэдэг тохиолдлыг оруулна.

Ундны усны хадгалалтын шаардлага хангасан гэдэгт худгийн орчмын хөрс цав цууралт үүсээгүй, хамгаалалтын бүс тогтоосон байх ба худаг заавал тагтай байх, усыг 3 хоногоос илүү хадгалдаггүй, усны сав хоргүй, зэвэрдэггүй, тагтай байх ба ус хутгах шанагыг тусад нь байлгадаг, усны савыг нарны тусгалаас зайдуу, ариун цэврийн байгууламжаас хол байрлуулсан байхыг хэлнэ.

Ундны усыг хэрхэн зөв хэрэглэх вэ?

- Усыг хоол, хүнсэндээ заавал шүүж юмуу буцалгаж хэрэглэх
- Амт, өнгө, үнэргүй, тунгалаг, бохирдоогүй, чанарын шаардлага хангасан усыг ундандаа хэрэглэх
- Усыг халдваргүй болгох энгийн аргуудыг хэрэглэх

Ундны усыг хадгалахад эрүүл ахуйн ямар шаардлагууд тавигддаг вэ?

- Худгийн орчмын хөрс цав цууралт үүсээгүй, хамгаалалтын бүс тогтоосон байх ба худаг заавал тагтай байх
- Усыг 3 хоногоос илүү хадгалахгүй байх
- Усны сав хоргүй, зэвэрдэггүй, тагтай байх ба ус хутгах шанагыг тусад нь байлгах
- Усны савыг нарны тусгалаас зайдуу, ариун цэврийн байгууламжаас хол байрлуулах


Хуванцар саванд **1,2 HDPE, 4 LDPE, PP** гэсэн тэмдэглэгээ байвал хүнсний зориулалттай хэрэглэж болно гэж мэргэжилтнүүд зөвлөдөг.

Гэрийн нөхцөлд ус цэвэршүүлэх ямар аргууд байдаг вэ?

- Буцалгах гэдэгт түлш, эрчим хүч хэрэглэн усыг буцалгах арга орно.
- Ариутгалын бодис хийх гэдэгт ариутгагч шингэн, эсвэл шахмал бодис (хлор) хийж ус цэвэршүүлэхийг ойлгоно.
- Даавуу, марлиар шүүх гэдэгт усыг даавуу, марлиар шүүж, бусад биетүүдийг ялгаж авахыг ойлгоно.
- Ус цэвэршүүлэгч хэрэглэх гэдэгт тусгай зориулалтын керамик, элс болон бусад зүйлээр хийсэн шалгахтай шүүгч, эсвэл тоног төхөөрөмжийг ашиглан усыг шүүж, янз бүрийн жижиг биетүүд, зарим микробоос цэвэрлэхийг ойлгоно.
- Нарны гэрлээр халдваргүйжүүлэх гэдэгт тунгалаг шилэн саванд усыг хийж наранд хэсэг хугацаанд байлгаж халдваргүйжүүлэхийг ойлгоно.
- Тунгаах гэдэгт савтай усыг хутгасны дараа тодорхой хугацаагаар хөдөлгөлгүй тавьж, доторх биетүүдийг ёроолд нь тунгаахыг ойлгоно.

Устай холбоотой үүсэх ямар өвчнүүд байдаг вэ ?

- Халдваргүй өвчнүүд болох шүд, элэг, бөөр, шээсний замын өвчин
- Халдварт өвчнүүд болох суулгалт, гэдэсний хижиг, цусан суулга, холер г.м



Д.Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр

Өрх төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон, албан ёсоор цахилгаан эрчим хүч ашиглах, хэрэглэх гэрээ хийсэн байх ёстой. Хөдөө орон нутгийн өрхийн хувьд нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй бол энэ ангилалд багтаана.

Өрх цахилгаан эрчим хүчний ямар ч эх үүсвэргүй бөгөөд хааяа цахилгаан эрчим хүчний суурин (хангагчийн) үүсгүүрээс хамааралгүй цахилгаан эрчим хүчээр тэжээх боломжтой үүсгүүр (жижиг оврын цахилгаан мотор гэх мэт)-ээс цахилгаан эрчим хүч хэрэглэдэг бол ямар нэг эх үүсвэргүй гэж үзнэ.

Цахилгаанд холбогдох нь өрхөд ямар давуу тайлтай вэ?

- Ахуйн хэрэгцээгээ хангах
- Сурах, хөгжих боломжийг бүрдүүлэх
- Эрүүл саруул аж төрөх

- Цахилгаан хэрэгслийг ашиглах

Цахилгааны хэрэглээнд юуг анхаарах хэрэгтэй вэ?

- Цахилгааны холболтыг мэргэжлийн хүнээр баталгаатай хийлгэх,
- Чанартай цахилгааны утас, залгуур, унтраалга хэрэглэж, галын аюулгүй байдлыг хангах
- Цахилгааны тоолуур тавиулж, хэрэглээгээ хянах
- Цахилгааныг хэмнэлттэй зөв хэрэглэхэд анхаарах
- Цахилгаан хэрэглэсэн төлбөрөө цаг тухайд нь төлж байх
- Хүүхдэд цахилгаан хэрэгсэлтэй зөв харьцах чадварыг эзэмшүүлэх
- Цахилгааны утас, хэрэгслийг бага насны хүүхдийн гараас хол тавих

Дараах байдлаар үнэлгээг хийнэ.

А. Ариун цэврийн байгууламж

- Эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэр, эмх цэгцтэй бол 3
- Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, гэхдээ эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц бус, цэвэр, эмх цэгцтэй бол 2
- Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц бохир, эмх цэгцгүй бол 1

Б. Гэр байшингийн аюул осол, гамшигт өртөхөөс урьдчилан сэргийлсэн байдал

- Аюул, осол, гамшгаас бүрэн хамгаалагдсан бол 3
- Аюул, осол, гамшгаас бүрэн хамгаалагдаж чадаагүй, гэхдээ эрсдэл бага бол 2
- Аюул, осол, гамшигт өртөх эрсдэлтэй бол 1

В. Ундны усны сайжруулсан эх үүсвэр

- Ундны усны сайжруулсан эх үүсвэртэй бол 3
- Ундны усны сайжруулсан эх үүсвэр 1 км-ээс хол бол 2
- Ундны усны шаардлага хангаагүй эх үүсвэртэй бол 1

Г. Ундны усны хадгалалт хэрэглээ

- Ундны усаа шаардлагын дагуу зөв хадгалж, хэрэглэдэг бол 3
- Ундны усны хадгалалт эсвэл хэрэглээ шаардлага хангадаггүй бол 2
- Ундны усны хадгалалт, хэрэглээ шаардлага хангадаггүй бол 1

Д. Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр

- Албан ёсоор төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон эсвэл нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй бол 3
- Албан бусаар төвлөрсөн эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон бол 2
- Эрчим хүчний ямар нэг эх үүсвэр байхгүй бол 1

Б. ХООЛ ХҮНС, ХЭРЭГЛЭЭ

3. ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ



А.Хоол хүнсний хангамж

Энд өрхийн хоол хүнсний хангамжийн талаарх сэтгэл ханамжийг үнэлнэ. Өрхийн хоол хүнсний хангамжиндаа хэр сэтгэл ханамжтай байгааг тэдний хэлснээр тэмдэглэн авна.

- Өрхийн хоол хүнсний хангамж гэж өрхийн гишүүн бүр хоногийн хэрэгцээт бүх төрлийн хүнсээр хангагдсан байдлыг хэлнэ. Хэрэгцээт бүх төрөл буюу үндсэн 5 бүлэг хүнс гэдэгт гурил будаа, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, сүү цагаан идээний бүлэг орно.

- Хоол хүнс нь хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт, хөгжил, илчлэгийн хэрэгцээг хангахуйц байх ёстой.
- Насанд хүрсэн, энгийн хөдөлмөр эрхлэгч хүн өдөрт дунджаар 2300-2800 ккал, биеийн хүчний хөдөлмөр эрхлэгч бол өдөрт дунджаар 2500-3200 ккал-ийг хоол хүнснээсээ авах ёстой.
- Хүүхдийн хоол хүнснээс авах илчлэгийн хэмжээ насны бүлгээр ялгаатай байдаг. Хэрэв хүүхэд 1-3 настай бол 1200 ккал, 4-6 настай бол 1600 ккал, 7-10 настай бол 2000 ккал, 11-14 настай бол 2100 ккал, 15-18 настай бол 2300 ккал илчлэг өдөрт авах ёстой.

НАСАНД ХҮРСЭН ХҮНИЙ ЗӨВ ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТЫН

"ГЭР" ЗӨВЛӨМЖ



Б.Хоол хүнсний зохистой хэрэглээ

Энд өрхийн хоол хүнсний зохистой хэрэглээний талаарх сэтгэл ханамжийг үнэлнэ. Өрхийн хоол хүнсний хэрэглээний бүтэцдээ хэр сэтгэл ханамжтай байгааг тэдний хэлснээр тэмдэглэн авна.

Хоол хүнсний зохистой хэрэглээ гэдэгт өрхийн хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл

олон, нүүрс ус, уураг, амин дэмээр баялаг, аюулгүй, цэвэр байхыг ойлгоно.

Хоол гэдэг нь аливаа бүтээгдэхүүнийг бодит байдлаар нь юм уу амьдралын явцад шалгарч, уламжлагдан ирсэн технологиор боловсруулсан, хүний хэрэгцээг хангаж байгаа амьтан, ургамлын гаралтай төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүн, амтлагч бодисуудын зохистой хослолыг хэлнэ. Хүнсний бүтээгдэхүүн гэдэг нь

бидний хоолондоо хэрэглэдэг түүхий эд.

Бидний хэрэглэж байгаа хүнс аюулгүй, эрүүл мэндэд ач холбогдолтой, тэжээллэг байх ёстой. Тэгвэл хүнсний аюулгүй байдал гэж юу вэ? Хүнсний аюулгүй байдал гэдэг нь эрүүл хүнсний хангамжийн жигд хүртээмж, хүнс худалдан авах чадвар, хүнсний тэжээллэг чанар, хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдал гэсэн хэд хэдэн ойлголтын нэгдэл юм.

Хүнсийг зориулалтаар нь хэрэглэхэд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх баталгааг хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдал гэнэ. Хүнсээр дамжин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй биологи (нян, нянгийн хор, вирус гэх мэт), хими (микотоксин, маринетоксин гэх мэт), физик (мод, шил, хуванцар гэх мэт)-ийн хүчин зүйлс хүнсэнд агуулагдах нөхцөл байдлыг хүнсний бүтээгдэхүүний аюул гэнэ.

Хүнсний бүтээгдэхүүнийг

1. Мах, махан бүтээгдэхүүний
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээний
3. Үр тарианы бүтээгдэхүүний
4. Жимс, жимсгэний
5. Хүнсний ногооны гэсэн 5 бүлэг болгодог. Зарим оронд 6 дахь бүлэг болгон тос, чихэрлэг бүтээгдэхүүнийг авч үзэх нь бий.

Мах, махан бүтээгдэхүүний бүлэгт малын мах, шувуу, гахайн мах, загасны мах, хиам, дотор мах, өндөг орно. Мах, махан бүтээгдэхүүн нь тос, уураг, амин дэм (ретинол, холин, фолийн хүчил, B12, B бүлгийн болон A, E, D, K амин дэмүүд) эрдэс (төмөр, фосфор, натри, кали, кальци, магни, хлор, зэс, цайр, марганец, молибден, иод гэх мэт) тэжээлийн бодисоор арвин. Мах нь мэдрэл, арьс, булчин, яс, цусны төлжилтөд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээний бүлэгт сүү, тараг, бяслаг, аарц, ааруул, ээдэм, хоормог, мөхөөлдөс, ээзгий, айраг зэрэг орно. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь уураг, ханасан тос, B1, A, D, B2 амин дэм, кальци, цайр, магни, фосфороор баялаг. Сүү нь яс, шүд, арьс, харааг сайжруулах ач холбогдолтой. Хоногт 1 аяга сүү, 1 аяга тараг, зөөлөн бяслаг, бусад цагаан идээнээс 125 гр-ыг хэрэглэж хэвших хэрэгтэй.

Үр тарианы бүлэгт гурил, будаа гоймон, гурилан бүтээгдэхүүн орно. Цэвэрлэгдээгүй бүтээгдэхүүн буюу 2-р гурил, арвайн гурил, шар будаа, хошуу будааны нэвс, чанах жигнэх аргаар боловсруулсан бүтээгдэхүүн эрүүл мэндэд ач холбогдолтой. Харин цэвэршүүлсэн бүтээгдэхүүн, дээд гурил, тослог ихтэй боов, жигнэмэг, тосонд болгосон болон дээд гурилаар хийсэн чихэртэй бүх төрлийн нарийн боов, вафлиас татгалзах хэрэгтэй. Үр тарианы бүтээгдэхүүн нь уураг, ханаагүй тос, нүүрс ус, цардуул, эслэг, B6, B1, B2 амин дэм, магни, цайр, кальци, фосфор, төмөр зэрэг эрдсээр баялаг. Үр тариа нь хүнд илч өгч, мэдрэлийн тогтолцооны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Жимс, жимсгэний бүлэгт байгалийн зэрлэг жимс, жимсгэнэ болон тарьж ургуулсан, хатаасан бүх төрлийн жимс багтана. Жимс жимсгэнэ нь нүүрс ус, эслэг, B1, B2, B6, A, C амин дэм, төмөр, кальци, кали, магни зэрэг эрдсээр баялаг. Энэхүү бүтээгдэхүүний ач холбогдол нь нүдний хараа, халдвар эсэргүүцэх, бие

махбодийн эсэргүүцлийг сайжруулахаас гадна өсөлт хөгжил, эрүүл мэндийг дэмжих олон бодис, амин дэмийг агуулдаг.

Хүнсний ногооны бүлэгт төмс, байцаа, үндэст ногоо (лууван, манжин, яншуй гэх мэт), сонгино (ногоон болон бөөрөнхий сонгино, сармис, таана, мангир гэх мэт), навчны ногоо (шанцай, бууцай, таван салаа гэх мэт), цэцгийн ногоо (цэцэгт байцаа), улаан лооль, хулуу, шош, буурцаг гэх мэт орно. Хүнсний ногоо нь эрдэс, эслэг, амин дэмээр баялаг.

А. Хоол хүнсний хангамж

- Хоол хүнс байнга хангалттай байдаг бол 3
- Хоол хүнс заримдаа хангалттай байдаг бол 2
- Хоол хүнс байнга хангалтгүй байдаг бол 1

Б. Хоол хүнсний зохистой хэрэглээ

- Тогтмол зохистой хэрэглээтэй байдаг бол 3
- Заримдаа л зохистой хэрэглээтэй байдаг бол 2
- Хэзээ ч зохистой хэрэглээтэй байгаагүй бол 1

4. ХҮНСНИЙ БУС ХЭРЭГЛЭЭ



А. Хувцас хунар

Энд өрхийн гишүүдийн хувцаслалтын талаарх сэтгэл ханамжийг үнэлнэ. Өрхийн гишүүдийн хувцаслалтандаа хэр сэтгэл ханамжтай байгааг тэдний хэлснээр тэмдэглэн авна.

Хүрээлэн буй орчны юмс үзэгдэл болох бороо, шороо, гал, хүйтэн, хорхой шавьж, хорт бодис гээд олон хүчин зүйлээс хүн өөрийн

бие, эрүүл мэндээ хамгаалахын тулд «нөмөрдөг» байгалийн болон зохиомол эд нэхмэл болон ширсэн зүйлийг ерөнхийд нь нэрлэнэ.

Хувцасны ач холбогдол

- Халуун хүйтэн байгалийн бусад нөлөөллөөс хамгаалах
- Биеийг далдлах
- Гоо сайхан, цаашлаад хувцасны чиг хандлагад нөлөөлөх
- Эрүүл ахуй, ариун цэврийг сахих
- Ажил мэргэжлийн зориулалтаар ашиглах
- Түүхийн өв соёл, цадиг түүхийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх

Хувцаслалтад юу анхаарах вэ?

- Цэвэр байх
- Улирал, цаг агаарт тохируулах
- Зориулалт, зохицолдлогоо оновчтой байх



Б.Түлшний хэрэглээ

Өрхийн түлшний хэрэглээ гэдэгт гэр, байшингийн дулаан хангамж, хоол ундаа болгоход хэрэглэж буй байдлыг ойлгоно. Тухайн өрхийн хэрэглэж буй түлш хамгийн гол нь байгаль орчинд ээлтэй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эрсдэлт байдал үүсгэхгүй байх ёстой.

Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг алдагдуулагч гол хүчин зүйл нь түүний

бохирдол бөгөөд энэ нь байгалийн буюу жам ёсны, хиймэл буюу зохиомол (хими, механик, физик) үйл явцын нөлөөгөөр үүсэн бий болж буй орчин тойрны өөрчлөлт юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 2-д “Хүн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан байдаг.

Гэвч сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа хүн амын механик хөдөлгөөн ихэссэнээр гэр хороолол тэлж, хотын нягтрал нэмэгдсэн. Түүнчлэн хот сууринд, ялангуяа, шинээр баригдаж байгаа байшин барилгын хоорондын зай багасч, агаарын урсгалыг сааруулж, бохирдлын сарнилтыг саатуулж байгаа зэрэг шалтгааны улмаас агаарын бохирдол ихээхэн нэмэгдэж, гамшгийн хэмжээнд хүрээд байна.

Агаарын бүтэц шинж чанар өөрчлөгдөхийг агаарын бохирдол гэдэг бөгөөд энэ нь хүний эрүүл мэнд, экосистд /байгаль, хүн хооронд/ таагүй нөлөө үзүүлдэг. Агаарын бохирдол байгалийн ба хүний гаралтай байж болно.

Хүний хамгийн үнэт эрдэнэ нь эрүүл мэнд бөгөөд хүн амьтны эрүүл явах үндэс бол цэвэр агаараар амьсгалах явдал билээ. Хүн хоол тэжээлгүйгээр хэдэн хоног явж чадах боловч хүчилтөрөгчгүйгээр хэдэн хором ч байж чадахгүй. Тайван байдалд эрүүл хүн нэг минутад 8-10 литр, цагт 500-600 литр, хоногт 1200-1400 литр хүчилтөрөгчөөр амьсгалдаг бол биеийн хүчний ачааллын үед 20,0 мянган литр хүртэл өсч болно.

Агаар бохирдуулах эх үүсвэрүүд:

1. Нийт агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын яндангийн утаа,
2. Бохирдлын 5-6 хувийг үйл ажиллагаа явуулж буй дулааны цахилгаан станцуудаас ялгаруулж буй утаа,
3. Авто замын хөдөлгөөнд оролцож байгаа 400,0 мянга гаруй авто тээврийн хэрэгслээс ялгарч буй утаа, угаарын хий 10 хувийг,
4. Дээр дурьдсанаас бусад эх үүсвэрээс ялгарч буй утаа, тоосжилт 4 хувийг тус тус эзэлж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэр болох түүхий нүүрсний хэрэглээ нь жилд 5,9 сая тонн бөгөөд үүнээс гэр хороололд 10 хувийг нь хэрэглэж байгаа боловч агаарт ялгаруулж байгаа бохирдлын 80 хувийг эзэлж байна.

Агаарын бохирдлын улмаас хүн амын дунд амьсгалын замын эмгэг түгээмэл

тохиолддог ба үүнд бүх насныхан өртдөг нь тодорхой. Үүний дотор хүүхэд, өндөр настан, мөн дархлаа султай өвчлөмтгий, архаг хууч өвчтэй хүмүүс илүү өртдөг. Олон улсад хийсэн судалгаагаар хүрээлэн буй орчны бохирдол нь хүн амын эрүүл мэндэд дараах байдлаар сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоосон байна. Үүнд:

1. Өвчлөлийг нэмэгдүүлэх

- Амьсгалын эрхтний эмгэг (Цочмог ларингит, архаг бронхит, тонзиллит, аденоидит, уушги, гуурсан хоолойн бөглөрөлтөт хэлбэрийн архаг үрэвсэл)
- Харшлын эмгэг (харшлын гаралтай нүд, чих хамрын хоолойн хөндийн үрэвсэл, багтраа, арьсны эмгэг)
- Зүрх судасны өвчин (Зүрх судасны өвчний тархалт өндөр байх, зүрхний үйл ажиллагааны хямрал, дутагдал, төрөлхийн гажиг, зүрхний ишеми)
- Удамшлын эмгэг, төрөлхийн гаж хөгжил
- Хавдар
- Нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. (үр хөврөл гэмтэх, дутуу төрөх)

2. Бие махбодын өсөлт, хөгжилтөд сөрөг нөлөөлнө.

- Өндөр, жин, цээжний тойргийн хэвийн харьцаа алдагдах
- Таргалах, турах
- Биеийн галбир өөрчлөгдөх

3. Бие махбодын физиологийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлнө.

- Уушгины үйл ажиллагаа алдагдах
- Оюуны ажиллах чадвар буурах
- Мэдрэхүй-хөдөлгөөний хурд өөрчлөгдөх
- Цусны даралт, судасны цохилт өөрчлөгдөх

4. Дархлалын түвшинг бууруулна.

- Биеийн ерөнхий эсэргүүцлийг сулруулах

Байгаль орчин, эрүүл мэндээ хамгаалж, агаарын бохирдлыг бууруулахын тулд юу хийж болох вэ?

- Утаа бага гаргадаг, боловсруулсан шахмал түлш хэрэглэх
- Утааг багатай эко зуух ашиглах
- Гэр болон байшингийн халаалтад цахилгаан эх үүсвэрийг ашиглах, ашиглалтын аюулгүй байдлыг хангах
- Гэр байшингаа сайтар дулаалж, дулааны алдагдлыг бууруулах

Гэр, байшингаа хэрхэн сайн дулаалах вэ?

- Гэр болон байшингийн дулаалгын материалыг зөв сонгон, аль болохоор дулааны алдагдал багатай материалаар гэрээ дулаалах
- Гэрийнхээ хаяаг манах зэрэг энгийн аргуудаар дулааны алдагдлыг багасгах

- Зориулалтын бус түлш хэрэглэх нь ямар хор холбогдолтой вэ?

- Хэрвээ өрх төвлөрсөн халаалт бүхий орон сууцны байшинд амьдардаг бол үнэлгээ хийхгүй.

А.Хувцас хунар

- ## Б.Түлшний хэрэглээ

- Зөвхөн зориулалтын түлш хэрэглэдэг бол 3
- Зориулалтын түлшийг хог хаягдалтай хамт хэрэглэдэг бол 2
- Зориулалтын бүс түлш болон хог хаягдал хэрэглэдэг бол 1

5. ӨРХИЙН САНХҮҮ



Өрх орлогын байнгын эх үүсвэртэй, өрхийн орлого зарлагаасаа давдаг бөгөөд илүү гарсан орлогоо өрхийн бусад хэрэгцээг хангах, тухайлбал, төлөвлөөгүй зардал, гэнэтийн эрсдэлт байдал (өвчин эмгэг, гамшиг гэх мэт) үүсэхэд хэрэглэх, дунд болоод урт хугацааны зорилгоо биелүүлэх хуримтлалтай байхыг санхүүгийн хувьд тогтвортой гэж ойлгоно

- Аливаа санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөж сурна.

- Болзошгүй эрсдлээс өрх, гэр өөрсдийгөө хамгаалж чадна.
- Нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөс өрхийн төсвийг хямралд оруулахгүйгээр амьжиргаагаа залгуулах бололцоотой болно.

Айл, өрх бүр санхүүгийн тодорхой зорилго тавьж, түүндээ хэрхэн хүрэх арга замаа сайтар төлөвлөх нь хамгийн чухал. Санхүүгийн зорилго гэдэг нь гэр бүлд чухал байгаа, гэр бүлийг аз жаргалтай болгох буюу амьжиргаагаа улам сайжруулахын тулд тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болох зорилт тавихыг хэлнэ. Тухайлбал: Шинэ машин авна гэсэн байхад тийм өнгөтэй, тийм маркийн, тийм үнэтэй гэх мэтээр нарийвчлан зорилт тавьж болно. Дараа нь энэхүү зорилгодоо хүрэх алхмаа хийх хэрэгтэй. Бага хэмжээний мөнгө байсан ч тасралтгүй цуглуулах хэрэгтэй. Хэрвээ мөнгөө банкинд хүүтэй хадгалуулбал хүү бодогдон, улам арвижих болно.

Хадгаламжгүй буюу санхүүгийн зорилго тавьж, түүнийхээ төлөө хөдөлмөрлөөгүй гэр бүл аливаа эрсдэл бэрхшээл тулгарахад хүнд байдалд орно. Өрхийн санхүүгийн зорилтыг биелүүлэхдээ:

- Ашигтай тоцоотой мөнгөн зарцуулалт хийх
- Зарлагаа хянах
- Орлого болон хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, хамгаалах
- Санхүүгийн ирээдүйн төлөвлөгөө гаргах ёстой гэдгийг мартаж болохгүй.

Аливаа өрх гэр нь санхүүгийн хүндрэлгүй амьдарч, хөгжихийн тулд зорилго, зорилтоо тодорхойлж, хөгжлийн оновчтой төлөвлөгөө хийх ёстой. Гэвч төлөвлөгөө хийнэ, хэрэгжүүлнэ гэдэг маш хэцүү. Ялангуяа, эмзэг, хүнд нөхцөлд амьдардаг өрхийн хувьд ихээхэн бэрхшээлтэй тулгарч болно. Нэгэн сонирхолтой судалгаагаар хүн бүр аливаа зүйлийг төлөвлөнө гэж бодоод шийдвэр гаргадаг бөгөөд тэд бүгд төлөвлөгөө хийх нь зөв гэж үздэг, гэвч 5 хувь нь л төлөвлөгөөгөө гаргаад хэрэгжүүлэх ажлаа эхэлдэг байхад тэднээс зөвхөн 2 хувь нь л төлөвлөсөн ажлаа бүрэн хийж чаддаг байна Харин төлөвлөгөө хийнэ гэж зорьсон хүмүүсийн 98 хувь нь хэлсэндээ хүрдэггүй гэсэн байна.

Өрх санхүүгийн зорилго тавьж төлөвлөж чадвал түүндээ хүрэх ямар нэг оновчтой аргаа олох хэрэгтэй. Нэг ёсондоо мөнгө буюу орлого хөрөнгөө хэрхэн оновчтой зарцуулахаа мэддэг байх ёстой. Юуны өмнө олсон орлогоосоо хэмнэлт хийхээс эхлэх хэрэгтэй юм. Хэрвээ хэмнэлт ерөөсөө хийж чаддаггүй бол энэ нь хэрэглээгээ оновчтой зохицуулж чаддаггүй буюу өр төлбөр ихтэй байгаагаас шалтгаалж болно. Ерөнхийдөө орлогоосоо давсан зардлыг хэрхэн шийдэх вэ хэрхэн хадгаламжтай болох вэ гэдэг нь хамгийн чухал асуудал болж болно.

Өрхийн хадгаламж нь төлөвлөсөн орлогоос зардлаа нөхөөд үлдсэн хэсгийг өрхийн төсвийн зарлагаас давсан орлого гэж үзнэ. Зарлагаас давсан орлого нь тухайн цаг хугацааны /сар, жилийн/ тэр айлын өрхийн хуримтлал буюу дараагийн хугацаанд ашиглах нэмэгдэл эх үүсвэр болдог.

Хадгаламж буюу нэмэгдэл эх үүсвэрийг дараах байдлаар ашиглаж болно.

1. Өрхийн орлогыг ашигтай байдлаар нэмэгдүүлэхийн тулд:
 - банкинд хадгалуулах, хуримтлалтай болох
 - хувьцаа, үнэт цаас худалдаж авах

- бусдад хүүтэй зээлдүүлэх
- 2. Өрхийн гишүүдэд оюуны хөрөнгө оруулалт хийх зорилгоор
 - Мэргэжил эзэмшүүлэх сургалтын төлбөр
 - Хэлний сургалтын төлбөр
 - Мэргэжлийн зэрэг ахиулах сургалтын төлбөр...гэх мэт
- 3. Амьдралын нөхцлөө сайжруулахад
 - Гэр бүлдээ хэрэгцээтэй эд хөрөнгө болон үл хөдлөх эд хөрөнгө худалдаж авах
 - Аялал, зугаалга, амралт сувилалд явах гэх мэт.

Харин төлөвлөсөн орлогоос зарлагын давсан хэсгийг өрхийн төсвийн алдагдал гэж үзэж үзнэ. Энэ тохиолдолд илүү гарсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрж олох шаардлага тавигдана. Үүний тулд орлогыг нэмэгдүүлэх, хэрэглээг бууруулах замаар орлогоос давсан зардлыг нөхөх арга хэмжээ авна.

1. Орлогыг нэмэгдүүлэх
 - Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх замаар, ажил албан тушаалаа өөрчлөх
 - Давхар ажил хийх
 - Өрхийн гишүүдийн хэн нэгнийг ашигтай бизнес эрхлүүлэх
 - Банк болон бусад байгууллага иргэдээс зээл авах
 - Илүүдэл эд зүйлийг худалдан борлуулах
2. Хэрэглээг хямдруулах
 - Аль болох хямд үнэтэй эд зүйлийн хэрэглээг сонгох
 - Зарим өндөр үнэтэй үсчин, угаалга, хими цэвэрлэгээ, ахуйн засвар зэрэг үйлчилгээнээс татгалзаж аль болох өөрсдийн хүчээр гүйцэтгэх
 - Биеийн эрүүл мэндэд анхаарч, өвдөж эм тарианд илүү зардал гаргахгүй байх
3. Зарим хэрэглээнээс татгалзах
 - Архи тамхи хэрэглэдэг муу зуршлыг орхих
 - Баяр ёслолыг өндөр зардлаар тэмдэглэхээс татгалзах зэрэг аргуудыг нэрлэж болно.



Б.Өрхийн төсөв

Өрх бүрт ашиглагдах мөнгөн орлогыг төлөвлөгөөтэйгээр захиран зарцуулах, бүртгэл хөтлөхийг өрхийн төсөв гэнэ. Өрхийн аль нэг гишүүн, эсвэл хамтдаа орлого, зарлагаа тооцоолж, өрхийн төсөв хөтлөх ёстой. Ингэснээр өрхийн хэрэглэж буй нөөц баялгийг илүү үр дүнтэй ашигтай байдлаар ашиглаж зарцуулж сурах ба бүртгэл хөтлөн, үр ашигтай зарцуулж, түүнийгээ тооцон дүгнэж, алдаа дутагдлаа засан залруулах ач холбогдолтой.

Өрхийн төсөв нь өрхийн гишүүдийн материаллаг болон соёлын /оюун

санааны/ хэрэгцээг аль болох хязгаарлагдмал нөөцөөр бүрэн дүүрэн хангахад чиглэгдэнэ.

Өрхийн төсөв нь:

1. Өрхийн орлого: Өрхийн орлого нь өрхийн төсвийн үндэс бөгөөд чухал бүтэц юм. Гэр бүлийн орлого гэдэг нь тогтсон болон тогтмол бус хугацаанд орж ирж байгаа бараа, үйлчилгээ, мөнгөн орлогыг хэлнэ. Орлого өрхийн гишүүдийн хэрэгцээнд зарцуулагдана.
2. Өрхийн зарлага: Өрх нь амьжиргаандаа хэрэгтэй зүйлээ орлогоосоо худалдан авахыг зарлага гэнэ. Өрхийн хувьд зарлагаа тооцож, бүртгэх нь маш чухал юм.

Хэрвээ зарлага, орлогоос давбал орлогоос давсан зарлага буюу өрхийн эдийн засгийн хувьд алдагдалтай байна гэсэн үг. Ямар ч тооцоогүй зарлага гаргаад түүнийгээ мэдэхгүй байснаар өр зээл өрх гэрт бий болдог. Энэ нь удаан үргэлжилснээрээ өр зээлэнд автах, эдийн засгийн хувьд гэр бүл хямралд өртөнө. Харин орлого, зарлагаас давбал зарлагаас давсан орлого буюу илүү гарсан орлого болно. Энэ нь гэр бүлийн эдийн засагт бусад төрлийн хэрэгцээгээ хангахад чиглэгдэх боломжтой болно.

Америк, Солонгос, Япон, Хятад гээд гадны улсуудын хувьд бүгд л гэр бүлийн санхүү, эдийн засаг тал дээрээ маш их анхаарч төсвөө оновчтой зарцуулах тал дээрээ өөр өөрсдийн арга технологийг боловсруулсан байдаг. Америкт гэр бүлүүд орлого нь хангалттай байдаг хэдий ч бүгдийг нь хэрэглээд дуусгадаггүй, тэд харин санхүүгээ яаж зөв менежменттэй зарцуулах вэ? гэдэг асуудал дээрээ анхаарлаа хандуулдаг. Харин манай улсын хувьд орлого нь дундаж, сайн байсан ч гэсэн хэрэглээндээ захирагдаж, орлогоосоо давсан зарлага гаргаснаар хуримтлуулах, хадгалах боломжгүй байдаг.

Өрхийн төсөв хөтлөх хэдэн арга байдаг. Тухайлбал:

- *Хүснэгтийн арга:* Олсон орлого, зарцуулсан мөнгөө тусгайлан бэлтгэсэн хүснэгтэд нарийвчлан бичиж хөтлөх арга юм. Өрхийн төсөв хөтлөх дэвтэр, хүснэгтийг боловсруулан номын худалдаагаар ихээхэн борлуулах болсон ба өрх өөрсдөө ч үүнийг зохиож хөтлөх боломжтой.
- *Дугтуйт төсвийн арга:* Орлого зарлагаа бүртгэж, мөнгөө чухам юу юунд зарцуулахаа сайтар тооцож, тус бүрд нь дугтуйнд хийж хадгалах арга юм. Энэ нь Америк болон Солонгос, Хятад улсуудад их хэрэглэгддэг арга юм. Энэ арга нь олон гэр бүлүүдэд үр ашгаа өгч чадсан.



В.Өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж орлого (төг)

Өрхийн нийт орлого гэдэгт цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, тэтгэвэр, тэтгэмж, хишиг хувь, бизнесийн орлого, халамжийн тусламж дэмжлэг, бусдын өгсөн мөнгө, авлага, өрхийн аж ахуй, үйлдвэрлэлээс өрхийн хэрэгцээнд хэрэглэсэн бараа,

бүтээгдэхүүнийг мөнгөн дүнд шилжүүлэн тооцсон орлогын хэмжээ зэргийг багтаан ойлгоно. Өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж орлогыг тооцохдоо өрхийн нийт орлогын хэмжээг өрхийн ам бүлийн тоонд хувааж олно.

Хүн амын амьжиргааны баталгаажих түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ. Харин хэрэглээний доод хэмжээ гэдэгт хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэглээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний тоо хэмжээг ойлгоно.

Хүн амын амьжиргааны баталгаажих түвшинг ҮСХ-оос жил бүр тооцож, зарлах ба энэ үзүүлэлт жишиг үзүүлэлт болдог. Хүн амын амьжиргааны доод түвшин 2016 онд Баруун бүсэд 164800 төг, Хангайн бүсэд 170800 төг, Төвийн бүсэд 163000 төг, Зүүн бүсэд 163700 төг, Улаанбаатарт 183700 төг тус тус байна.

Дараах асуултын дагуу үнэлгээ хийнэ.

А.Санхүүгийн тогтвортой байдал

- Өрх санхүүгийн хувьд байнга тогтвортой бол 3
- Өрх санхүүгийн хувьд тогтворгүй бол 2
- Өрх санхүүгийн хувьд байнга асуудалтай, хүнд бол 1

Б. Өрхийн төсөв

- Сар бүр өрхийн төсөв зохиож, түүнийхээ дагуу зарцуулдаг бол 3
- Өрхийн төсвийн талаар мэддэг ч, орлого, зарлагаа төдийлөн хянаж чаддаггүй бол 2
- Өрхийн төсвийн талаар мэдлэг байхгүй, орлого, зарлагын огт хяналтгүй бол 1

В. Өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж орлого (төг)

- Нэг хүнд ногдох орлого амьжиргааны баталгаажих түвшнээс дээгүүр бол 3
- Нэг хүнд ногдох орлого амьжиргааны баталгаажих түвшний 40 хувиас багагүй бол 2
- Нэг хүнд ногдох орлого амьжиргааны баталгаажих түвшний 40 хувьд хүрэхгүй бол 1

6. ӨРХИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ



А.Ажил, хөдөлмөр эрхэлж буй байдал

Өрхийн ядуурлаас гаргах гол арга замын нэг бол өрхийн гишүүдийн ядаж хэн нэг нь тогтмол орлоготой, байнгын ажил эрхэлж байх явдал юм.

- Хэрвээ албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагддаггүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэр (нөхөрлөл, хоршоо, компани гэх мэт)-т ороогүй, хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ эрхэлдэг бол

албан бус хөдөлмөр эрхлэлт гэж үзнэ. Албан бус хөдөлмөр эрхэлдэг бол ажил эрхэлдэг гэж үзнэ.

- Хэрвээ улирлын чанартай ажил (барилга, уул уурхай, газар тариалан гэх мэт) эрхэлдэг бөгөөд тогтоосон хугацаанд буцаад ажилдаа орох бол ажил, хөдөлмөр эрхэлдэг гэж үзнэ. Нийгмийн даатгалын тухай хуулиар жилд 7 сараас доошгүй хугацаагаар улирлын чанартай ажил эрхэлсэн бол бүтэн жилийн туршид нийгмийн даатгалын шимтгэл төлсөнд тооцдог.
- Мал аж ахуй, газар тариалан, өрхийн бизнес (аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ) зэрэг хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол ажил эрхэлдэг гэж үзнэ.



Б. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь а) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, б) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ гэсэн 2 төрөлтэй.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- Ажилд зуучлах;
- Ажилгүйдлийн тэтгэмж олгох;
- Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;
- Бусад үйлчилгээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ.

- Хөдөлмөрт бэлтгэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
- Ажил олгогчийг дэмжих;
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
- Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон

хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулна.

- Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:

- Хөдөлмөрт бэлтгэх: Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ нь ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд хүнтэй харилцах ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь туслах зэрэг зайлшгүй хэрэгцээт багц үйлчилгээ, дэмжлэг, туслалцааны хэлбэртэй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах: Хөдөлмөр эрхлэлтийн сургалт нь иргэнд үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалт, явуулын болон зайны сургалт, шавь сургалтын зэрэг хэлбэрээр богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилготой байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд хамрагдана.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих:

- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байна.
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгоно.
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид таван сая хүртэл, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд арван сая хүртэл төгрөгийн зээлийг 2 жил хүртэл хугацаагаар олгоно.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах:

- Нийтийг хамарсан ажлыг ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажилгүй иргэнийг түр хугацаагаар ажиллуулах, орлого нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээний хэлбэрээр зохион байгуулна.

Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:

- Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих

ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох;

- Ажил олоход хүндрэлтэй иргэн хувиараа болон өрхийн аж ахуйн хэлбэрээр хөдөлмөр эрхлэх бол түүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгох;
- Малгүй болон цөөн малтай иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар туслах малчнаар ажиллуулан, мал маллах арга ажиллагаанд сургаж, малжуулсан малчинд тухайн иргэнд төлсөн хөдөлмөрийн хөлсний хэмжээг нь харгалзан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг нэг удаа үзүүлж болно.

Тус хуулийн хүрээнд дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны нэгдүгээр тогтоолоор баталсан байна. Үүнд:

Нэг. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр

Хамрах хүрээ

- Ажилгүй иргэн;
- Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн¹;
- Ажил олоход хүндрэлтэй иргэн;
- Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд;
- 15-34 насны залуучууд.

Зохион байгуулах арга хэмжээ

- Тухайн иргэн²-ий онцлог, хэрэгцээг тодорхойлж, хөдөлмөрт бэлтгэх дараах арга хэмжээнд хамруулна. Үүнд:
 - ✓ Зөвлөгөө, мэдээлэл /Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох болон нийгэмшүүлэх зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан

1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт заасны дагуу “Ажилгүйдэлд өртөж болзошгүй гэж –Хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа өөрчлөх шаардлагатай болсон, эрхэлж байсан хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас сэргэх боломжгүй болсон тухайгаа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид мэдэгдэж, бүртгүүлсэн иргэнийг хэлнэ” гэж ойлгоно.

2 Сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд, асрамжаас гарсан иргэн; хорих ангиас суллагдсан иргэн; 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн; хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн; 15-34 насны ажилгүй залуучуудыг хамруулна.

зохицоход нь туслах, мэдээллээр хангах/;

- ✓ Сургалт /харьцааны ур чадвар, сэтгэл зүй, хувь хүний төлөвшил, хөдөлмөрийн харилцаа, аюулгүй ажиллагааны сургалтууд/.
- Иргэний суралцах мэргэжлийн чиглэл, хэлбэр, боломжийн талаарх хүсэлтийг үндэслэн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн доорх сургалтад хамруулна:
 - ✓ Үйлдвэрлэл дээрх сургалт;
 - ✓ Мэргэжлийн болон давтан сургалт

Хоёр. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Хамрах хүрээ

- Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн;
- Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч;
- Ажилгүй иргэн, орон нутгийн иргэдийн бүлэг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж;
- Ажил хайгч иргэд, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын оюутан, суралцагч;
- Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хүнсний ногоо тариалах хүсэлт гаргасан иргэн, иргэдийн бүлэг.

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээ

- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох;
- Аж ахуй эрхлэлтийн сургалт;
- Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх;
- Ажил олгогчид дэмжлэг олгох;
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулж, түр ажлын байраар хангах;
- Ажил хайгч иргэд, оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучилж орлого нэмэгдүүлэх;
- Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг зохион байгуулж орлогын дэмжлэг үзүүлэх.

Гурав. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр

Хамрах хүрээ

- Хөтөлбөрт залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчид хэрэгжүүлэх арга хэмжээний шаардлагын дагуу хамрагдана.

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээ

- Гарааны бизнесийг дэмжих;
- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох;
- Борлуулалтын болон үйлдвэрлэлийн ажлын байрны түрээсийн хөнгөлөлт

олгох.

Дөрөв. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хамрах хүрээ

- Залуу малчин
- Цөөн малтай иргэдэд

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээ:

- Малчин өрхийг малжуулах;
- Мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах.

Тав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Хамрах хүрээ

- “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан³”, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, бичгээр хандсан хөгжлийн бэрхшээлтэй хүн;
- Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч.

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээ:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний аж ахуй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Ажил олгогчийг дэмжих.

Зургаа. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр

Хамрах хүрээ

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахмад мэргэжилтнүүд;
- Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод.

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээ

- Аймаг, дүүрэгт ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах⁴;
- Үндэсний хэмжээнд ахмадын төрийн бус байгууллагуудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах,
- Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Өрх бүрээс энэхүү эрэлт хэрэгцээний талаар асуух бөгөөд хэрвээ өрхөд ийм хэрэгцээ шаардлага байхгүй гэж үзвэл үнэлэхгүй байж болно.

3 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.

4 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

Дараах асуултын дагуу үнэлгээг хийнэ.

А.Ажил, хөдөлмөр эрхэлж буй байдал

- Хөдөлмөрийн насны бүх гишүүд ажил эрхэлдэг бол 3
- Хөдөлмөрийн насны гишүүдийн зарим нь ажил эрхэлдэг бол 2
- Хөдөлмөрийн насны гишүүд бүгд ажил эрхэлдэггүй бол 1

Б. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээ

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага байхгүй бол 3
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ эсвэл дэмжих арга хэмжээнд хамрагдах шаардлагатай бол 2
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болон дэмжих арга хэмжээнд хамрагдах шаардлагатай бол 1

ХОЁР. ЧАДАВХ, БОЛОМЖ Г. ЭРҮҮЛ МЭНД

7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭРЭГЦЭЭ



А.Эрүүл мэндийн байдал

Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар “Эрүүл мэнд” гэж хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ.

Үүний тулд дараах асуудлын хүрээнд ярилцана. Үүнд:

- Та болон танай гэр бүлийн гишүүд бие физиологийн хувьд ямар нэг өвчин зовиургүй байна уу?
- Та болон танай гэр бүл сэтгэл санааны хувьд ямар нэг дарамт түгшүүргүй амар амгалан байна уу?
- Таны хүрээлэн буй орчин (нийгэм, ажлын байр, гэр бүл, байгаль орчин) эрүүл орчин мөн үү?

Өрхийн гишүүдийн өөрсдийн тодорхойлсноор эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийнэ:

- Өрхийн бүх гишүүд эрүүл бол 3
- Өрхийн зарим гишүүд эрүүл мэндийн хувьд эмзэг, өвчлөмтгий бол 2
- Өрхийн бүх гишүүд эрүүл мэндийн хувьд тааруу, архаг хууч өвчтэй, эрсдэлтэй бол 1

8. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ



А.Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг нь өвчнийг эрт үед илрүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд өвчлөх эрсдлээс бүрэн хамгаалдгаараа ач холбогдолтой.

Иргэн бүр эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ шаардлага гарахаас өмнө урьдчилан сэргийлэх байдлаар эмнэлэгт жилдээ ядаж нэг

удаа ханддаг байх ёстой.

Тэгэхээр өрхийн гишүүдийн хувьд ийм дадал хэвшил төлөвшсөн эсэхийг тодорхойлохоос гадна шаардлага гарсан тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чаддаг эсэхийг тодорхойлох зорилготой.

Статистик мэдээнээс үзвэл 2016 онд хавдрын 5991 тохиолдол шинээр бүртгэгдсэн бөгөөд 2160 буюу тал хувь элэгний хавдартай гарсан байна. Сүүлийн 10 жилд элэгний хорт хавдрын улмаас жилд дунджаар 2600 хүн буюу өдөр бүр долоон хүн нас барж байгаа нь дэлхийн дунджаас өндөр үзүүлэлт юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хийсэн түүвэр судалгаагаар манай улсын 400 орчим мянган хүн В,С вирусийн халдвартай байх магадлалтай байна.


Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг 4 зорилт 31 үйл ажиллагааны хүрээнд 2017-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийг 2020 он хүртэл хэрэгжүүлснээр гепатитийн вирусийн халдварын тархалтыг хязгаарлан, С вирусийн халдварын шинэ тохиолдлыг таслан зогсоож, элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаантай нас баралтыг эрс бууруулах боломж бүрдэнэ.

Энэ хүрээнд 2020 он гэхэд С вирусийн халдвартай 150,000 хүнийг бүрэн эмчилж, элэгний хорт хавдар, хатуурлын шалтгаантай нас баралтыг эрс бууруулж, вирусийн голомтыг устгахыг зорьж байна.

Тухайлбал 2017 онд 40-65 настан, 2018 оноос 15-39 настай болон 65-аас дээш насны иргэдийг В, С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна. Энэ шинжилгээг Өрхийн эрүүл мэндийн төвд авч байна. Мөн эмийн эмчилгээг даатгалын хөнгөлөлттэй үнэд багтаан, цаашдаа элэг шилжүүлэн суулгах хагалгааны зардлыг төрөөс хариуцдаг болох юм.

Түүнчлэн Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан дараах шинжилгээг иргэдэд үнэ төлбөргүй хийж байна. Үүнд:

- умайн хүзүүний хорт хавдрын шинжилгээг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд 2 жил тутам
- холестерин, сахарын шинжилгээг хүссэн хүн бүр хийлгэх боломжтой болсон байна.



Б.Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналт, дархлаажуулалт

Хүүхдийн өсөлт, хөгжил гэдэг нь бие бялдар, танин мэдэхүй, хөдөлгөөн, нийгэм, сэтгэл зүйн хөгжлийн үйл явцыг хэлдэг. Хүүхдийн хөгжлийг хянаснаар тэдний бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжилд гарах өөрчлөлтийг тодорхойлж, хөгжлийн хоцрогдолд орохоос сэргийлнэ.

Хүүхдийн өсөлт нь хүүхдийн нас, биеийн жин, урт/өндрийн хэмжээгээр, хөгжил нь хүүхдийн үйл хөдөлгөөн, оюун ухаан, танин мэдэхүйн чадвараар илэрхийлэгдэнэ.

Хүүхдийн өсөлт, хөгжил гэдэг нь бие бялдар, танин мэдэхүй, хөдөлгөөн ба нийгэм, сэтгэл зүйн хөгжлийн үйл явцыг хэлдэг.

- Хүүхдийн өсөлт нь хүүхдийн нас, биеийн жин, урт/өндрийн хэмжээгээр илэрхийлэгдэнэ.
- Хүүхдийн хөгжил нь хүүхдийн үйл хөдөлгөөн, оюун ухаан, танин мэдэхүйн чадвараар илэрхийлэгдэнэ.

Хүүхдийн өсөлтийг тогтмол хянах нь хүүхдийн эрүүл мэнд, хооллолт, хөгжилд гарч болзошгүй сөрөг өөрчлөлтийг эрт мэдэж, улмаар цаг алдалгүй хариу арга хэмжээ авах ач холбогдолтой.

Хүүхэд хангалттай хоол тэжээл авч байгааг хэрхэн мэдэх вэ?

- Хүүхдийн өсөлтөөр хоол тэжээлийн байдлыг үнэлнэ.
- Сар бүр хэмжсэн жин болон урт/өндрийн хэмжээг холбосон шугам нь гурван янзын өсөлтийн муруйг үүсгэнэ.
- Өсөлтийн муруй нь аль болох өсөлтийн хүснэгтийн голч шугам руу чиглэсэн буюу түүнийг дагаж өссөж байх шаардлагатай.
- Хүүхдийн өсөлтийн муруй цэнхэр өнгийн дэвсгэр дээр өгсөж байвал хүүхэд хэвийн өсч, хооллолт сайн байгааг харуулна.

Харин дараах асуудал буюу эрсдэл гарвал анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Өсөлтийн муруй цэнхэр өнгийн дэвсгэр дээр тэгширсэн бол хүүхдийн жин, өндөр нэмэгдэхгүй байгааг харуулна
- Өсөлтийн муруй нь огсом өгсөж ногоон өнгө рүү орвол хүүхдийн жин хэвийн бус таргалж байгааг харуулна
- Өсөлтийн муруй шар өнгө руу уруудвал хүүхэд чинь туранхайг бүр улаан дэвсгэр рүү орвол хүүхэд тураалтай байгааг харуулна.

Хүүхдийн жин болон урт/өндөр нь өмнөх сарын үзүүлэлтээс нэмэгдэхгүй эсвэл өмнөх хэмжээнээсээ багасах нь хүүхэд өвдсөн эсвэл өсөлт хөгжлийг хангахуйц хангалттай хооллож чадахгүй байгаа буюу асаргаа сувилгаа муу байгааг илтгэх бөгөөд эмчид яаралтай хандаж зөвлөгөө авах шаардлагатай.

Бага насны хүүхэд өөрийн хөгжлийн үе шат бүхэнд тохирсон хөдөлгөөн,

үйлдлийг хийж чаддаг байх ёстой. Хүүхдийн хөгжлийн хамгийн чухал үе нь 0—24 сар (0-2 нас) бөгөөд энэ үед хоол тэжээлийн дутагдлаас болж турж, хөгжлөөр хоцордог. Хүүхдийн хөгжилд асаргаа сувилгаа нэн чухал байдаг. Хүүхэд бага жинтэй (2500 гр-аас доош) төрөх нь өсөлт хөгжлийн хоцрогдолд орох магадлал их байдаг.

0-24 сартай хүүхдийн хөгжлийн онцлог юу вэ?

- Уураг тархины эд эсийн хөгжил эрчимтэй явагдана
- Гар, хурууны жижиг булчингийн хөгжил явагдана
- Хараа, хөдөлгөөний баримжаа сайжирна
- Танин мэдэхүйн хүрээ нэмэгдэнэ
- Сэтгэлийн хөдөлгөөн, сониуч зан илэрнэ
- Хөл, хэлд орно

Хүүхэд бүр дараах товлосон хугацаанд дархлаажуулалтад бүрэн хамрагдах ёстой. Үүнд:

- Сүрьеэ: Төрснөөс хойш 24 цагийн дотор
- Гепатит В: Төрснөөс хойш 24 цагийн дотор
- Халдварт саа: Төрснөөс хойш 24 цагийн дотор, 2, 3, 4 сартайд
- Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран+гепатит В+хемофилюс инфлюэнза): 2, 3, 4 сартайд
- Улаан бурхан, гахай хавдар, улаанууд: 9 сартайд, 2 настайд
- Сахуу, татран: 7, 15 настайд

Хүүхдийн хөгжлийг хянаснаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжилд гарах өөрчлөлтийг тодорхойлж, хүүхдийг хөгжлийн хоцрогдолд орохоос сэргийлнэ. Ингэхдээ эцэг эхчүүд хүүхэдтэйгээ байнга ярих, хөдөлгөөнийг дэмжих, асаргаа сувилгаа хийж, зөв хооллож хайрлан халамжлах шаардлагатай байдаг.

Хүснэгт 7. 0-24 сартай хүүхдийн хөгжлийн үе шатны бүлэг үзүүлэлтүүд

Хүүхдийн	Хөгжил		
	Бие бялдарын	Сэтгэхүйн	Нийгэмшихүйн
Нярай	• Хөхөө хөхөж чадна • Ихэвчлэн тайван унтана • Түрүүлгээ харуулан хэвтүүлэхэд эрүүгээ бага зэрэг өргөнө • Гарт бариулсан бүхнийг атгана	• 15-20 см-ын зайд байрлуулсан зүйлийг харна • Дуу чимээ гарсан зүг рүү толгойгоо эргүүлнэ • Шээсэн буюу таатай биш байгаа үед уйлна	• Эхийгээ танина • Анхаарал татах гэж уйлна • Эхийнхээ хайр энхрийллийг мэдэрнэ
1 сартай	• Түрүүлгээ харуулж хэвтүүлэхэд түр толгойгоо өргөнө • Толгойгоо арай ядан даана	• Тод өнгийн зүйлийг сонирхож харна • Ойр хөдөлж байгаа зүйл рүү харна • Таатай үед ганганана	• Өөрт нь хандан ярихад нүүр рүү нь харна • Хайр энхрийлэл болон хэрэгцээгээ уйлж илэрхийлнэ

2 сартай	• Түрүүлгээ харуулж хэвтүүлэхэд толгойгоо арай удаан өргөнө • Гарт тааралдсан зүйлийг атгана	• Түрүүлгээ харж хэвтсэн үедээ толгойгоо эргүүлэн дагуулж харна • Дуу чимээ гарсан зүг рүү толгойгоо эргүүлж харна • Өглөө сэрмэгц тайван хэвтэж ганганана	• Эх, ойр дотны хүмүүсээ таньж инээмсэглэнэ • Анхаарал халамж хэрэгтэй болон хоол идэхийг хүссэн үедээ уйлна
3 сартай	• Өвөр дээрээ тэврэн зогсооход толгойгоо сайн даана • Хөдөлж буй зүйл рүү гараа сунгаж барьж авахыг оролдоно	• Хүний дуу хоолойг сонсон, хүн харсан үедээ дуугарч, гар хөлөө хөдөлгөнө • Дуу чимээ гарсан зүг рүү толгойгоо эргүүлэн харцаараа хайна • Хөгжим сонсоно • Гараа өөрийнхөө нүүр, нүд, аманд хүргэнэ	• Эцэг эх, ойр дотны хүмүүсээ таньж инээмсэглэнэ • Эхийгээ орхиж явахад уйлна • Анхаарал халамж хэрэгтэй болон хоол идэхийг хүссэн үедээ уйлна
4 сартай	• Толгойгоо бүрэн даана • Хэвтэж байхдаа эргэж хөргөнө • Өвөр дээрээ тэврэхэд тэнцвэртэй зогсоно	• Халбагаар хооллоход амаа ангайна • Дуу чимээ, хөдөлгөөнийг сонсож ажиглана • Гар хүрэх зүйлийг барьж үзэж сонирхоно • Түүнд хандаж ярихад хоолойгоо татаж, дуу авиа гаргана • Түүнтэй тоглоход инээнэ	• Эх ба хооллож байгаа хүн рүү харж инээмсэглэнэ • Эхийгээ хараад баяртай байгаагаа дуу гаргах, хөлөө тийчлэх байдлаар илэрхийлнэ • Усанд дүрэхэд чичирнэ • Шээсэн болон өлссөн үедээ уйлна
5 сартай	• Гараараа тулж цээж болон биеэ өргөнө • Бусдын дэмжлэггүйгээр түр хугацаанд сууна • Суганаас нь тулж зогсооход толгой болон биеэ тэгш байлгана • Доош харуулсан үед мөлхөх оролдлого хийнэ	• Барьж буй зүйлээ нэг гараасаа нөгөө гарт шилжүүлнэ • Эд зүйлсийг сонирхож гартаа атган амандаа хийнэ • Хөдөлж буй зүйлд анхаарал нь татагдана • Ба, ма, га, да гэх мэтийн авиа гаргана	• Толинд харахдаа дуртай байна • Түүнтэй ярихад гараа хөдөлгөж, дуу авиа гаргана • Түүнтэй тоглоход чанга дуугарч инээнэ

6-8 сартай	• Бусдын тусламжгүйгээр сууна • Мөлхөнө • Сууж буй үед нь гараас нь барихад татаж босно	• Эд зүйлсийг эвсэлтэйгээр барьж авна • Хуруунуудаа хөхнө • Нэрээр нь дуудахад харна • Усаар тоглоно • Дохио үйлдлийг хийнэ • Аав, ээж зэрэг богино үетэй үгийг хэлнэ	• Эцэг, ах эгчийгээ танина • Ах, эгчтэйгээ тоглоно • Танихгүй хүнийг хараад гэрэвшинэ
9-11 сартай	• Юм түшин хажуулдаж явна • Богино хугацаанд ганцаараа зогсоно • Жижиг зүйлийг эрхий болон долоовор хуруугаар барьж сурна	• Ямар нэг зүйл рүү хуруугаа хийх дуртай • Савыг дүүргэж, түүнийгээ асгах дуртай • Хөгжмийн аянд биеэ хөдөлгөнө, найгана • 2 үетэй богино үгнүүдийг хэлж сурна	• Ах эгч нартайгаа тоглоно • Хүнд илүү дасамгай болно • Бусдын зааврыг биелүүлнэ / баяртай гэхэд гараа хөдөлгөх/
12-14 сартай	• Ганцаараа сууна • Явган сууна • Бусдын тусламжгүйгээр ганцаараа зогсоно • Хэдэн алхам хийнэ	• Зааврыг дагаж биелүүлнэ • Эд зүйлсийн бүтцийг сониучирхана • Зарим үгсийг хэлж сурна • Ойр зуурын харилцан яриаг ойлгож эхэлнэ	• Дуу сонсоод биеэ хөдөлгөнө • Ганцаараа тоглоно • Бие дааж хооллохдоо дуртай байна • Хүссэн үедээ аав ээжийгээ үнсэнэ
15-17 сар	• Бие даан чөлөөтэй алхана • Богино зайд гүйхийг оролдоно • 2 гараараа бөмбөг шидэхдээ тэнцвэрээ хадгалж чадахгүй унана	• Амаа ангай, хэлээ гарга гэсэн заавруудыг ойлгоно • Биеийнхээ эрхтэнүүдийг мэддэг болно • Богино дуу дуулж, шүлэг уншина • Мэддэг зүйлийг нь асуухад хуруугаараа заана	• Бусад хүүхдүүдтэй байхдаа ч ганцаараа тоглоно • Танил хүмүүстэйгээ харилцах дуртай байна • Өөртөө анхаарал тавихыг шаардана
18-20 сар	• Арагшаа, хажуу тийшээ алхана • Сайн гүйх боловч зогсох үедээ унана • Сараачин зурна	• Эд зүйлсийг хүнд шилжүүлэн өгч чадна • Хүн, юмыг нэрээр нь нэрлэнэ, мэддэг үгнүүдээ хэлнэ • Хаана байгааг асуухад гараараа заана • Мэддэг буюу таалагддаг дуу авиагаа дуурайна	• Эд юмсыг хөдөлгөж шилжүүлэх дуртай • Хийж байгаа зүйлдээ сонирхолтой байна • Хувцсаа тайлахыг оролдоно • Тэврэхэд тэвэрнэ • Тоглосон үед инээнэ, ганганана.

21-24 сар	• Богино хугацаанд өлмий дээрээ зогсоно • Бөмбөгийг урагш өшиглөнө • Шатны бариулаас барьж хөлөө зөөж явна	• Нэрээ мэддэг болно • Ганцаараа дуулах, бүжиглэх дуртай болно • Эд юмс нэртэй болохыг мэднэ • Өлссөн цангасан үедээ хоол, ус нэхнэ • Шүлэг сонсох дуртай • Нэг үетэй үгнүүдийг хэлдэг болно	• Гэр ахуйн ажилд оролцохыг оролдоно • Гадаа тоглох дуртай, тоглоомуудаа өмчилнө • Айж байгаагаа илэрхийлнэ
-----------	--	---	---

Хүүхдийн өсөлт хөгжлийг хэрхэн үнэлэх вэ?

- Хүүхдийн өсөлтийг үнэлэхийн тулд түүний жин болон урт/өндрийг хэмжинэ.
- Жинлэхдээ хүүхдийг аль болох нимгэн хувцастай, тайван байлгана.
- 0-23 сартай хүүхдийг хэвтүүлж жинлэнэ.
- 0-23 сартай хүүхдийг хэвтүүлж уртыг нь, харин 24-59 сартай хүүхдийг зогсоож өндрийг нь хэмжинэ.
- Хүүхдийн хөгжлийг хүүхдийн үйл хөдөлгөөн, сэтгэлийн илэрхийллийг тодорхойлж үнэлнэ.

Хүүхдийн өсөлт хөгжлийг ямар хугацаанд хянаж үнэлэх вэ?

- Хүүхдийг 0-23 сартайд нь сар бүр хянана
- Хүүхдийг 24-59 сартайд нь улирал бүр хянана
- Хүүхдийн жин болон урт/өндрийн хэмжээ, хүүхдийн үйл хөдөлгөөн, сэтгэлийн илэрхийллийг Хүүхдийн өсөлт хөгжлийн бүртгэлд тэмдэглэж үнэлнэ.

Хэрэв өрх энэ насны хүүхэдгүй бол үнэлгээ хийгдэхгүй.



В.Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хяналт, үйлчилгээ (Гэр бүл төлөвлөлт, жирэмсний болоод төрсний дараах хяналт орно)

15-49 насны эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн насны гэж үзнэ. Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг нь нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо өвчин эмгэггүй, эрүүл байх төдийгүй бие махбодь, сэтгэл санаа, нийгмийн талаар бүрэн төгс эрүүл,

хувь хүн, гэр бүлийн хосууд сэтгэл ханамжтай, аюулгүй бэлгийн амьдралтай, нөхөн үржих чадвартай байж, хэзээ хэдэн хүүхэд төрүүлж өсгөхөө чөлөөтэй шийдвэрлэх чадвартай байх тухай ойлголт юм.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуйтай холбоотой хяналт, үйлчилгээнд хамрагдалтыг энэ хэсэгт тодорхойлно.

Жирэмсний явцад ямар ч хүндрэл гарч болзошгүй байдаг тул хяналтад орж, мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах нь гарч болзошгүй хүндрэлээс сэргийлнэ. Жирэмсэн эмэгтэй эхний 3 сарын дотор эмнэлэгт эмчийн хяналтад орох

шаардлагатай бөгөөд жирэмсний явцад нийт 6-9 удаа үзүүлж, зөвлөгөө авсан байна. Үзлэгт:

- Жирэмслэлт хэвийн явагдаж байвал 6 удаа
- Эрсдэлт жирэмсэн эмэгтэй 8 болон түүнээс дээш удаа
- Эмгэг өөрчлөлт илэрвэл хугацаа харгалзахгүйгээр
- Төрсний дараах үед 21 хоног тутамд 1 удаа тус тус үзүүлж, зөвлөгөө авна.

Жирэмсний хяналтад орохын ач холбогдол:

- Жирэмслэлтийн эрсдлийг тодорхойлуулах (анхны жирэмслэлт, 18 түүнээс доош настай жирэмсэн, 5 буюу түүнээс олон жирэмслэлт, 35-аас дээш насны жирэмслэлт)
- Жирэмсний үед гарах хүндрэл, архаг өвчнийг илрүүлэх (зүрх, бөөр, даралт, сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин)
- Ургийн өсөлт, эрүүл, зөв байрлалтай байгааг мэдэх
- Эмнэлгийн үзлэгт хамрагдах зэрэг эмнэлгийн бусад үйлчилгээг авах
- Архаг хууч өвчтэй болон өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэй эх барих эмэгтэйчүүдийн их эмчийн хяналтад орж, заавал төрөх газар төрөх
- Амны хөндийг эрүүлжүүлэх, хөхөө арчлахыг талаар зөвлөгөө авах

Жирэмсний явцад анхаарвал зохих ямар шинж тэмдгүүд байдаг вэ?

- Биеийн жин нэмэгдэхгүй байх (жирэмсний хугацаанд биеийн жин дор хаяж 6 кг-аар нэмэгдэх ёстой)
- Цус багадах, зовхины дотор тал цайх, их ядрах, амьсгаадах
- Хөл, гар, нүүр хавагнах
- Ургийн хөдөлгөөн маш муу эсвэл хөдлөхгүй байх

Жирэмсэн эмэгтэй зохистой, чанартай хоолыг бага багаар ойрхон идэх нь ургийн өсөлт, хөгжилд сайнаар нөлөөлнө. Үүний тулд:

- Зохистой хооллох – Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэнд болон эхийн хэвлийд байгаа ургийн өсөлт, хөгжилтөд хэрэгтэй.
- Олон нэр төрлийн хоол, хүнс хэрэглэх нь шаардлагатай бодисуудыг хангалттай авах ба жирэмсэн эмэгтэйг цус багадалтаас, бахлуураас, хүүхдийг нь элдэв гаж хөгжил, бага жинтэй төрөхөөс урьдчилан сэргийлнэ.
- Нэмэлтээр бичил тэжээлийн бодисуудыг хэрэглэх – Эмчийн хяналтын дор төмрийн бэлдмэлийг нэмэлтээр ууж, иоджуулсан давсыг тогтмол хэрэглэнэ.
- Тамхи, архи болон эмчийн зөвшөөрөлгүй эм, тариа хэрэглэхгүй байх- Жирэмсэн хүн тамхи татах, архи уух, эмийг замбараагүй хэрэглэх нь бага жинтэй, төрөлхийн согогтой хүүхэд төрөх шалтгаан болдог.
- Биеийн жингээ хянах - Жирэмсэн эмэгтэйн жин **3** сар тутамд дунджаар **3.6** кг нэмэгдсэн байна. Жирэмсний хугацаанд (9 сар) ойролцоогоор биеийн жин нь дунджаар 11 кг-аар нэмэгдэх ёстой. Хэвийн жин нэмэлт, эмгэг жин нэмэлт (хавагнах)-ийг сайн анхаарч, хавагнасан үед хяналтын эмчид яаралтай үзүүлнэ.

Жирэмсний үеийн хооллолтой холбоотой зовиурын үед яах вэ?

- Бөөлжис цутгах, огиулах үед мах бага идэж, бага багаар ус ууж, унтаж сэрсний дараа бага хэмжээгээр талх, будаа, жигнэмэг идэх
- Цээж хорсож, ходоод хямрахад мах бага идэж, халуун ногоо, хоол амтлагч хэрэглэхгүй байх, хоол идсэний дараа баруун хажуугаараа доош харж хэвтэх
- Өтгөн хатах, гэдэс дүүрэх үед өдөрт 2 литрээс багагүй хэмжээний шингэн уух, хүнсний ногоо, жимс жимсгэнэ хангалттай хэмжээгээр идэх, дасгал хөдөлгөөн тогтмол хийж, алхах
- Цагаан мах гарахад удаан хугацаагаар зогсохоос зайлсхийх, өтгөн хаталтыг эмчлэх, хэвлийг хүчилж, шахаж болохгүй, бүлээн усаар биеэ арчиж, усанд орох

Жирэмсэн эмэгтэй сайн унтаж амарч, сэтгэл санаа тайван байж, гэр бүлийнхэн нь сайн хайр халамж үзүүлдэг байх ёстой. Жирэмсэн эмэгтэй илүү цагаар буюу шөнийн ээлж, биеийн хүчний хүнд ажил хийхийг хориглоно. Жирэмсэн эмэгтэйд илүү анхаарал халамж шаардлагатай байдаг. Учир нь:

- Хүнд хөдөлмөр нь жирэмсэн эмэгтэйд ядрааж ураг зулбах, дутуу төрөх, төрөлхийн ургийн гажиг үүсгэх аюултай
- Жирэмсэн эмэгтэйд хүнд юм өргүүлэх, мод түлээ хагалуулах, газар шорооны ажил хийлгэхгүй байх
- Гэр бүлийн хэрүүл маргаан, зодоон, хүчирхийлэл, дарамт, архидалт зэрэг нь жирэмсэн эмэгтэй буюу урагт маш муугаар нөлөөлдөг тул тайван байлгах
- Жирэмсэн эмэгтэйд амьдрах орчны таатай нөхцлийг (ор, дэр, ахуйн ариун цэврийг сайн байлгах, гэрэл, агааржуулалтыг шаардлагын дагуу зөв өгч байх, архи, тамхигүй орчин) бүрдүүлэх
- Жирэмсэн эмэгтэй сэтгэл санаа тайван байж, маш сайн амарч байх
- Жирэмсний 6 сартайгаас эхлэн хөдөлмөрийн хүнд нөхцлийг өөрчлөх

Жирэмсэн эмэгтэйд дараах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандаж тусламж авах шаардлагатай. Үүнд:

- Жирэмсний явцад үтрээнээс цусархаг зүйл, цус гарах, ус гарах
- Толгой хүчтэй өвдөх, гэдэс базлах
- Хүчтэй огиулж бөөлжих
- Өндөр халуурах, таталт өгөх
- Хүчтэй өвдөх
- Амьсгаадах
- Биеийн жин нэмэгдэхгүй байх эсвэл 7 хоногт 400 граммаас дээш нэмэгдэх
- Хэвлийн доод хэсгээр базалж өвдөх
- Артерийн даралт нэмэгдэх, эсвэл буурах
- Хавагнах
- Шээсний гарц багасах, ойр ойрхон шээх
- Арьс, салст гэнэт цайх

- Хүүхэд хөдлөхгүй болох

Жирэмсэн эмэгтэй хүнд ажил хийж, хүчирхийлэл дарамтад байснаар ямар хор уршиг гарах вэ?

- Эхийн сэтгэл санаа хямрах, хөхний сүү татрах, өвдөх
- Ураг зулбах, дутуу төрөх, төрөлхийн ургийн гажиг үүсэх аюултай .

Сумын болон өрхийн эмч төрсөн эх, нярайг эмнэлгээс гарснаас хойшхи 2 сарын хугацаанд 7 хоног тутамд эргэж, эрүүл мэндийг нь үзэж зөвлөгөө өгнө.

Төрсний дараах хяналтаар юуг үнэлж, зөвлөх вэ?

- Эх хүүхдээ хөхөөр хооллож байгаа эсэх, хүүхэд эрүүл өсөж байгаа эсэх, Эх ОНБТБ болон А аминдэм авч байгаа эсэхийг хянана.
- Эхэд нярайн хоол, асаргааны талаар зөвлөгөө өгнө.

Төрсний дараа эхэд дараах шинж тэмдэг тэмдэг илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандаж тусламж авах шаардлагатай. Үүнд:

- Арьс салст цайх
- Халуурах
- Толгой эргэх, толгой өвдөх
- Нүд, гар, шилбээр хавагнах
- Шилэн хүзүүгээр хөших
- Аюулхай орчмоор өвдөх
- Хэвлийн доогуур өвдөх
- Шавхарга ихээр гарах, эвгүй үнэртэй болох

Нярайд дараах шинж тэмдэг тэмдэг илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандаж тусламж авах шаардлагатай. Үүнд:

- Арьсны шарлалт буурахгүй байх
- Хүйнээс шүүс гарах
- Хүйний орчим улайх
- Халуурах, хөлрөх эсвэл биеийн халуун буурах
- Хүүхэд тайван биш байх
- Хөхөө хөхөхгүй байх
- Гулгих
- Амьсгал түргэсэх эсвэл удаашрах
- Цээж хонхолзох
- Хөдөлгөөн удаашрах
- Биеийн жин огцом буурах
- Шээс ховордох

Дээрх шинж тэмдгүүдийг аяндаа зүгээр болохыг хүлээх эсвэл өөрөө эмчлэх гэж хугацаа бүү алдаарай.

Жирэмсэн болон төрсөн эх, нярай амин дэмийг дараах зааврын дагуу хэрэглэх ёстой.

Төмрийн бэлдмэл, ОНБТБ /цаашид Олон найрлагат бичил тэжээлийн

бэлдмэл гэх/, Д аминдэмийг хэрхэн уух вэ?

- ОНБТБ болон төмрийн бэлдмэлийг жирэмсний эхний **3** сараас эхлэн төрөх хүртлээ эмчийн заавраар хэрэглэх
- Төмрийн бэлдмэлийг хоол идэхээс **30** минутын өмнө ус, жимсний шүүсээр даруулж хэрэглэх ба сүүтэй цайгаар ууж болохгүй
- ОНБТБ-ийг хоолны дараа буюу өдөрт **1** удаа уух
- Өндөр тунтай Д аминдэмийг жирэмсний сүүлийн **3** сар намар, өвөл, хаврын **3** улиралд сард **1** удаа уух

Яагаад энэхүү аминдэм, бичил тэжээлийг уудаг вэ?

- Жирэмсэн үед цус багадах, хоол тэжээлийн бусад дутлуудад өртөх эрсдэл өндөр байдаг,
- Цус багадалт нь хугацаанаас өмнө төрөх, жирэмсэн болон төрөлтийн үед хүндрэл гарах, хүндээр өвдөхөд хүргэдэг.
- Төмөр нь цус багадахаас сэргийлж, ургийн өсөлт хөгжил, оюуны чадавхид эерэгээр нөлөөлдөг.

Төрсөн эх ОНБТБ, төмрийн бэлдмэл ба А аминдэмийг уух нь ямар ач холбогдолтой вэ?

- Эхийн тамир тэнхээ, хүч чадал, хоол тэжээлийн бодисуудын нөөцийг сэлбэх
- Эхийн төрөлтийн үед алдсан цусыг нөхөх

Төрсөн эх ОНБТБ ба А аминдэмийг хэзээ, яаж уух ёстой вэ?

- Төрөөд **45** хоногийн дотор **1** ширхэг А аминдэмийг уух ба энэ хугацаанаас хойш А аминдэмийг уух шаардлагагүй.
- ОНБТБ-ийг төрөөд **1** сар болсон үеэс нь эхлэн **4** сарын турш хоолны дараа уух


0-5 хүртэлх нас (0-59 сар)-ны хүүхдэд ОНБТБ болон А, Д аминдэмийг уулгана.

Хүүхдэд ОНБТБ болон А, Д аминдэмийг хэзээ уулгах вэ?

- А аминдэмийг 6-59 сартай хүүхдэд жилд 2 удаа 5 ба 10 дугаар сард уулгах
- Д аминдэмийг дутуу төрсөн хүүхдэд төрсний дараах 14 хоногтойгоос 23 сартайд, харин хугацаандаа гүйцэд жинтэй төрсөн 1-23 сартай хүүхдэд намар, өвөл, хаврын улиралд сар бүр уулгах
- ОНБТБ-ийг 6, 12, 18, 23 сартай хүүхдэд өдөр бүр 1 ширхэгийг хоолтой нь хольж 2 сарын турш өгөх

ОНБТБ болон А, Д аминдэмийг уухын ач холбогдол юу вэ?

- Хүүхдийн бие махбодын өсөлт, хөгжлийг хангах
 - Хүүхдийн оюун ухааны чадавхийг сайжруулах
 - Хүүхдийн өвчин эсэргүүцэх чадвар, дархлааг бэхжүүлэх
 - Рахит, цус багадалтаас сэргийлж, хүүхдийн харааг сайжруулах
- Өрхөд энэ насны эмэгтэй байхгүй бол үнэлгээ хийхгүй.



Г.БЗХӨ⁵, ХДХВ/ДОХ⁶, сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт

Өрхийн бүх гишүүд тухайн өвчний талаар мэдлэгтэй, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг дадал хэвшилтэй байх ёстой.

12.а БЗДХ, ХДХВ/ДОХ нь ямар замаар дамжих вэ?

- Бэлгийн зам: БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдвартай хүнтэй хамгаалалтгүй /бэлгэвчгүй/ бэлгийн хавьталд орох
- Цусаар: Халдварлагдсан цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх, эд эрхтэн шилжүүлэн суулгах, зүү тариурыг дамжуулан хэрэглэх
- ХДХВ-ийн халдвартай эхээс хүүхдэд: жирэмсэн үед, төрөх үед болон төрсний дараа хөхний сүүгээр

БЗДХ, ХДХВ¹⁰/ДОХ нь ямар замаар дамжихгүй вэ? ХДХВ хүний биеийн гадна удаан амьдарч чаддаггүй учраас

- Шүлс
- Нулимс
- Хоол хүнс, аяга халбагаар
- Агаар дуслын зам /ханиах, найтаах зэрэгт шүлсээр/
- Шумуул болон бусад төрлийн хорхой шавьж
- Хамт амьдрах, ажиллах, суралцах
- Тэврэх, үнсэх
- Бассейн, халуун ус, бие засах газар зэрэгт орох зэрэг нь аюулгүй юм.
- Гэхдээ шүдний сойз, сахлын хутга зэрэг арьс салст гэмтээдэг багаж хэрэгслийг хамтран хэрэглэх нь аюултай юм.

Шинж тэмдэг.

ХДХВ нь хүний дархлалын тогтолцоог гэмтээж дархлааг бага багаар сулруулсаар алдагдуулдаг. Тухайн хүний биеийн эсэргүүцлээс хамаарч дархлалын тогтолцоог гэмтээх явц нь 6 сараас 10 гаруй жил үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд тухайн хүнд зовиур илрэхгүй эрүүл хүн шиг байх боловч, бусдад халдвар тараах эрсдэлтэй байдаг. Энэ үед вирус зөвхөн дархлалын тогтолцоонд чухал үүрэгтэй Т4 эсийг гэмтээдэг.

Дархлалын систем сулрах тусам тухайн хүн жингээ алдаж, ядрамтгай болж, янз бүрийн арьсны өвчин, элдэв яр шарх, мөөгөнцөр болон шингэн алдах зэргээр аливаа халдварт өртөмтгий болдог. Улмаар уушгины үрэвсэл, хомхой, сүрьеэ, хорт хавдар зэрэг илүү ноцтой хүнд өвчнүүдэд өртөнө. ДОХ өвчний үед ямар ч шалтгаангүйгээр дараах шинж тэмдгүүд ихэнхдээ илэрдэг:

- Биеийн жин буурах

5 БЗДХ-Бэлгийн замаар дамжих халдвар

6 ХДХВ-Хүний дархлалын хомсдлын вирус, ДОХ-Дархлалын олдмол хомсдол

- Байнга ядрах
- Шөнө хөлрөх
- Хүзүү, суга, цавины булчирхай томрох
- Амьсгаадах, хуурай ханиах

БЗДХ-ын үед ямар шинж тэмдгүүд зонхилон илрэх вэ?

- Бэлэг эрхтнээс хэвийн бус ялгадас гарах
- Бэлэг эрхтэн орчим загатнах, улайх, хорсох
- Бэлэг эрхтэн дээр яр, шарх, тууралт гарах
- Бэлгийн хавьтлын үед өвдөх, эвгүй үнэр үнэртэх

Бид бэлгийн замаар дамжих халдвараас хэрхэн урьдчилан сэргийлэхийн тулд юуг анхаарах вэ?

- Хайр сэтгэлдээ үнэнч байж, бие биеэ хүндэтгэх,
- Тохиолдлын бэлгийн хавьталд орохгүй байх, бэлгэвчийг тогтмол хэрэглэх, тэвчих
- Архи, мансууруулах бодисоос хол байх
- Насанд хүрэгчид болон үе тэнгийнхний дарамт шахалт, уруу таталтад орохгүй байх
- Насанд хүрэгчдийг дуурайхгүй байх, өөрийгөө хамгаалах
- Өсвөр үеийнхэн бэлгийн харьцаанд яарахгүй байх
- Зөв шийдвэр гаргах, өөртөө хариуцлагатай байх
- Хосууд бэлгийн амьдралын талаар илэн далангүй ярилцах
- Үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдах, шаардлагатай тохиолдолд эмчилгээг хийлгэх

Эмчилгээ:

- БЗДХ нь эмчийн заавар, зөвлөгөөний дагуу эмчилгээ хийлгэснээр бүрэн эмчлэгдэх боломжтой юм.
- ДОХ болон ХДХВ-ийн эсрэг эмчилгээ нь зөвхөн вирусийн хөгжлийг саармагжуулах, дархлааг дэмжих төдий л байгаа бөгөөд одоогоор мэдэгдэж буй бүрэн төгс эмчилгээ байхгүй байна. Гэхдээ үүсэх шалтгаан болон урьдчилан сэргийлэх арга замуудыг тогтоосон юм.
- ДОХ нь одоогоор төгс эмчилгээгүй үхэлд хүргэдэг өвчин. Гэхдээ ДОХ-оос урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой.

Сүрьеэ өвчин нь янз бүрийн эрхтэн түүний дотор уушгинд гол төлөв нэг ба түүнээс олон үрэвслийн голомт үүсгэдэг халдварт өвчин юм. Сүрьеэ өвчний үүсгэгчийг анх нээсэн хүний нэрээр Кохын савханцар гэж нэрлэдэг бөгөөд уг савханцар нь газарт, цасанд, спирт, шүлтэнд маш тэсвэртэй оршин байдгаараа бусад нян бактериудаас ялгаатай. Зөвхөн өндөр температур, нарны туяаны шууд тусгал, хлор агуулсан бодист л үхдэг байна.

Сүрьеэ өвчнөөр халдварлахад дан ганц сүрьеэгийн бактери хангалтгүй байдаг. Учир нь дархлаа сайтай тохиолдолд сүрьеэгийн өвчин үүсгэгчийг

устгадаг. Зарим хүмүүсийн хувьд өвчин үүсэгчийг устгахгүй боловч идэвхжлийг тодорхой хэмжээгээр барьж саатуулж байдаг. Харин хүний биеийн дархлаа сулрах тохиолдолд энэ нь сэргэж өвчлүүлдэг.

Сүрьеэгээр өвчлөхөд ямар хүчин зүйлс нөлөөлдөг вэ?

- Байгаль нийгмийн орчны таагүй байдал
- Хоол хүнсний дутагдал, хангалтгүй хооллолт
- Архи тамхины хэрэглээ, мансуурах бодис хэрэглэх
- Стресс
- Дархлаа сулрах
- Дагалдах өвчнүүд

Сүрьеэгийн халдвар амархан дамждаг. Учир нь сүрьеэ өвчнөөр өвдсөн хүний ярих, найтаах, ханиах зэрэгт эргэн тойронд нь өвчин үүсгэгч савханцар нь тархаж байдаг.

Уушгины сүрьеэ өвчнөөр өвдөхөд ямар шинж тэмдэг илэрдэг вэ?

- Бие сулрах, амархан ядрамтгай болох
- Хооллох дур багасах, богино хугацаанд 5-10 килограммаар турах
- Шөнө их хөлрөх, халуурах, биеийн хүчний ажил хийхэд амьсгаадах
- Ханиалгах, цустай цэр гарах, нүдний харц хурц, гялалзсан болох

Халдвар авсан хүн болгон шууд өвчлөхгүй хэдий ч нян тээгч болдог бөгөөд өөрөөр хэлбэл халдвар тараагч болно. Сүрьеэ нь бүрэн эдгэрдэг өвчин бөгөөд гол нь зөв эмчлэх хэрэгтэй. Сүрьеэ өвчнийг эмчлэхдээ сүрьеэгийн эсрэг хэд хэдэн эмийг уух замаар эмчилнэ. Мөн үүний зэрэгцээ дархлаа сайжруулах, нөхөн сэргээх зэрэг эмчилгээнүүдийг хавсран хийх нь үр дүнтэй байдаг. Буруу эмчлэх, эмчилгээний дэглэмийг нарийн баримтлахгүй байх нь сүрьеэ өвчнийг ужиграх, эмчлэхэд төвөгтэй эмэнд дасал болсон өвчин болгох аюултай.

Сүрьеэ өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

- Ханиах үедээ буруу харах, эсвэл амаа алчуур буюу цаасан салфеткаар таглах
- Хэрэглэсэн алчуураа сайтар угаах, тусдаа аяга, таваг хэрэглэх
- Халдваргүйжүүлэх зорилгоор хлорын уусмалыг хэрэглэх
- Хөнжил, бүтээлэг зэрэг даавуун эдлэлийг нарны шууд гэрэлд тавих хэрэгтэй.

Урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагддаг гэдэгт жилдээ ядаж нэг удаа хамрагдахыг ойлгоно

Дараах асуултын дагуу үнэлгээ хийнэ.

А.Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт

- Өрхийн бүх гишүүд урьдчилан сэргийлэх үзлэгт жилдээ ядаж нэг удаа хамрагддаг бөгөөд шаардлагатай үедээ эрүүл мэндийн үйлчилгээ бүрэн авч чаддаг бол 3
- Өрхийн гишүүд урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэдэггүй, эрүүл мэндийн үйлчилгээг шаардлагатай зарим үед авч чаддаггүй бол 2

- Өрхийн гишүүд урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэдэггүй, эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай үедээ огт авч чаддаггүй бол 1

Б.Тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналт, дархлаажуулалт

- Хүүхдүүд өсөлт хөгжлийн хяналт, дархлаажуулалтад тогтмол хамрагддаг бол 3
- Хүүхдүүд өсөлт хөгжлийн хяналт, дархлаажуулалтад тогтмол бус хамрагддаг бол 2
- Хүүхдүүд өсөлт хөгжлийн хяналт, дархлаажуулалтад огт хамрагддаггүй бол 1

В. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хяналт, үйлчилгээ

- НҮЭМ-ийн хяналт, үйлчилгээнд тогтмол хамрагддаг бол 3
- НҮЭМ-ийн хяналт, үйлчилгээ авахаар эмнэлэгт хандаж байгаагүй бол 2
- НҮЭМ-ийн хяналт, үйлчилгээний талаар мэдлэг, мэдээлэлгүй бол 1

Г.БЗХӨ, ХДХВ/ДОХ, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт

- Эдгээр өвчний талаар сайн мэдлэгтэй, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг бол 3
- Эдгээр өвчний талаар мэдлэг тааруу, урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлэгт хандаж байгаагүй бол 2
- Эдгээр өвчний талаар мэдлэг муу, мэдээлэл, үйлчилгээ хаанаас авахаа мэддэггүй бол 1

Д. БОЛОВСРОЛ, ТЕХНОЛОГИ

9. СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ



А.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдалт (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оруулна)

Хүүхэд бүхэн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох эрхтэй. Эцэг эхчүүд 0-2 настай хүүхдээ гэрээр хөгжүүлж, 2-5 насанд нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулна. Байнга шинийг олж мэдэх гэсэн танин мэдэхүйн хүсэл тэмүүлэл, эрмэлзэлтэй, өсөлт хөгжил нь

эрчимтэй явагддаг бага насандаа хүүхэд бүр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүртэх ёстой.

Хэрэв өрх 2-5 насны хүүхэдгүй бол үнэлгээ хийхгүй



Б.Ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт (6-18 насны хүүхэд)

(Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүнд, хөнгөн хэлбэрээс хамааралгүй оруулна)

“Хүн бүр сурч боловсрох эрхтэй” хэмээн Үндсэн хуулинд заасан. Төрөөс байгаль, нийгэм хийгээд эдийн засгийн шинжтэй бүхий л эрсдэлээс хамгаалах гол зэвсэг бол Боловсрол хэмээн онцлон үзэж, боловсролыг тэргүүлэх салбар болгосон байна.

Хүүхдийг 6 наснаас эхлэн сургуульд элсэн суралцуулж, боловсролыг дараах үе шаттай эзэмшүүлнэ. Үүнд:

- Бага боловсролыг 5 жилд,
- Суурь боловсролыг 9 жилд,
- Бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшүүлнэ.

Хэрэв өрх 6-18 насны хүүхэдгүй бол үнэлгээ хийхгүй.



В.Боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдалт (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оруулна)

Сургууль завсардсан хүүхдийг боловсрол нөхөн олгох албан бус сургалтад хамруулна. Манай улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд албан бус боловсролын нэг салбар хэсэг нь бага, дунд, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн

сургалт юм.

Сургууль завсардсан болон ийм үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхэд байхгүй бол үнэлгээ хийхгүй.

Сургалтын төрийн сангаас дараах суралцагчид сургалтын төлбөр олгоно:

- бүтэн өнчин суралцагч;
- хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч;
- хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;
- багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь.

Сургалтын төрийн сангаас дараах суралцагчид амьжиргааны зардал олгоно:

- багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх суралцагчид тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны зардал.

Дараах асуултын дагуу үнэлгээ хийнэ.

А. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдалт (2-5 насны хүүхэд)

- 0-2 насны бүх хүүхэд цэцэрлэгт, эсвэл хувилбарт сургалтад хамрагддаг бол 3
- 0-2 насны хүүхдүүдийн зарим нь цэцэрлэг болон хувилбарт сургалтад хамрагдаж чаддаггүй бол 2
- 0-2 насны хүүхдүүд цэцэрлэг, хувилбарт сургалтын алинд ч хамрагддаггүй бол 1

Б. Ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт

- 6-18 насны бүх хүүхэд сургуульд суралцдаг бол 3
- 6-18 насны сургууль завсардсан хүүхэдтэй бол 2
- 6-18 насны бүх хүүхэд сургуульд сурдаггүй бол 1

В. Боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдалт

- Сургууль завсардсан бүх хүүхэд боловсрол нөхөн олгох сургалтад хамрагддаг бол 3
- Сургууль завсардсан хүүхдүүдээс зарим нь боловсрол нөхөн олгох сургалтад хамрагддаггүй бол 2
- Сургууль завсардсан бүх хүүхэд боловсрол нөхөн олгох сургалтад хамрагддаггүй бол 1

10. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО



А.Мэдээллийн хэрэгсэл (Радио, ТВ, сонин гэх мэт)

Өрх цаг үеийн болон бусад шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь авах, нийгмийн амьдралд оролцох, байгалийн гамшиг, цаг агаарын мэдээ, авч, урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн хэрэгслийн аль нэг төрлийг тогтмол хэрэглэж занших хэрэгтэй.

Радио, телевиз, сонин хэвлэлийг тогтмол хэрэглэхийн ач холбогдол юу вэ?

- Цаг үеийн мэдээллийг цаг хугацаанд нь авах

- Өрхөд шаардлагатай мэдээллийг авах
- Нийгмийн амьдралд оролцох
- Ажлын байр, шаардлагатай үйлчилгээнд хамрагдах
- Байгалийн гамшиг, цаг агаарын мэдээ авч, урьдчилан сэргийлэх



Б.Харилцаа холбоо (Суурин болон гар утас, интернет гэх мэт)

Өрх аюулд өртөх, өвдөх, осол эндэгдэл тохиолдох зэрэг эрсдэлтэй үед тусламж авах боломжийг бүрдүүлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, бусадтай холбогдож, богино хугацаанд мэдээлэл солилцох зорилгоор холбоо харилцааны хэрэгслийг ашигладаг байх шаардлагатай.

Харилцаа холбооны хэрэгсэл (шугамын болон үүрэн утас)-ийн ач холбогдол юу вэ?

- Өрхөд галын аюул гарах, түргэн тусламж дуудах зэрэг эрсдэлтэй үед тусламж авах боломжийг бүрдүүлэх
- Аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх
- Бусадтай холбогдож, богино хугацаанд мэдээлэл солилцох
- Холбоо харилцааны хэрэгслийг ашигласан хэрэглээгээ хянаж сурах

А. Мэдээллийн хэрэгсэл

- Өрх мэдээллийн хэрэгсэл тогтмол хэрэглэдэг бол 3
- Өрх мэдээллийн хэрэгсэл тогтмол бус хэрэглэдэг бол 2
- Өрх мэдээллийн хэрэгсэл огт хэрэглэдэггүй бол 1

Б. Харилцаа холбоо

- Өрхөд харилцаа холбооны хэрэгсэл хүртээмжтэй бол 3
- Өрхөд харилцаа холбооны хэрэгслийн хүртээмж дунд зэрэг бол 2
- Өрхөд харилцаа холбооны хэрэгсэл байхгүй бол 1

11. НИЙГМИЙН ХАЛАМЖ



А.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дор дурдсан иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй:

- 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй /насыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн жил бүр 6 сараар нэмэгдэхээр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, нийгмийн

халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулсан./

- 16 насанд хүрсэн одой иргэн,
- Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд.

60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- өргөдөл (маягтын дагуу)
- 2 хувь зураг
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт

Ахмад настан нийгмийн халамжийн тэтгэвэр 140,000 төгрөгийг сар бүрийн 15-наас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

16 насанд хүрсэн одой иргэн нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- өргөдөл (маягтын дагуу) тодорхойлолт
- сум, хорооны Засаг даргын тодорхойлолт
- 2 хувь зураг
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт
- одой болохыг тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр

16 насанд хүрсэн одой иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр 140,000 төгрөгийг сар бүрийн 15-наас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- өргөдөл (маягтын дагуу);
- 2 хувь зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- 16 нас хүрээд нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгож байгаа иргэнээс бусад иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт;

- сум, хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр
- аймаг, дүүргийн засаг даргын захирамж.

Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр 140,000 төгрөгийг сар бүрийн 15-наас тухайн сар дуустал хугацаанд харъяа банкнаас тэтгэврийн дэвтэр, иргэний үнэмлэхтэйгээ очиж авна.

Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж сум, хорооныхоо нийгмийн ажилтанд өгнө.

- өргөдөл (маягтын дагуу)
- 2 хувь зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- тэжээгчийн нас барсны гэрчилгээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, тэдгээрийн хуулбар;
- 18 хүртэлх насны хүүхдийн төрсний гэрчилгээ, эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний үнэмлэх, тэдгээрийн хуулбар
- сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- 16 нас хүрээд нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгож байгаа иргэнээс бусад иргэнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт;
- сум хорооны амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр, аймаг, дүүргийн засаг даргын захирамж,

Тэтгэвэр тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа:

- Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.
- Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ.

Тэтгэвэр тэтгэмж олгох

- Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг банкаар дамжуулан олгоно
- Тэтгэвэр, тэтгэмж авагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргавал улиралд олгох тэтгэвэр, тэтгэмжийг тухайн улирлын эхний сард бөөнөөр нь олгож болно
- Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг түүний итгэмжлэгдсэн иргэнд, эсхүл нийгмийн халамжийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан гэрт нь хүргэж өгнө.
- 16 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.
- Иргэн хүсэлтээ гаргасан тохиолдолд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг тухайн иргэний хадгаламжийн дансанд

нь шилжүүлж болно.

Нийгмийн халамжийн тэтгэмж дараах төрөлтэй байна:

1. асаргааны тэтгэмж;
2. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж;
3. онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;
4. жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж;
5. хүүхдийн мөнгөн тэтгэмж.

Асаргааны тэтгэмж болох 64,000 төгрөгийг дараах иргэнд сар бүр олгоно:

- a. бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;
- b. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхэд, хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- c. тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- d. эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа.

Асаргааны тэтгэмж олгох

- Асаргааны тэтгэмжийг сар бүрийн 15-наас хойш харъяа банкнаас хүлээн авна.
- Асаргааны тэтгэмжийг хөдөлмөрийн насны иргэнээс гадна ахмад настан болон 16-гаас дээш насны хүүхдэд олгож болно. (МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох журам»-ын 4.6-д зааснаар)
- Асаргааны тэтгэмжийг асруулагч тус бүрээр тооцож олгоно. Нэг иргэн нэг хаяг дээр оршин суугаа 3-аас дээшгүй иргэнийг асарч болно. (МУЗГ-ын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох журам»-ын 4.5-д зааснаар)

Нийгмийн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлэх бөгөөд нийгмийн халамжийн сангаас сар бүр тэтгэмж олгоно.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно:

- a. гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар

гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхөд 1,200,000 төгрөгийг нэг удаа;

- b. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд 1,200,000 төгрөгийг нэг удаа;
- c. хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд 1,200,000 төгрөгийг нэг удаа;
- d. улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхдээс бусад хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд 2 ихэр бол 1,000,000 төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр бол 3,000,000 төгрөгийг нэг удаа;
- e. 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд сар бүр 140,000 төгрөг
- f. 16-аас дээш насны байнгын асаргаа шаардлагатай иргэнд улирал бүр 60,000 төгрөг;
- g. Гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэгт жилд 1 удаа 120,000 төгрөг;
- h. “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонтой эхэд жил бүр 1 удаа 200,000 төгрөг;
- i. “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эхэд жил бүр 1 удаа 100,000 төгрөгийн тэтгэмж олгоно.

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж

- Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийг эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр 40,000 төгрөг олгоно.

2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Эх, олон хүүхэдтэй өрх тойлгойлсон эцэг эхэд тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн :

- 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхэд сар бүр Засгийн газраас тогтоосон хэмжээний /50,000 төгрөг/-ийн тэтгэмж олгоно;
- гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд улирал бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү /одоо 240,000 төгрөг байна/ хэмжээний тэтгэмж олгоно.
- Хэрэв эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.

Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжид хамрагдах иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлэн сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө. Үүнд:

- өргөдөл (маягтын дагуу);
- 2 хувь зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт;

- сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
- Жирэмсэн үедээ эмнэлгийн хяналтад орсон тухай болон төрсний дараа хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай суманд бол сумын их эмч, хороонд бол өрхийн эмчийн тодорхойлолт;

Тэтгэвэр тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа

- Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.
- Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлүүлнэ.

Өрхийн гишүүдийн хувьд халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй, эсвэл шаардлагагүй бол үнэлгээг хийхгүй.



Б.Нийгмийн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

а. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;

б. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
- зөвлөгөө өгөх;
- сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- түр байрлуулан асрамжлах;
- өдрийн үйлчилгээнд хамруулах;
- гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэнийг өрхийн хөгжлийн дэвтэрт бичихгүй.

Нийгмийн хөгжлийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- Боловсролыг дэмжих үйлчилгээ: Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхийн хүүхэд сургуулийн өмнөх боловсролын болон

ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх;

- б. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ: Өрхийн гишүүн иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлдөг болон эрүүл мэндийн бусад үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх; /энэ хүрээнд хүнсний эрхийн бичиг авч байгаа хөдөлмөрийн насны иргэд эрүүл мэндийн даатгалаа төрөөс нөхөн төлүүлэх боломжтой. Эдгээр иргэдийн регистрийн дугаарыг харьяа аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газарт хүргүүлж хөнгөлөлтөд хамруулна./
- с. Хүнс тэжээлийн дэмжлэг: хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох.

Боловсролыг дэмжих үйлчилгээ одоогоор хэрэгжиж эхлээгүй байна.

2009-2012 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр” төслийн хүрээнд бага орлоготой өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүнсний талон хөтөлбөрийг анх хэрэгжүүлж эхэлсэн. 2013 оноос Нийгмийн халамжийн тухай хуульд шинэ үйлчилгээ болж орсон бөгөөд “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн ХАХНХ-ын сайдын А/18 тоот тушаалаар батлан хүнсний эрхийн бичиг олгох ажлыг зохион байгуулж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.1 дэх хэсэгт зааснаар орлогыг орлуулан тооцох аргаар амьжиргааны түвшингээ үнэлүүлж, мэдээллийн санд орсон иргэдээс хамгийн бага амьжиргаатай буюу батлагдсан босго онооноос доогуур үнэлгээтэй нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгож байна. Хүнсний цаасан болон цахим эрхийн бичиг нь сар бүр том хүн 13,000 төгрөг хүүхэд 6,500 төгрөг байх юм.

Өрхийн гишүүдийн хувьд халамжийн үйлчилгээ авах нөхцөл, эрх үүсээгүй бол үнэлгээ хийхгүй.



В. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлт

Ахмад настан:

- Хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа, шүд /үнэт металлаар хийхээс бусад/- ний протезийн дотоодод хийлгэсэн зардлын үнийг гурван жилд нэг удаа тус тус нийгмийн халамжийн, эсхүл эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олгох;

- Ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр

олгох;

- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор

ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

- Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох;
- Ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксианаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих бөгөөд нийтийн тээврийн байгууллага ахмад настныг нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;
- Эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
- Нийслэлээс 1000 километр ба түүнээс хол алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлэг тухайн ахмад настанд дараалал харгалзахгүй үйлчилж, унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
- алдар цолтой ахмад настанд төрөөс олгох нэмэгдэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезын үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;
- 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;
- Насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;
- Дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;
 - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан, сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах;
- Бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
- Нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;
- Хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;
- Хийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;
- Аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

Дараах асуултын дагуу үнэлгээ хийнэ

А. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж

- Өрхийн гишүүд хуульд заасан нөхцлөөр халамжийн тэтгэвэр, тэтгэмж бүрэн авдаг бол 3
- Өрхийн гишүүд хуульд заасан нөхцлөөр халамжийн тэтгэвэр, тэтгэмжээс заримыг нь авч чаддаггүй бол 2
- Өрхийн гишүүд хуульд заасан нөхцлөөр халамжийн тэтгэвэр, тэтгэмж авч чаддаггүй бол 1

Б. Нийгмийн халамжийн үйлчилгээ

- Өрхийн гишүүд хуулийн дагуу хамрагдах боломжтой халамжийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаг бол 3
- Өрхийн гишүүд хуулийн дагуу хамрагдах боломжтой зарим үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй бол 2
- Өрхийн гишүүд хуулийн дагуу хамрагдах боломжтой халамжийн үйлчилгээнд огт хамрагдаж чаддаггүй бол 1

В. Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлт

- Өрхийн гишүүд боломжит нийгмийн хөгжлийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаг бол 3
- Өрхийн гишүүд боломжит нийгмийн хөгжлийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаггүй бол 2
- Өрхийн гишүүд боломжит нийгмийн хөгжлийн үйлчилгээнд огт хамрагдаж чаддаггүй бол 1

12. НИЙГМИЙН ДААТГАЛ



А. Нийгмийн даатгалд хамрагдалт, ашиглалт

- Өрхийн хөдөлмөрийн насны бүх гишүүдийн хувьд нийгмийн даатгалд хамрагддаг эсэхийг үнэлнэ. Үнэлгээг хийхдээ нийгмийн даатгалд албан журмаар эсвэл сайн дураар хамрагддаг эсэх, эрүүл мэндийн даатгалаас бусад даатгалын төрлөөс хуульд заасан нөхцлөөр үр шимээ хүртэж чадаж байгаа эсэхийг мөн давхар тодруулна.

Нийгмийн даатгал гэдэг нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, даатгуулагч

нас барахад түүний асрамжид байгаа хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгал нь:

- Албан журмаар даатгуулах
- Сайн дураар даатгуулах гэсэн хоёр төрөлтэй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлөх даатгуулагчид

- өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
- Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
- төрийн албан хаагч;
- хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол улсын иргэн.

Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас бусад иргэн сайн дураар нийгмийн даатгалд хамрагдаж болно. Тухайлбал:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Малчин
- Газар тариалан эрхлэгч
- Бичил уурхай эрхлэгч
- Чөлөөт уран бүтээлч

Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн

- Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн
- Оюутан, суралцагч
- Бусад иргэн

Хүснэгт 8. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Сайн дурын даатгуулагч
Тэтгэврийн даатгал	7.0	7.0	10
Тэтгэмжийн даатгал	0.8	0.8	1
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0	2,0
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	0,8-2,8	-	1,0
Ажилгүйдлийн даатгал	0.2	0.2	-
Шимтгэлийн дүн	10.8-12,8	10.0	12,0

Сайн дураар даатгуулагч шимтгэл төлөх сарын орлогоо өөрөө тодорхойлох бөгөөд энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, шимтгэл төлөх сарын дээд хэмжээнээс ихгүй байна.

Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу шимтгэл төлсөн даатгуулагч нийгмийн даатгалын сангаас дараах тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүснэ. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж
- Ажилгүйдлийн тэтгэмж

Өндөр насны тэтгэврийг хэзээ авах вэ?

- Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.
- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч дор дурдсан болзлыг хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:
 - нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас хүрсэн бол;
 - нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 45 нас хүрсэн бол;
 - нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 45 нас хүрсэн бол;
- Хуульд заасан тэтгэвэр тогтоолгох нас нь хүрээгүй даатгуулагч мөн хэсэгт заасан шимтгэл төлөх хугацааг хангаад цаашид тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөө зогсоосон байхад түүний уг насанд хүрээд өндөр насны тэтгэврээ тогтоолгон авах эрх нь хадгалагдана.
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй шимтгэл төлсөн нийт хугацаандаа

ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.

- Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-оос доошгүй жил ажилласан, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил дурьдсан мэргэжлээр ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэн, мөн 25-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг даатгагч хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал олгоно.
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний 1,5 хувиар бодож нэмэгдэл олгоно.
- Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр
- Хөдөлмөрийн дэвтэр
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах, эсхүл архивын лавлагаа
- 1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд батлагдсан маягтын дагуу тухайн ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагаар, эсхүл архивын сан хөмрөгөөс гаргуулсан лавлагаа,
- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- 2 хувь цээж зураг /3*4 хэмжээтэй/

Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх хэрхэн үүсэх вэ?

- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнө 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- Хуульд заасан шимтгэл төлөх хугацааг хангаагүй даатгуулагч нийтдээ 3-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.
- Тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас

барвал нас барсны дараагийн сар дуустал олгоно.

Бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр
- 1995 оноос өмнөх хугацаанд ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах, эсхүл архивын лавлагаа
- 1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд батлагдсан маягтын дагуу тухайн ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагаар, эсхүл архивын сан хөмрөгөөс гаргуулсан лавлагаа,
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр
- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- 2 хувь цээж зураг /3*4 хэмжээтэй/

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх хэрхэн үүсэх вэ?

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан даатгуулагч нийтдээ 20 ба түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, эсвэл нас барахын өмнөх 5 жилийн 3 жилд нь тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.
- Хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахгүйгээр төрүүлсэн буюу үрчлэн авсан 19 нас хүрээгүй хүүхэд
- Хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 19 нас хүрээгүй ач, зээ, төрсөн дүү;
- Тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн тахир дутуу буюу 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү;
- Эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл тахир дутуу болсон эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэжээх өөр хүнгүй өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;
- Найман нас хүрээгүй хүүхэд, хууль ёсоор асрах хүнгүй төрсөн дүү, ач, зээг нь асарч ажил хийгээгүй байгаа эцэг, эх буюу нөхөр, эхнэрийн аль нэг /нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр/.

Дор дурдсан иргэд гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нэгэн адил тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

- Өндөр насны, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад нас барсан, түүнчлэн нас барахын өмнөх саруудад хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд;
- Төрсөн эцэг, эхээс шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдаггүй хүүхэд хойд эцэг буюу эхийгээ нас барахад төрсөн хүүхдийн адил;
- Дагавар хүүхэд нь тэжээгч байгаад нас барсан бол хойт эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил;
- Даатгуулагч сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, уг шийдвэр хүчинтэйд тооцогдсон тохиолдолд түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 5-аас доошгүй жил, үүнээс 1 жил нь тасралтгүй төлсөн тэжээгч нас барсан бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь түүний шимтгэл төлсөн нийт хугацаанд ногдох тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй. Тэжээгч нь нас барсан бөгөөд өөр төрлийн тэтгэвэр авдаггүй тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хугацаанд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоон олгож болно.

Хүснэгт 9. Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл

Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо	Тэтгэвэр бодох хувь хэмжээ / хувиар/
3, түүнээс дээш	100
2	75
1	50

Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ нь хөдөлмөрийн баталгаат хөлсний 50 хувиас багагүй байна.

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох хугацаа:

- Тэжээгчээ алдсаны тэтгэврийг гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнд нэгтгэн нэг тэтгэвэр тогтооно. Харин тогтоосон тэтгэврийг тэдний хүсэлтээр хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд адил хэмжээгээр хуваан олгож болно.
- Тахир дутуугийн тэтгэвэр авч байсан тэжээгч нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1,0 хувиар бодож нэмэгдүүлнэ.
- Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барсан өдрөөс эхлэн хүүхдэд 19 нас хүртэл, тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд нь, тэтгэврийн насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сар дуустал тус тус олгоно.

Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх

- Та ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, түүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй.

Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ

Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын орлогын дунджаас дараах хувиар бодож олгоно

Хүснэгт 10. Ажилгүйдлийн тэтгэмжийн шимтгэлийн хэмжээ

Шимтгэл төлж ажилласан хугацаа/жилээр/	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	45
5-10хүртэл жил	50
10-15 хүртэл жил	60
15 ба түүнээс дээш жил	70

Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно. Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.



Б.Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, ашиглалт

Эрүүл мэндийн даатгал. Эрүүл мэндийн даатгал нь нийгмийн даатгалын нэг бүрэлдэхуун хэсэг бөгөөд өөрийн эрүүл мэндээ даатгуулж, тодорхой хувиар тогтоосон хэмжээгээр шимтгэл урьдчилан төлж, төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжид заасан тусламж, үйлчилгээнд хамрагдахыг хэлнэ.

Эрүүл мэндийн даатгалын төрөл

- Албан журмын даатгал
- Сайн дурын нэмэлт даатгал

Даатгуулагч иргэн

- Монгол улсын иргэн бүр
- Гадаадын иргэн, харъяалалгүй хүн

Ямар иргэд шимтгэлээ өөрөө хариуцан төлөх вэ?

- Оюутан суралцагсад
- Малчид
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн

Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн

Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг дээрх иргэн-даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээий зардлын төлбөр нь тухай жилийн дээд хязгаар /2,0 сая төгрөг/-аас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэгдаатгуулагч- гишүүний зөвшөөрснөөр түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах эрхтэй.

Ямар иргэдийн шимтгэлийг төр хариуцан төлөх вэ?

- 0-18 насны хүүхэд
- Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн
- Хүүхдээ 2, /ихэр бол 3/ нас хүртэл өсгөн бойжуулж байгаа эх/эцэг
- Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг “Үндэсний зөвлөл”-ийн саналыг үндэслэн Засгийн газар тогтоодог.

Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээ

Даатгуулагчийн төрөл	Шимтгэлийн хувь, хэмжээ	Шимтгэлийг хариуцан төлөх эзэн
⇒ Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс: Ажил олгогч-2 хувь Даатгуулагч-2 хувь	Аж ахуйн нэгж, байгууллага, ажилтан
⇒ Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн, бусад иргэн	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувь	Өөрөө
⇒ Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан суралцагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувь	
⇒ Тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн ⇒ Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн ⇒ Хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх/эцэг ⇒ Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувь	Төр (Улсын төсвөөс)
⇒ Ял эдэлж байгаа ялтан		Хорих байгууллага
⇒ 0-18 насны хүүхэд	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувь	Төр (Улсын төсвөөс)

Эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд харъяа нутаг дэвсгэрийн Нийгмийн даатгалын байгууллагын эрүүл мэндийн даатгалын байцаагч болон тухайн байгууллагын нягтлан бодогч, санхүүгийн ажилтанд дараах материалыг бүрдүүлж өгнө.

Ямар баримт бичиг бүрдүүлэх вэ?

Шимтгэлийг төр хариуцдаг иргэд:

- Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, тэтгэврийн дэвтэр
- Нэг хувь цээж зураг
- ЭМД-ын гэрчилгээний үнэ /0-16 насны хүүхдэд гэрчилгээ авах шаардлагагүй/

Шимтгэлийг өөрөө төлдөг иргэд :

- Иргэний үнэмлэх
- Нэг хувь цээж зураг
- Гэрчилгээний үнэ төлсөн баримт
- Нэг жилийн шимтгэлээ нийгмийн даатгалын дансанд төлсөн баримт

Та эрүүл мэндийн даатгалд даатгуулснаар дараах эрхүүдийг эдлэх болно.

- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ;
- Өдрийн эмчилгээ, үйлчилгээ;
- Амбулаторийн үйлчилгээ
- Оношилгоо, шинжилгээ
- Уламжлалт эмчилгээ
- Сэргээн засах болон рашаан сувиллын тусламж, үйлчилгээ;
- Удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээ
- Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ;
- Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт;
- Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн үнийн хөнгөлөлт;
- Зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл;
- Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ;
- Гемодиализын эмчилгээ

Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцан төлөх тусламж, үйлчилгээний төрөл

№	Тусламж, үйлчилгээний төрөл	ЭМДС-аас төлөх төлбөрийн дээд хязгаар
1.	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	Даатгуулагч эдгээр тусламж, үйлчилгээнд жилдээ 2'000'000 хүртэл төгрөгийн зардлыг төлүүлэх эрхтэй
2.	Өдрийн эмчилгээ, үйлчилгээ	
3.	Амбулаторийн үйлчилгээ	
4.	Оношилгоо, шинжилгээ	
5.	Уламжлалтын эмчилгээ	
6.	Сэргээн засах болон рашаан сувиллын тусламж, үйлчилгээ	
7.	Удаан хугацааны нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээ	
8.	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	
9.	Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ	
10.	Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн үнийн хөнгөлөлт	Эдгээр тусламж, үйлчилгээ нь зардлын дээд хязгаарт хамаарахгүй
11.	Зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн үнийн хөнгөлөлт	
12.	Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ	
13.	Гемодиализийн эмчилгээ (улсын төсвөөс ЭМДС-аар дамжуулан)	

Дараах асуултын дагуу үнэлгээ хийнэ.

А. Нийгмийн даатгалд хамрагдалт, ашиглалт

- Өрхийн гишүүд хуулийн дагуу нийгмийн даатгалд албан журмаар эсвэл сайн дураар бүрэн хамрагдаж, үр шимийг нь хүртэж чаддаг бол 3
- Өрхийн гишүүдийн зарим нь хуулийн дагуу нийгмийн даатгалд албан журмаар эсвэл сайн дураар хамрагдаж чаддаггүй, заримдаа үр шимийг нь хүртэж чаддаггүй бол 2

- Өрхийн гишүүд хуулийн дагуу нийгмийн даатгалд албан журмаар эсвэл сайн дураар бүгд хамрагдаж чаддаггүй, үр шимийг нь хүртэж чаддаггүй бол 1
- Б. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, ашиглалт
 - Өрхийн гишүүд хуулийн дагуу ЭМД-д бүрэн хамрагддаг, үр шимийг нь хүртэж чаддаг бол 3
 - Өрхийн гишүүдийн зарим нь хуулийн дагуу ЭМД- хамрагдаж чаддаггүй, заримдаа үр шимийг нь хүртэж чаддаггүй бол 2
 - Өрхийн гишүүд заавал эсвэл сайн дураар бүгд ЭМД-д хамрагддаггүй, үр шимийг нь огт хүртэж чаддаггүй бол 1

ГУРАВ. ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ Ё. ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ХАРИЛЦАА

13. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА



А.Гэр бүлийн гишүүдийн харилцаа

Өөрийн гэр бүлийн харилцаандаа сэтгэл ханамжтай байгаа эсэхийг үнэлнэ. Өрхийн гишүүдийн өөрсдийн тодорхойлсноор сэтгэл ханамжийг тэмдэглэнэ.

Гэр бүлийн гишүүдийн халуун дулаан уур амьсгал, бие биедээ итгэсэн, хайрласан, дэмжсэн харилцаа нь тэдний амжилт, аз жаргалын үндэс нь билээ. Гэр бүлийн харилцаа нь хамгийн ариун нандин, үнэнч, хүндэтгэлтэй харилцаа дээр суурилдаг. Энэ харилцаанд хэн нэгний мэдлэг,

чадвар, эд хөрөнгө, байр суурь чухал биш гагцхүү бие биеэ хайрлах ухаан, сэтгэлийн тэнхээ, хүнлэг чанарууд л эн тэргүүнд тавигдана.

Монголчууд олон мянган жилийн түүхэн хөгжлийнхөө явцад гэр бүлийн харилцааны үндэсний онцлогтой, сэтгэл зүй, зан үйл, сэтгэл хөдлөл, соёл, зан заншлын дотоод хэлхээ холбоогоор батажсан, харилцааны сэтгэл зүйн цогц цул хамаарлыг бий болгосоор иржээ. Гэр бүлийн гишүүдийн сэтгэл санаа, бодол төсөөлөл нь өөр хоорондоо үл үзэгдэх шижмээр холбогдож, нэг нь нөгөөдөө ямагт тулгуур түшиг болж байдаг харилцааны сэтгэл зүйн онцлогтой байдаг байна.

Гэвч гэр бүлийн гишүүдийн нийгмийн хэрэгцээ хангагдаагүй, хувь хүний эзэлж байгаа байр суурь бодитой биш, орчныхоо хүмүүсийг хайрлах хүндэтгэл бага, өөрийгөө илэрхийлэх, батлан харуулах боломжгүй нөхцөл үүссэн зэргээс болж гэр бүлд зөрчил үүсдэг байна.

Гэр бүлийн зөрчил гэдэг нь үзэл бодол, сэдэл тэмүүлэл, чиг хандлагын зөрөөтэй байдлын үндсэн дээр гэр бүлийн гишүүдийн хооронд бий болох таарамжгүй байдал юм. Гэр бүлийн зөрчил нь дараах онцлогтой. Үүнд:

- Харилцаа хандлагын хамгийн чухал чанарыг нөхцөлдүүлж байдаг;

- Хууль зүйн үүрэг хариуцлага тэр бүр хүлээдэггүй;
- Ёс суртахуун оюун санааны үнэт зүйлийг үгүй хийдэг.

Гэр бүлийн зөрчил нь дараах шалтгаануудын улмаас үүсэх нь түгээмэл байна. Үүнд:

- Гэр бүлийн гишүүдийн чөлөөт байдал, идэвхтэй ажиллах боломж хязгаарлагдсанаас;
- Гэр бүлийн гишүүдийн зан үйлд өөрчлөлт орсноос;
- Гэр бүлийн зарим гишүүд хэрэгцээндээ сэтгэл ханамжгүй байх, түүний хүсэл эрмэлзэл сонирхолд өөрчлөлт орсноос;
- Гэр бүлд захиран тушаах, хатуу ширүүн зан харьцаа давамгайлснаас;
- Материаллаг асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учирснаас;
- Хосуудын бэлгийн хэрэгцээ хангагдаагүйгээс;
- Гэр бүлийн дотоод харилцаанд төрөл садны зүгээс хэт оролцсоноос;
- Хүйсийн онцлогоос;
- Амьдралын тодорхой өөрчлөлтөд бэлтгэгдээгүй байснаас;
- Зан харилцаа, дадал зуршлын таарамжгүй байдлаас;
- Боловсролын ялгаатай байдлаас;
- Үл итгэлцлээс.

Орчин үед хосуудын харилцааг хурцатгаж байгаа нэг гол асуудал нь тэдний ахуйн үүрэг хариуцлагын тэгш биш байдал юм. Хүйсийн онцлогоос шалтгаалсан зөрчил зайлшгүй байна. Гэр бүлийн зөрчлийг цаг тухайд нь зөв шийдвэрлэхгүй бол үр дагавар нь хүндээр тусдаг. Зөрчил бол зайлшгүй зүйл харин зөрчлийг даамжрахаас сэргийлэх нь чухал байдаг. Гэхдээ зөрчлийг шийдвэрлэх оновчтой хувилбар бол маргаантай асуудлын талаар зөвшилд хүрэх, асуудлыг харилцан ойлголцсоны үндсэн дээр тухайн нөхцөлд нь шийдвэрлэхгүй бол хуримтлагдаж явсаар хурцадмал байдалд хүрч салалтаар дуусгавар болох нөхцөлд хүрдэг.

Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа муу, зөрчилтэй байгаа нь өрхийн болон өрхийн гишүүдийн хөгжил, амьжиргаа, олот амжилтад сөргөөр нөлөөлнө. Иймд гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, харилцан итгэлцэл, хүндэтгэлийг бий болгоход хүн бүрийн хүчин чармайлт ихээхэн чухал юм.

Гэр бүлийн харилцааны тактик

Дарангуйлан захирах тактик

Гэр бүлийн аль нэг гишүүн бусдад өөрийн үзэл бодлоо тулгадаг, хэрцгий авирлаж, ноёрхуу ааш зан гаргадаг, бусад гишүүнээ тамлан зовоодог зарим тохиолдол гардаг. Нөгөө талаар хүүхдүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг үл хүндэтгэн, өөрийнхөө хүссэнээр байлгаж, дэг журам тогтоохын тулд айлган сүрдүүлж, хэт их хяналт тавьж, дарамталж эхэлнэ. Мэдээж, энэ байдлыг хүүхдүүд тэсвэрлэхгүй, гэр бүлийн харилцаанд хуурамч байдал, үл итгэлцэл үүсэх, эцэг эхийгээ үзэн ядах бодол үүсэх, гэр орноосоо дайжих, гэмт хэрэгт холбогдох зэрэг байдлыг үүсгэдэг.

Асрамжлан хамгаалах тактик

Энэ тактик нь гэр бүлийн гишүүддээ санаа тавих, элдэв хүндрэл бэрхшээлээс хамгаалах, халамж, анхаарал тавьдаг ч гэсэн тэднийг бие даах чадваргүй, санаачилгагүй, өөртэй нь холбогдсон аливаа асуудлыг шийдвэрлэх сонирхолгүй болгодог. Нөгөө талаас эцэг, эхчүүд хүүхдүүдтэйгээ маргалдан, зөрчил үүсгэхээс эмээж явсаар байвал хүүхэд өөрийгөө хэт дөвийлгөх ойлголт, хандлагатай болдог байна. Энэ тактик нь хүүхдийг аливаа асуудалд өөрийн гэсэн бодолгүй, аав ээжийн гар хардаг, ямар ч асуудлаар зөвхөн эцэг эхийн шийдвэрийг хардаг, эсвэл эсрэгээр, эцэг эх нь хэт зөөлөн, хүүхдүүдийнхээ аясаар ханддаг байсан бол ёс суртахууны хувьд эвдэрч, бусдад баярхах, дээрэлхэх, "Би" гэж өөрийгөө дөвийлгөх зэрэг сөрөг үр дагаврыг авчирдаг байна.

Мэтгэлцэн, сөргөлдөх тактик

Гэр бүлд тохиолдож буй аливаа асуудлаар гэр бүлийн гишүүд өөр өөрийн байр суурь, үзэл бодлыг хамгаалан, сөргөлдөж, улмаар таагүй уур амьсгал үүсч, улмаар түүнийгээ хамгаалан, ширүүн хэрүүл болон хувирч, түүнийг намжаах, зохицуулахад хүндрэлтэй байдал үүсч болно. Энэ байдал улам даамжирвал гэр бүл салах, үр хүүхдийн хүмүүжилд асар муугаар нөлөөлөх зэрэг үр дагаврыг авчирдаг байна.


Энх тайвнаар зэрэгцэн орших тактик

Гэр бүлийн харилцааны энэхүү тактик нь бусдын дотоод хэрэгт үл оролцох гэсэн байр сууринаас үндэслэгдсэн байна. Гэр бүлийн гишүүн бүрт өөрийн ажил, асуудал, хүндрэл бэрхшээл, ололт амжилт гээд олон асуудал байх хэдий ч энэ тактикийг баримталдаг гэр бүлийг хувьд бие биений асуудлыг хуваалцаж, сэтгэл зүрхээрээ хамт байх явдал бараг гардаггүй аж. Энэ нь ялангуяа, хүүхдийн хүмүүжилд маш их хортой юм. Эцэг эхийн хараа хяналтаас холдсон хүүхэд элдэв сөрөг нөлөөнд автах боломж их юм.

Хамтран ажиллах тактик

Энэ нь гэр бүлийн харилцааны хамгийн үр ашигтай тактик юм. Гэр бүл, гэр бүлийн гишүүдийн аливаа асуудлыг хамтран шийддэг, баяр гунигаа хуваалцдаг хамт олонч чанарыг төлөвшүүлэхэд маш чухал юм. Аливаа асуудлаар хамтын шийдвэр гаргаж, гэр бүлийн гишүүн бүр гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг нь тодорхой байдаг.

Эх үүсвэр: "Зорилтот өрхийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалтын модул" Багшийн гарын авлага



Б.Хүүхдийн хүмүүжил, халамж

Гэр бүл нь хүүхдийн хөгжлийг тэтгэгч анхдагч орчин бөгөөд хүүхдийн хөгжил төлөвшилд эцэг эхийн хоёулангийнх нь оролцоо чухал байдаг. Сэтгэл зүйчид эцэг эхийн хүүхдэдээ ханддаг харилцааг судлаад алдааг (1) хүүхдийнхээ зан авир, төлөв байдлыг хянаж чадахгүй байгаагаас (2) Хүүхдэдээ сэтгэл хөдлөлөөр харьцсанаас болж болдог гэж тодорхойлж байна. Энэ нь:

Энэ хоёрын аль нэгийг, эсвэл хоёуланг зэрэг зөрчвөл хүүхдийнхээ хөгжил, төлөвшилд ноцтой гэм учруулна. Жишээлбэл: Хүүхдийнхээ зан авир, төлөв байдалд нь зохих ёсны хяналтаа тавьж чадаагүйгээс хүүхдийн хөөрүү сэтгэлийг илүү анхаарах, хэт эрх танхи байлгаж, илүү энхрийлэх, зарчимгүй буулт хийх, хүүхдэд өөрт нь байдаг, байдаггүй сайн талыг нь байнга магтсаар байгаад хүүхдийн зан төлвийн хөөрүү /хийрхүү/ шинжийг төлөвшүүлдэг. Эцэг, эх та хүүхдэдээ хайхрамжгүй хандсанаас болж хүүхдээ өвөг дээдсийн ярьдагчлан

хүүхдээ хүн шиг хүн болгож чадахгүй, эцэг, эх та өөрсөддөө уршиг тарина.



Та хэмээс хэтэрсэн хяналт, дэндүү хатуу ёс суртахууны шаардлага хүүхэддээ тавьж, ингээд зогсохгүй хүүхдээ айлгах, сүрдүүлэх, бие даах гэж буй, бие дааж буй байдлыг анхаарахгүй, зэмлэл, шийтгэлийг зүй бусаар /ялангуяа зодох, жанчих/ арга хэрэглэснээр хүүхдийг магадгүй харгис хэрцгий араншинтай болгож, хүүхдээ дарамтын хэрэгсэл болгох, эцэг, эх та шийтгэл, өөрийн бухимдлаа хүүхэддээ хэрэгжүүлэх талбар болгож болох юм. Түүнчлэн эцэг эхтэйгээ сэтгэлийн холбоо хэлхээгүй, зохих ёсны хяналтгүй, халуун дулаан харьцаагүй, хүүхдийнхээ сонирхол, тэдэнд тохиолдож буй асуудлуудыг жижигхэн ч гэлтгүй мэдэрч туслаагүйгээс хүүхдээ орон гэрээсээ холдох, оргох, дэмий тэнэх, хэрэг төвөгт орооцолдох байдалд ч хүргэнэ. Энэ нь юуны өмнө эцэг, эх та эцэг, эхийнхээ үүргээ биелүүлэхэд сэтгэл санаа, сурган хүмүүжил, ёс суртахууны хувьд бэлтгэгдээгүй юмуу дутмаг байгаатай холбоотой.

Гэр бүл нь хүүхдийн хөгжилд шууд нөлөөлж байдаг төдийгүй нийгмийн амьдралд хөл тавих, гадаад ертөнцтэй харьцах анхны орчин нь болж өгдөг. Хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг гэр бүлийн дотоод хүчин зүйлсээс дурдвал:

- Гэр бүлийн хүндрэлтэй нөхцөл байдал:
 - Өрх толгойлсон эцэг/эхтэй
 - Өвчтэй, хөдөлмөрийн чадвараа алдсан хүнтэй
 - Гэр бүлийн дотор хэрүүл маргаантай, гэр бүлийн харилцаа алдагдсан
 - Хүүхдийн хамгаалал ба дэмжлэг дутмаг гэр бүл
- Гэр бүлийн үнэт зүйлс муутай
- Хүүхдээ хүмүүжүүлэх арга барил муутай гэх мэт.

Гэр бүлийн дотор эцэг, эхийн харилцан бие биеэ хайрлан хүндлэх сэтгэл нь хүүхдэд хүмүүжлийн юугаар ч орлуулашгүй ач холбогдолтой бөгөөд гэр бүлийн сэтгэл зүйн уур амьсгалыг сайн сайхан байх нөхцлийг бүрдүүлдэг. Эцэг эх бие биеэ хайрлаж дээдэлдэг бол тэдний хайраас хүүхэд, бүхнээс илүү ихийг амсах болно. Хүүхэд аливаа зүйлийг хийхдээ зөвхөн өөрийнхөө төлөө биш бусдын төлөө хийдэг хүмүүжилтэй болохыг хичээх хэрэгтэй.

Эцэг эхийн зүгээс хүүхэдтэй харилцах харилцаа нь тэдний хайр болон нийгмийн өмнө хүлээх үүрэг гэсэн хоёр гол сэдлээр тодорхойлогддог. Эцэг эхийн хайр халамж нь заримдаа хүүхдийнхээ аяыг дагаж, сөрөг зан чанар, хувиа бодсон байдлыг өөгшүүлсэн, ямар ч идэвхгүй, зөнгөөрөө хүн болгох нь бий.

Хүүхэд хүмүүжлийн доголдолд орох олон шалтгаан байдаг. Тухайлбал:

- Гэр бүлийн харилцаанд асуудал үүсч, бүрэн бүтэн байдал алдагдсанаас, сэтгэл ханамжгүй байдлаас,
- Гадаад орчны сөрөг нөлөөлөл, хүмүүжлийн чиг баримжааг нь алдагдуулах, тэдэнд буруу ойлголт, үзэл сонирхол, төрүүлж байдаг харш зүйлүүдээс,

- Хүүхдийн нас, бие махбод, оюун санааны хөгжлийн онцлогт тохироогүй сурталчилгаа, буруу үлгэр дууриал, зан харьцаанаас,
- Хүүхдийн хичээл сурлага, чөлөөт цаг ашиглалтад тавих анхаарал сулаас гэх мэт.

Хүүхдийн зан үйлийн алдаа дутагдлыг ойлгуулахдаа тэднийг шүүмжлэх, хийснийг нь үгүйсгэх, нэр хүндийг нь гутаан доромжлох, доголдож байгаа зүйлийг нь дахин сануулах замаар биш, харин тэдэнд итгэл найдвар төрүүлэх замаар зөвлөх, анхааруулах, үүрэг даалгавар өгөх зэргээр ажиллах нь илүү үр дүнтэй.

Эцэг эх бүр хүүхэдтэйгээ хамт инээж, тоглох, хүүхэддээ ном уншиж өгөх, уншсан номныхоо утгыг ярилцах, хүүхдийнхээ гэрийн даалгаврыг хийлгэх, хүүхдэд бэрхшээл тохиолдсон үед дэмжлэг үзүүлэх, туслахад тодорхой цаг зарцуулдаг байх ёстой.

Үнэлгээг хийхдээ сэтгэл ханамж талаас асууж, үнэлнэ. Хэрэв хүүхэдгүй өрх бол үнэлгээг хийхгүй.




В.Гэр бүлийн уламжлал, үнэт зүйлс

Гэр бүлийн үнэт зүйлс гэдэгт хамтач харилцаа, бие биеэрээ бахархах, урам хайрлаж, дэмжин талархдаг, нээлттэй, уян хатан харилцаатай, хамтдаа байх дуртай, бие биенийхээ өөр байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг, бэрхшээлийг даван туулах чадвартай байх явдлыг ойлгоно.

Уламжлалт үнэт зүйлс гэдэгт үр хүүхэд, эцэг эх, эх орон, хайр сэтгэл, итгэлцэл, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, уламжлалт ёс заншил орно.

Орчин үеийн үнэт зүйлс гэдэгт эрүүл мэнд, мэдлэг, боловсрол, нэр хүнд, удам угсаа, ажил мэргэжил, эд хөрөнгө, хүний эрх, эрх чөлөө, үзэл бодол, хууль ёсыг дээдлэх зэргийг хамруулан ойлгоно.



Г. Буруу зуршил, хэрэглээ

Архи, согтууруулах ундаа хэрэглэх нь өрхийн орлого, эдийн засагт сөргөөр нөлөөлөх, гэр бүл, найз нөхөдтэйгээ маргах, харьцааны зөрчилд орох, бодож сэтгэх, чадваргүй болох, эрүүл мэнд муудах зэрэг муу үр дагавартай. Иймд аль болох хэрэглэхгүй байх, зайлшгүй шаардлага гарвал стандарт хэрэглээнээс хэтрүүлэхгүй байх хэрэгтэй юм.

Архи согтууруулах ундааны стандарт хэрэглээ гэдэг нь ууж байгаа архи согтууруулах ундаанд агуулагдах цэвэр спиртийн хэмжээ 10-14 гр байхыг хэлнэ. Согтууруулах ундааны нэг удаагийн зохистой хэрэглээнд цагаан архи 30 мл,

шар айраг 330 мл, дарс 100 мл байна.

Архи, согтууруулах ундааны үр дагавар нь гэр бүлийн хүчирхийлэл байдаг. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр дарангуйлан эрхшээлдээ оруулж, гэр бүлийн тайван амгалан байдлыг алдагдуулахыг гэр бүлийн хүчирхийлэл гэнэ. Гэр бүлийн хүчирхийлэл нь дараах хэлбэрээр үйлдэгддэг байна.

- *Гэр бүл дэх эдийн засгийн хүчирхийлэл:* Ажлаас нь гаргах, орлогогүй болгох, хянах хавчих, хяналт тавих, эдийн засгийн эрх мэдэлгүй байлгахыг хэлнэ.
- *Гэр бүл дэх сэтгэл зүйн хүчирхийлэл:* Гэр бүлийн нэг гишүүний үйлдэлтэй холбогдон бусад гишүүдийн сэтгэл зүйд нөлөөлсөн үгээр гутаан доромжлох, заналхийлэх, мөрдөн мөшгих, айлган сүрдүүлэх замаар өөртөө итгэх итгэлгүй болгох, өөрийгөө хамгаалах чадваргүй болгох, тусгаарлах, доромжлох, ичээх, сэтгэл зүйн эрүүл мэндэд нь хохирол учруулж болох буюу учруулсныг хэлнэ.
- *Гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл:* Бэлгийн дур хүслээ хангах объект мэт хандах, хүслийг нь үл харгалзан хүч хэрэглэх, гэр бүлийн бусад гишүүнийг хүчирхийлэх зэрэг орно.
- *Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийлэл:* Хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл гэдэг нь ихэвчлэн эцэг, эх асран халамжлагчдын хүүхдээ асран хамгаалах ердийн хэм хэмжээний баталгаа алдагдсаны улмаас хүүхэд хор нөлөөг нь амсахыг хэлнэ.

Хүчирхийллийн эцсийн хохирогч нь хүүхэд бөгөөд хүүхдийн хөгжил, төлөвшилд асар их сөрөг нөлөө үзүүлдэг болохыг онцгой анхааруулж таниулна. Энгийн бөгөөд санамсаргүй зүйл ч хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийн аль нэг хэлбэр болдог. Тухайлбал хүүхдийг сонсохгүй байх, хүсэл сонирхлыг нь үл харгалзан үзэх гэх мэт.

Хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл гэдэг нь ихэвчлэн эцэг, эх асран халамжлагчдын хүүхдээ асран хамгаалах ердийн хэм хэмжээний баталгаа алдагдсаны улмаас хүүхэд хор нөлөөг нь амсахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл хүүхдийн зүй ёсны хүсэл сонирхлыг хүчээр буюу бусад арга замаар хясан боогдуулах, хоорондын таарамжгүй харилцааны улмаас хүүхдийг сэтгэл санааны гүн дарамтанд оруулахыг хэлнэ. Үүнд эцэг эх эсвэл асран халамжлагчдын зүгээс үйлдсэн болон хийх ёстой үүргээ биелүүлээгүй үйлдлүүдийг хамааруулдаг байна.

Хүчирхийллийн бус аргаар асуудлыг шийдвэрлэхэд харилцаандаа дараах зарчмыг баримтлах шаардлагатайг сайтар ойлгуулна.

- ✓ Саруул уужим ухаанаар хандах
- ✓ Сэтгэлийн дотоод амар амгалан, тайван байдлыг эрхэмлэх
- ✓ Харилцан ойлголцож ярилцах
- ✓ Хүлээцтэй, тэвчээртэй байх
- ✓ Эв эеийг эрхэмлэх
- ✓ Өөрийн буруу алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрөх
- ✓ Буулт хийх

- ✓ Өсөрхөж гомдохгүй байх, уучлах
- ✓ Маргаан, сөргөлдөөн гаргахаас зайлсхийх

Дараах асуултын дагуу үнэлгээ хийнэ.

А. Гэр бүлийн гишүүдийн харилцаа

- Бие биеэ дэмжсэн, нээлттэй, эерэг харилцаатай бол 3
- Эерэг ч, бага зэргийн зөрчилтэй бол 2
- Зөрчилтэй, сөрөг муу нөлөө, хүчирхийлэлтэй бол 1

Б. Хүүхдийн хүмүүжил, халамж

- Хүүхдийнхээ хүмүүжил, халамж асаргаанд зарцуулж буй цагтаа сэтгэл хангалуун бол 3
- Хүүхдийнхээ хүмүүжил, халамж асаргаанд төдийлэн цаг зарцуулж чаддаггүй бол 2
- Хүүхдийнхээ хүмүүжил, халамж асаргаанд огт цаг зарцуулдаггүй бол 1

В. Гэр бүлийн уламжлал, үнэт зүйлс

- Гэр бүлийн уламжлал, үнэт зүйлсээ өрхийн бүх гишүүд дээдэлдэг бол 3
- Гэр бүлийн уламжлал, үнэт зүйлсийн талаар өрхийн гишүүд нэгдмэл ойлголтгүй бол 2
- Гэр бүлийн уламжлал, үнэт зүйлсийн тухай ямар ч ойлголт, мэдлэггүй бол 1

Г. Буруу зуршил, хэрэглээ

- Архи, мансууруулах бодис хэрэглэдэг гишүүн байхгүй бол 3
- Архи, мансууруулах бодис хааяа хэтрүүлэн хэрэглэдэг гишүүд байдаг бол 2
- Архи, мансууруулах бодис байнга хэтрүүлэн хэрэглэдэг гишүүд байдаг бол 1

14. НИЙГМИЙН ХАРИЛЦАА



А. Найз нөхөд, хамт олны тусламж, дэмжлэг

Зорилтот өрхийн гишүүдийн ихэнх нь ажил, сургуульгүй байдаг учир найз нөхөд цөөтэй, хамт олны дэмжлэг туслалцаагүй байх нь элбэг.

Зорилтот бүлгийнхний хувьд эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бусдын дэмжлэг маш их шаардлагатай хэдий ч энэхүү дэмжлэгийг авч чаддаггүй билээ.

Иймд тэдний нийгэм, хамт олны дунд байх хэрэгцээ хангагдахгүйгээс бухимдал ихтэй, гэр бүлийн гишүүд хоорондын харилцаа тааруу, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан зэрэг хүч чадал дорой хэсэг нь хүчирхийлэлд байнга өртдөг, архийг их хэмжээгээр байнга хэрэглэдэг зэрэг сөрөг дадал хэвшил, зан үйлтэй байдаг. Иймд өрхийн насанд хүрэгчдийг ажил хөдөлмөр эрхлүүлэх замаар

нийгэм хамт олны дунд хөгжүүлэх шаардлагатай юм.

Өрхийн гишүүдийн өөрсдийн тодорхойлсноор сэтгэл ханамжийг тэмдэглэнэ.



Б.Хөршийн харилцаа холбоо

Амьдарч буй нутаг дэвсгэрийн эрүүл, аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэд, айл өрхүүд бие биедээ туслах, элдэв хүчирхийлэл, аюулаас бие биенийгээ хамгаалах, мэдлэг чадвар, боловсрол, эдийн засгийн хувьд туслах зэрэг эерэг хандлагыг төлөвшүүлэх нь Зорилтот өрхийн хөгжлийн

төлөвлөгөөний нэг чухал хэсэг болдог.

Статистик мэдээнээс харахад гэр, орон сууцанд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн 50-60 хувийг иргэдийн өмчлөх эрхийн эсрэг, 30-40 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Иймд Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 126 дугаар тогтоолоор Хөршийн хяналт хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх журмыг баталсан байна. Хөтөлбөрийн хүрээнд цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх бодит мэдээ, мэдээллийг цаг алдалгүй тухай бүрт түргэн шуурхай мэдээлэх, зөрчил дутагдлын хажуугааар дуугүй өнгөрөх биш харин иргэн бүр хууль ёсны шаардлага тавьдаг байх, та бидний таньж мэддэг хүмүүс, найз нөхөд, хамаатан садан, ойр дотны хэн нэгэн гэр бүлийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэл дарамтад өртөж буй талаар хууль хяналтын байгууллагад мэдээлдэг байх, иргэнийхээ үүргийг биелүүлдэг байх хэрэгтэй гэж үзсэн байна.

Түүнчлэн хөрштэйгээ сайн харилцаатай байж хүнд хэцүү цагтаа бие биедээ тусалдаг байх, хүндэтгэлтэй харилцдаг байх нь зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хувьд эерэгээр нөлөөлөх юм.

Өрхийн гишүүдийн өөрсдийн тодорхойлсноор сэтгэл ханамжийг тэмдэглэнэ.



В.Олон нийтийн үйл ажиллагаан дах идэвх, оролцоо

Зорилтот бүлгийн иргэдийн хувьд бусдаар хүндлүүлэх, олон нийтийн дунд байх хэрэгцээ хангагдаагүйгээс болж өөртөө болон амьдралдаа итгэл итгэл суларч, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо маш бага байх нь түгээмэл байдаг.

Тэд олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор бусдаас сайн туршлага, мэдээллийг олж авах, бусдын үлгэр дууриаллыг өөрийн гэр бүлийн амьдралдаа ашиглах зэрэг олон эерэг үр дагавартай.

Иймд орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдах үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг хугацаанд нь тэдэнд хүргэх, заавал оролцуулж байхад нийгмийн ажилтан анхаарах ёстой.

Өрхийн гишүүдийн өөрсдийн тодорхойлсноор сэтгэл ханамжийг тэмдэглэнэ. Дараах асуултын дагуу үнэлгээг хийнэ:

А. Найз нөхөд, хамт олны тусламж, дэмжлэг

- Бүх гишүүд бусадтай нээлттэй, эерэг харилцаатай, шаардлагатай үед бусдаас тусламж, дэмжлэг авч/өгч чаддаг бол 3
- Зарим гишүүд бусадтай нээлттэй, эерэг харилцаатай байж, шаардлагатай үед бусдаас тусламж, дэмжлэг авч/өгч чаддаг бол 2
- Бүх гишүүд бусадтай байнга зөрчилтэй, тусламж, дэмжлэг авч/өгч чаддаггүй бол 1

Б. Хөршийн харилцаа холбоо

- Бие биеэ дэмжсэн, нээлттэй, эерэг харилцаатай бол 3
- Эерэг ч, дэмжлэггүй, зарим үед зөрчилтэй харилцаатай бол 2
- Байнга зөрчилтэй, сөрөг, тааламжгүй харилцаатай бол 1

В. Олон нийтийн үйл ажиллагаан дах идэвх, оролцоо

- Бүх гишүүд идэвх, санаачилгатай, оролцоотой бол 3
- Зарим гишүүд идэвхтэй оролцдог бол 2
- Бүх гишүүдийн идэвх санаачилга сул, оролцоогүй бол 1

___оОо___

Хавсралт



Хавсралт 1

ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан)

	Эрэлт хэрэгцээний түвшин, асуудал	Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Санхүүгийн эх үүсвэр
1	ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ	1.				
		2.				
		3				
	Орон байр	1.				
		2.				
		3.				
	Хоол хүнс, хэрэглээ	1.				
		2.				
		3.				
	Санхүү, ажил эрхлэлт	1.				
		2.				
		3,				
2	ЧАДАВХ, БОЛОМЖ					
	Эрүүл мэнд	1.				
		2.				
		3.				

2	Боловсрол, технологи	1.							
		2.							
		3.							
	Нийгмийн хамгаалал	1.							
		2.							
		3.							
		1.							
		2.							
		3.							
3	ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ	1.							
		2.							
		3.							
	Гэр бүл, нийгмийн харилцаа	1.							
		2.							
		3.							
		1.							
		2.							
		3.							

Өрхийн гишүүн:/...../Нэр/

...../Гарын үсэг/

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтэн:/...../Нэр/

Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах тухай дэлгэрэнгүй тайлбарыг нэгдүгээр бүлгээс харна уу:

ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан)

1. Салбар дундын зохицуулалтыг хангах

Салбар дундын зохицуулалт хариуцсан талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах:

- ✓ Үндэсний хэмжээнд “Хүн амын хөгжлийн асуудлаарх Үндэсний хороогоор Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг хэлэлцэж байх.

Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороог Засгийн газрын 2013 оны 97 дугаар тогтоолоор Хүн ам, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнээр ахлуулан байгуулсан бөгөөд бүрэлдэхүүнийг нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны ... дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

- ✓ Орон нутгийн түвшинд “Хүн амын хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо”-г аймаг/дүүргийн Засаг даргаар ахлуулан, бүрэлдэхүүнд нь бүх салбарын төлөөлөл, мөн иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж, өдөр тутмын үйл ажиллагааг тухайн аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс хариуцан ажиллах.

Үндэсний хорооны дүрэмд Хүн амын хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо”-г аймаг/дүүргийн Засаг даргаар ахлуулан, бүрэлдэхүүнд нь бүх салбарын төлөөлөл, мөн иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулах талаар тусгагдсан. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөртэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс хариуцна.

- ✓ Сум/хорооны түвшинд сум/хорооны Засаг даргаар ахлуулсан, нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч/багш, өрхийн эмч, цагдаагийн хэсгийн байцаагч, хэсгийн ахлагч, тухайн нутаг дэвсгэрийн нэр хүндтэй өрх, гэр бүл, иргэдийн төлөөллөөс бүрдсэн хамтарсан баг ажиллах
- ✓ Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний болон орон нутгийн хороо, хамтарсан багийн гишүүн бүрийн ажил үүргийн хуваарь, үр дүнгийн гэрээний биелэлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлыг тусган, дүгнэдэг хяналт-үнэлгээний хэлбэрийг бий болгох

Одоогоор зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн

Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэсийн холбогдох ажилтнуудын үр дүнгийн гэрээнд тус хөтөлбөрийг тусгасан. Цаашдаа бусад салбар, ажилтнуудын үүрэг хариуцлагыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа учир тэдний үр дүнгийн гэрээнд тусган, хэрэгжилтийг нь хангуулж, түүнд хяналт тавих нь зүйтэй юм.

- ✓ “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-ний хүрээнд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг төв, орон нутгийн бодлого, салбарын бодлого, хөтөлбөр, олон улсын болоод донор байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах, тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах.

Үүний тулд бусад салбар, олон улсын болоод донор байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиглэл, улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээний жил жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахаас өмнө Зорилтот өрхийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох талуудад хүргэж хэвших хэрэгтэй. Ингэж чадвал, салбарын хөгжлийн бодлого, чиглэл, тулгамдсан асуудлыг донор байгууллагын тухайн жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулах, зарим талаар үйл ажиллагааны давхцлаас зайлсхийж, санхүүжилтийг шийдэх боломж бүрдэнэ.

- ✓ Салбаруудын хамтын үйл ажиллагааны хүрээнд “Өрхийн хөгжил-Түншлэл”, “Нийгмийн хөгжлийн түншлэл” зэрэг хамтарсан хөтөлбөрийг төр-хувийн хэвшил, төр-иргэний нийгмийн байгууллага, төр-иргэн, төр-олон улсын байгууллага зэрэг олон талт хэлбэрээр хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах.

Хэрэв салбарууд энэхүү түншлэлийн дор нэгдэж чадвал өрх, гэр бүл, иргэдтэй холбоотой олон асуудлыг шийдэх санхүүжилт, хүн хүч, чадавхийг нэгэн зүгт дайчлах боломжтой болно.

- ✓ Нийгмийн ажилтан нь зорилтот өрхийн гишүүдийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамруулах ажлыг орон нутгийн төрийн байгууллага, ажилтнуудтай хамтран зохион байгуулж, хүүхдүүдийг бүх шатны боловсролд хамруулах, сургалтын төрийн сангийн зээлд хэрхэн хамрагдах зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх.

Нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдтэй хамтран өрх бүрт үнэлгээ хийж, хэрэгцээг нь тодорхойлсны дараа сум, хорооны хэмжээнд хамруулах шаардлагатай үйлчилгээний чиглэлээр нарийвчилсан судалгаа гаргана. Энэхүү судалгааг эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгал, хүнс, хөдөө аж зэрэг байгууллагад хүргүүлнэ. Эдгээр байгууллага судалгааны дагуу иргэдийг холбогдох үйлчилгээнд хамруулж, үр дүнг Засаг дарга, Хүн ам, хөгжлийн асуудлаарх хороонд тайлагнана.

- ✓ Бусад салбар, олон улсын болоод донор байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх нэгдсэн мэдээлэл сантай болох, салбаруудын мэдээллийн сангийн нэгдмэл байдлыг хангах, шаардлагатай мэдээ мэдээллийн солилцооны урсгалыг бий болгож, тогтмолжуулах.

Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс

ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс хамтран орон нутгийн хэмжээнд олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг цуглуулж, мэдээллийн сан байгуулна. Ялангуяа Дэлхийн зөн, АДРА, НҮБ-ын системийн байгууллагуудаас өрх, иргэний амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагаатай Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөрийг уялдуулах хэрэгтэй.


Өрхийн хөгжлийн төлрөөлөгөөний хэрэгжилтийн салбар дундын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг дараах байдлаар ажиллана:

	Байгууллага	Гүйцэтгэх чиг үүрэг	Хариуцах/оролцох нэгж/ажилтан
1	Хүн ам, хөгжлийн асуудлаарх үндэсний хороо	- Салбар дундын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, - Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төсөв хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийх.	- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж - Үндэсний хорооны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг заавал оруулна.
2	Хүн ам, хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо	- Салбар дундын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах ажлыг орон нутагт зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох төр, төрийн бус байгууллага, хандивлагчид, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, - Бодлого, чиглэлээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, - Хөрөнгө нөөцийг дайчлах, - Шаардлагатай хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх, - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийх.	- Аймаг, нийслэлийн Засаг дарга ахална. - Бүрэлдэхүүнд нийгмийн халамж, даатгал, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэнд, үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг эрхэлсэн төрийн байгууллага, хүний хөгжлийг хангах, амьжиргааг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөл, хөтөлбөр, олон улсын болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл байна.

3	Сум/ хорооны хамтарсан баг	• Олон нийт, гэр бүл, өрхөд тулгараад байгаа асуудлыг тодруулах, шийдвэрлэх арга замын талаар хамтран хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, • Өрх гэр бүлд өөр өөрийн мэргэжлийн үүднээс нөхцөл байдлын үнэлгээ хийх, • Байгууллага хоорондын харилцаа холбоог сайжруулах, • Асуудлыг шийдвэрлэх даван туулахын тулд мэргэжилтнүүд өөр өөрийн байр суурь үүрэг хариуцлагын үүднээс оролцох, • Нийгмийн суурь үйлчилгээг цогц хэлбэрээр хүргэх.	• Баг/хорооны засаг дарга • Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн мэргэжилтэн • Хөгжлийн нийгмийн ажилтэн • Тухайн хорооны хамран сургах тойргийн сургуулийн нийгмийн ажилтан • Цагдаагийн хэсгийн байцаагч • Өрхийн эмч • Цэцэрлэгийн эрхлэгч/багш • Албан бус боловсролын арга зүйч • Хэсгийн ахлагч • Иргэний бүртгэл, нийгмийн даатгал хариуцсан ажилтан • Нутгийн нэр хүндтэй иргэдийн төлөөлөл
---	-------------------------------------	---	---

2. Орон нутгийн түвшинд Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх гол байгууллага нь орон нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага байна. Үүнд:



1	Аймаг, нийслэлийн ИТХ	- Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг аймаг, нийслэлийн төсөвт тусгах - Засаг дарга, Тамгын газар, холбогдох байгууллагуудын зүгээс ӨХТ-г хэрэгжүүлэх талаар гаргаж буй санаачилга, хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих, хуралдаанаар хэлэлцэх - ӨХТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар дундын уялдаа холбоог хангах талаар холбогдох шийдвэрийг гаргах	- Засаг дарга - Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс
2	Сум, дүүргийн ИТХ	- Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зорилтот өрхийн тоог тогтоох - Сум, дүүргийн хэмжээнд Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусган батлах - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар Засаг даргын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнгийн талаар хэлэлцэн, зөвлөмж, чиглэлээр хангах	- Засаг дарга - Хамтарсан баг - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан
3	Баг, хорооны Иргэдийн нийтийн хурал	- Баг, хорооноос Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх өрхийг сонгох, баталгаажуулах - Шаардлагатай хөрөнгийн тооцоог сум, дүүргийн ИТХ-д уламжлах - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд хяналт тавих	- Багийн Засаг дарга - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хөгжлийн нийгмийн ажилтан - Хамтарсан баг
4	Аймаг, нийслэлийн Засаг дарга	- Аймаг, нийслэлийн хэмжээний Өрхийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх - Салбар байгууллагуудын уялдаа холбоог хангах, холбогдох байгууллагын Үр дүнгийн гэрээнд Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлыг тусган, хяналт тавих - Шаардлагатай хөрөнгийн тооцоог хийж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах - Хэрэгжилтийг нэгтгэн ИТХ-аар хэлэлцүүлэх - ХНХЯ-нд үр дүнг тайлагнах	- ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс
5	Сум, дүүргийн Засаг дарга	- Сум, дүүргийн хэмжээнд Зорилтот Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх Хамтарсан багийг байгуулан ажиллуулах - Сум, дүүргийн холбогдох байгууллагын үйл ажиллагаатай Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг уялдуулах, түүнд хяналт тавих - Сум, дүүргийн ИТХ-д Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт, хэрэгжилтийн талаар танилцуулах	- ЗДТГ-ын Хүн амын хөгжлийн асуудал хариуцсан ажилтан - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хамтарсан баг

6	Баг, хорооны Засаг дарга	• Сонгогдсон өрхийг холбогдох нийгмийн үйлчилгээ, сургалт, сурталчилгаанд хамруулах ажлыг Хамтарсан багтай хамтран зохион байгуулах • Өрхийн идэвх санаачилгыг дэмжих, урамшуулах, туршлага солилцох боломжийг бүрдүүлэн ажиллах • ӨХТ-ний хэрэгжилтийг сум, дүүргийн Засаг даргад тайлагнах • Шаардлагатай хөрөнгийг ИНХ-аар дамжуулан дээд шатны Засаг дарга, ИТХ-д оруулж, шийдвэрлүүлэх	- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хамтарсан баг
---	--------------------------	--	---

3. Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг улс, орон нутгийн төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиг үүргийн болоод салбар дундын зохицуулалтын талууд “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан, хэрэгжүүлэхэд жил бүрийн улсын төсөв, хөгжлийн төлөвлөлтийн хугацаатай уялдуулан дараах байдлаар оролцоно. Үүнд:

	Үе шатны ажил	Хугацаа	Хариуцах хүн/нэгж
1	Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх асуудлыг Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах	Жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор	- Засаг дарга - Засаг даргын Тамгын газар
2	Өрхүүдийг сонгож, баталгаажуулах	Жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор	- Сум/хорооны Засаг дарга - Хэсгийн ахлагч нар - Хамтарсан баг - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан
3	Өрхийн суурь үнэлгээ хийх	Жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор	- Өрх - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Нийгмийн ажилтан - Сум/хорооны Засаг дарга
4	Өрхийн түвшинд хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор	- Өрх - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хөгжлийн нийгмийн ажилтан - Сум/хорооны Засаг дарга
5	Өрхүүдийг хөгжүүлэх орон нутгийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулан, батлуулах	Жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор	- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хөгжлийн нийгмийн ажилтан - Аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс - Бүх шатны Засаг дарга нар - ИТХ - Хүн ам, хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо

6	Нэгдсэн төлөвлөгөөнд шаардлагатай санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийн саналыг орон нутгийн төсөвт тусгуулах	Жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор	- Аймаг/дүүргийн нийгмийн ажилтан - Аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга - Аймаг/дүүргийн Засаг дарга нар - Хүн ам, хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо
7	Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс	- Өрх - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хөгжлийн нийгмийн ажилтан - Сум/хорооны хамтарсан баг
8	Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Улирал тутам	- Өрх - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хөгжлийн нийгмийн ажилтан - Аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, ЗДТГ - Хүн ам, хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо - Хүн ам, хөгжлийн асуудлаарх үндэсний салбар хороо
9	Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тайлагнах	Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор	- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн ажилтан - Хөгжлийн нийгмийн ажилтан - Аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга - Аймаг/дүүргийн Засаг дарга нар - Хүн ам, хөгжлийн асуудлаарх орон нутгийн салбар хороо - Хүн ам, хөгжлийн асуудлаарх үндэсний салбар хороо

4.Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбар, байгууллагуудын оролцоог хангах

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүх салбар оролцох ба дараах чиглэлээр холбогдох, бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлж, тухайн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийн үйл ажиллагаанд холбогдох асуудлуудыг тусган, хэрэгжүүлэхэд дараах чиг үүргийг гүйцэтгэн, идэвх санаачилгатай ажиллана. Үүнд:

	Салбар	Хариуцах чиглэл
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	• Салбар дундын зохицуулалтыг хариуцах • Шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах • Шаардлагатай хөрөнгийн асуудлыг бусад салбартай хамтран шийдвэрлэх • Нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулах • Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамруулах бодлого хэрэгжүүлэх • Олон улсын байгууллагын үйл ажиллагаатай холбох • Судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд эхний ээлжинд хамруулах талаар холбогдох бодлого, шийдвэрийг гарган хэрэгжүүлэх • Зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ(хөдөлмөрт бэлтгэх болон хөдөлмөр эрхлэлтийн сургалтын хөтөлбөр гэх мэт)-ний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх • Хөнгөлөлттэй нөхцлөөр аж ахуй эрхлэх зээлд хамрагдах боломжийг бүрдүүлэх
2	Эрүүл мэндийн салбар	• Судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээнд эхний ээлжинд хамруулах талаар холбогдох бодлого, шийдвэрийг гарган хэрэгжүүлэх • Зорилтот бүлгийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр үйлчлэх • Эрүүл мэнддээ анхаардаг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах • Өндөр үнэтэй эмчилгээ, шинжилгээ хийлгэх шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн төлбөрийн асуудлаар тусгайлсан бодлого хэрэгжүүлэх • Зорилтот өрхийн эх хүүхдийн эрүүл мэнд, ариун цэврийн байгууламж зэрэг асуудлаар тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх
3	Боловсролын салбар	• Зорилтот бүлгийн хүүхдүүдийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах • Тэдэнд шаардлагатай хувцас, хичээлийн хэрэглэлд үнийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэх • Зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдийг шат ахин суралцахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
4	Хүнс, хөдөө аж ахуй салбар	• Зорилтот бүлгийн иргэдийг малжуулах, газар тариалан эрхлэх хөтөлбөрт хамруулах
5	Байгаль орчин, ногоон хөгжил	• Зорилтот бүлгийн иргэдийн ундны усны хангамжийг сайжруулах
6	Аж үйлдвэрийн салбар	• Хөнгөлөлттэй нөхцлөөр жижиг үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх
7	Барилга, хот байгуулалт	• Бага орлоготой иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хамруулах • Үл хөдлөх хөрөнгө, ялангуяа, газрын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
8	Эрчим хүчний салбар	• Эрчим хүчийг хэмнэх, нөхөн сэргээгдэх эх үүсвэрүүдийг түгээх, цахилгаанд холбох • Хөнгөлөлттэй үнээр эрчим хүчээр хангах

9	Онцгой байдал	- Аюул, осолгүй амьдрах зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, үзүүлэх сургуулилтыг зохион байгуулах - Амьдрах орчных нь байдалд үнэлгээ хийж, зөвлөмж чиглэлээр хангах
10	Цагдаагийн байгууллага	- Хүчирхийлэл дарамтад өртснийг мэдээлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнүүдийг бий болгох - Хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг явуулах

5. Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог хангах

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог дараах байдлаар хангана. Үүнд:

	Төрийн албан хаагч	Оролцоо, чиг үүрэг
1	Баг/хорооны Засаг дарга нар	- Хамтарсан багийг удирдлагаар хангах - Өрхийн үнэлгээ хийх, сургалт явуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах - Орон нутгийн хэмжээний өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хариуцах - Хамтран ажиллагч байгууллагын оролцоог хангах, үйл ажиллагааг нь дэмжин урамшуулах - Шаардлагатай хөрөнгийн асуудлыг ИТХ болон холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
2	Хөдөлмөр эрхлэлт нийгмийн халамжийн ажилтан	- Өрхийн нөхцөл байдлын үнэлгээг хийх ажлыг зохион байгуулах - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд хамрагдсан өрхийн талаарх мэдээллийн сан байгуулах, холбогдох судалгааг хийх - Тухайн үнэлгээгээр илрэн гарсан асуудлуудыг нэгтгэх, эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх - Хамтарсан багийн үйл ажиллагааг зохион байгуулах - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрхтэй хамтран боловсруулах - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээг төлөвлөх, хамрагдахад нь туслах - Нийгмийн үйлчилгээний байгууллагуудад өрхийг зуучлах, холбож өгөх - Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай иргэд болон гэр бүлийг тодорхойлж, хамруулах - Өрхийн гишүүдэд эерэг дадал төлөвшүүлэх, сөрөг зуршлаас салгахад чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах

3	Сургуулийн нийгмийн ажилтан	• Тухайн тойргийн хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулах • Багш нар, эцэг эхчүүдийг сурагчид болон үр хүүхдээ хүмүүжлийн эерэг аргаар хүмүүжүүлэх ур чадварт сургах • Сургууль завсардах эрсдэл бүхий сурагчид, тэдний гэр бүлтэй ажиллах • Ядуу болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур гэр бүлийн хүүхдүүдэд илүү анхаарлаа хандуулах • Сургуулийг хүчирхийлэлгүй хүүхдэд ээлтэй орчин болгох талаар тодорхой үйл ажиллагаа явуулах • Сурагчидтай ганцаарчлан болон бүлгээр ажиллах • Бусад салбарын нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах
4	Цагдаагийн ажилтан	• Иргэдийн амьдрах аюулгүй орчинг бий болгох болон гэмт хэрэгтэй тэмцэх • Гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэх болон өртөхөөс урьдчилан сэргийлэх • Энэ үйл ажиллагаанд ард иргэдийг татан оролцуулах • Гэмт хэргт холбогдох эрсдэл бүхий хэсэгтэй ажиллах • Хууль эрх зүйн сургалт явуулах, хуулийн талаар ухуулга таниулга хийх • Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажиллах
5	Сум, өрхийн эмнэлгийн эмч	• Өрхийн гишүүдийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, үйлчилгээг төлөвлөх • Эрүүл мэндийн заавал хэвшүүлэх зан үйл, эрүүл ахуйн талаар сургалт явуулах • Товлолт шинжилгээнд иргэдийг бүрэн хамруулах • Гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгөх • Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах • БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэ болон халдварт өвчний талаар мэдлэг олгох • Хэвтрийн болон хүнд өвчтэй иргэдэд гэрээр хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг зохион байгуулах
6	Цэцэрлэгийн эрхлэгч, багш	• Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулахын төлөө ажиллах • Сургуулийн өмнөх насны хүүхэдтэй гэр бүлтэй хамтран ажиллах • Гэр цэцэрлэг ажиллуулах, үүндээ аль болох цэцэрлэгт хамрагддаггүй хүүхдүүдийг хамруулах
7	Албан бус боловсролын арга зүйч	• Сургууль завсардсан болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийг албан бус боловсролд бүрэн хамруулах • Албан бус болон амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулах • Албан бус сургалтаас ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцуулах боломжийг бүрдүүлэх
8	Хэсгийн ахлагч нар	• Өрхийн сургалт үнэлгээнд хамрагдах өрхүүдийг сонгоход оролцох • Сургалтад өрхийн гишүүдийг хамруулах • Сургалт үнэлгээ хийх үйл ажиллагаанд туслах • Тухайн өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өрхийн гишүүдийг татан оролцуулах

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, салбар дундын зохицуулалт дээр дурьдсан байдлаар хийгдэх ба удирдлага, зохицуулалтыг сайжруулахын тулд дараах асуудлыг төв, орон нутгийн түвшинд нэн тэргүүнд шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд:

6. Ач холбогдлыг ойлгуулан таниулах:

Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө"-ний ач холбогдлыг бүх түвшинд ойлгуулан таниулах ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- ✓ Өрхийн амьжиргааг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулах асуудлыг хөгжлийн бодлого, хөтөлбөр, тухайлбал, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зорилтууд (2016-2030), Засгийн газар, Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдаг. *"Өрхийн хөгжлийн төлөвлөгөө" бол хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төдийгүй иргэдийн оролцоотой хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх нэг гол арга хэрэгсэл* гэдгийг бүх шатны бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, төв/орон нутгийн удирдлагын түвшинд ухуулга нөлөөллийн боломжит хэлбэр (зөвлөлдөх уулзалт ярилцлага, хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, танилцуулга материал тараах)-ийг ашиглан ойлгуулах;
- ✓ *"Өрхийн хөгжлийн төлөвлөгөө" бол өрх, өрхийн гишүүдийн өөрсдийн хүсэл тэмүүлэл, хэрэгцээ, санаачилгад суурилсан, өрхийг хөгжүүлэх гол арга хэрэгсэл* гэдгийг өрхийн түвшинд ойлгуулан таниулах ухуулга нөлөөллийн ажлыг орон нутгийн байгууллагуудаас зохион байгуулах;
- ✓ *"Өрхийн хөгжлийн төлөвлөгөө" хэрэгжүүлэн, амьжиргаагаа дээшлүүлсэн өрх, гэр бүл, амьжиргаа сайжруулах зорилгоор бүлэг, хоршоо байгуулан ажиллаж, амжилтад хүрсэн өрх, иргэд болоод нийгмийн хариуцлагынхаа хүрээнд өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд санаачилгатай ажиллаж, өрх, өрхийн гишүүдийн хэрэгцээг хангахад зохих хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж байгууллагын шилдэг туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх. Шилдэг туршлага, ур чадварыг түгээн дэлгэрүүлэх олон нийтийг хамарсан үйл ажиллагааг жил бүрийн 5 дугаар сарын 15 "Олон улсын гэр бүлийн өдөр", 7 дугаар сарын 11 "Дэлхийн хүн амын өдөр", 10 дугаар сарын 17 "Ядуурлыг бууруулах олон улсын өдөр" зэрэг тэмдэглэлт өдрүүдээр зохион байгуулж, хэвших.*

7. Чадавхжуулах

- ✓ Зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын, тухайлбал, өрхийн гишүүд, нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулах
- ✓ Өрх, иргэдийг асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, амьдралын хэв маяг,

дадал зуршлаа өөрчлөх, хүндрэл бэрхшээлийг даван туулах чадавхид суралцуулах зорилготой сургалтуудыг мэргэжлийн (амьдрах ухааны, хувь хүний хөгжлийн, сэтгэл зүйн, гэр бүлийн гэх мэт) байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

- ✓ Нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдийн асуудалд дүн шинжилгээ хийх, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтэд гарч болох эрсдлийг тодорхойлох, нийгмийн ажлын үйлчилгээ, ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах зэрэг ур чадварт суралцуулах ажлын байрны сургалтуудад тогтмол хамруулах.

___oOo___

Хавсралт 3

ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан)

Эрэлт хэрэгцээний түвшин, асуудал	Зорилт	Үйл ажиллагаа	Гарсан үр дүн
1 ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ	Орон байр	1.	
		2.	
		3	
	Хоол хүнс, хэрэглээ	1.	
		2.	
		3.	
	Санхүү, ажил эрхлэлт	1.	
		2.	
		3,	

2	ЧАДАВХ, БОЛМЖ	Эрүүл мэнд	1.			
			2.			
			3.			
			1.			
			2.			
			3.			
			1.			
			2.			
			3.			
	Боловсрол, технологи	Нийгмийн хамгаалал	1.			
			2.			
			3.			
			1.			
			2.			
			3.			
			1.			
			2.			
			3.			
3	ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ	Гэр бүл, нийгмийн харилцаа	1.			
			2.			
			3.			
			1.			
			2.			
			3.			
			1.			

Амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа	Амжилттай хэрэгжихэд нөлөөлсөн хүчин зүйлс
...	...
Тохиолдсон бэрхшээл	Бэрхшээлийг даван туулсан байдал
...	...
Цаашдын үйл ажиллагааны талаарх санал зөвлөмж	
...	

Өрхийн гишүүн: /Гарын үсэг/ /Нэр/

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн мэргэжилтэн: /Гарын үсэг/ Нэр/

ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН АХИЦ ДЭВШИЛ

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан)

	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний дундаж утга			Өөрчлөлт	
		Суурь үе	Тайлант үе	Статистик ач холбогдлын түвшин	Абсолют	Хувийн жингийн
1	ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ					
	Орон байр					
	Хоол хүнс, хэрэглээ					
	Санхүү, ажил эрхлэлт					
2	ЧАДАВХ, БОЛОМЖ					
	Эрүүл мэнд					
	Боловсрол, технологи					
	Нийгмийн хамгаалал					
3	ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ					
	Гэр бүл, нийгмийн харилцаа					
	ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ УТГА					
	ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ОНОО					

Өрхийн гишүүн:/Гарын үсэг//Нэр/

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн мэргэжилтэн:/Гарын үсэг//Нэр/

..... СУМ/ДҮҮРЭГ, АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЗОРИЛТОТ ӨРХИЙН
ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАН

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан)

	Эрэлт хэрэгцээний түвшин, асуудал	Хэрэгжсэн үйл ажиллагаа		Хэрэгжээгүй үйл ажиллагаа	
		Үйл ажиллагааны нэр	Туршлага болгож, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр	Бэрхшээл, сургамж
1	ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ				
	Орон байр				
	Хоол хүнс, хэрэглээ				
	Санхүү, ажил эрхлэлт				
2	ЧАДАВХ, БОЛОМЖ				
	Эрүүл мэнд				
	Боловсрол, технологи				
	Нийгмийн хамгаалал				
3	ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ				
	Гэр бүл, нийгмийн харилцаа				

Өрхийн гишүүн:	/Гарын үсэг/	/Нэр/
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн мэргэжилтэн:	/Гарын үсэг/	/Нэр/

..... СУМ/ДҮҮРЭГ, АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЗОРИЛТОТ ӨРХИЙН
ХӨГЖЛИЙН АХИЦ ДЭВШЛИЙН НЭГТГЭЛ

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн
А/26 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан)

	Шалгуур үзүүлэлт	Өрхийн тоо, хувийн жин					
		Ахиц гарсан		Хэвээрээ байсан		Суурь үеийн түвшнээс буурсан	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	ҮНДСЭН ХЭРЭГЦЭЭ						
	Орон байр						
	Хоол хүнс, хэрэглээ						
	Санхүү, ажил эрхлэлт						
	ЧАДАВХ, БОЛОМЖ						
2	Эрүүл мэнд						
	Боловсрол, технологи						
	Нийгмийн хамгаалал						
3	ЁС СУРТАХУУН, ХҮНДЛЭЛ						
	Гэр бүл, нийгмийн харилцаа						
	ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ УТГА						
	ХӨГЖЛИЙН ТҮВШИН						

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн дарга:/Гарын үсэг//Нэр/

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн мэргэжилтэн:/Гарын үсэг//Нэр/

Хавсралт 7

СУМ/ДҮҮРЭГ, АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ МАЯГТ

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан)

	Хүрэх үр дүн	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин
1.	Үр дүн 1: Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэж, мэргэжил, ур чадвар ахисан байна.	• Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа хүн амын дор хаяж 50 хувь нь байнгын ажлын байртай болно. • Өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлэхгүй байгаа хүн ам хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд 100 хувь хамрагдаж мэргэжил, ур чадвараа ахиулсан, мэргэжлийн чиг баримжаатай болно.	
2.	Үр дүн 2: Нийгмийн хамгааллын үйлчилгээ, дэмжлэг туслалцаа шаардлагатай бүх хүндээ хүрсэн байна.	• Өрхийн гишүүд нийгмийн даатгалд заавал болон сайн дураар бүрэн хамрагдсан байна. • Хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход шаардлагатай бичиг баримтын зөрчилтэй өрхийн гишүүнгүй болно. • Хуульд заасан нөхцлөөр халамжийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай өрхийн гишүүдийн хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэнэ. • Хуульд заасан нөхцлөөр нийгмийн тусламж, хөнгөлөлтөд хамрагдах шаардлагатай өрхийн гишүүдийн хамрагдалтын түвшин 100 хувьд хүрнэ.	
3.	Үр дүн 3: Өрхийн гишүүдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалтын түвшин өссөн байна.	• Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшин суурь үеийнхээс 50 хувиар нэмэгдсэн байна. • Суурь боловсрол эзэмших насны хүүхдүүд 100 хувь сургуульд хамрагдана. • Сургууль завсардсан хүүхдүүд 100 хувь албан бус сургалтад хамрагдсан байна. • Өрхийн 15-аас дээш насны хүүхэд залуус нь МСҮТ шаардлагатай бол төрийн сангийн зээл тусламжаар их, дээд сургуульд хамрагдсан байна.	

4.	Үр дүн 4: Өрхийн гишүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдалтын түвшин нэмэгдсэн байна.	• Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдагсдын түвшин суурь үеийнхээс 50 хувиар нэмэгдэнэ. • Өрхийн 5 хүртэлх насны хүүхдүүд өсөлт, хөгжлийн хяналт, вакцинжуулалтад бүрэн хамрагдана. • Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хяналт, үйлчилгээнд хамрагдалт 100 хувьд хүрнэ.
5.	Үр дүн 5: Өрхийн гишүүдийн сөрөг зан үйл, дадал арилж, гэр бүлийн харилцаа эерэг, таатай болсон байна.	• Архидан согтуурах, мансуурах, бусдыг хүчирхийлэх, тэнэх зэрэг сөрөг зан үйлтэй өрхийн гишүүдгүй болно. • Хүүхдийн хүмүүжил, халамж, асаргаанд хангалттай цаг зарцуулдаг эцэг эхчүүдийн хувийн жин суурь үеийн түвшнээс 50 хувиар нэмэгдэнэ. • Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан орчинд амьдардаг өрхийн хувийн жин суурь үеийн түвшнээс 30 хувиар өснө. • Зохицтой хэрэглээтэй, эрүүл аж төрөх ёсны зан үйл төлөвшсөн өрхийн хувийн жин суурь үеийн түвшнээс 30 хувиар өснө.
6.	Үр дүн 6: Өрхийн гишүүдийн нийгмийн идэвх, санаачилга нэмэгдэж, олон нийтийн шинжтэй арга хэмжээнд оролцох оролцоо сайжирсан байна.	• Сум/хорооноос зохион байгуулж буй олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцогч өрхийн хувийн жин суурь үеийн түвшнээс 50 хувиар нэмэгдэнэ. • Өөрсдийн санаачилгаар нэгдмэл бүлэг үүсгэн, хамтын үйл ажиллагаа эрхэлж буй өрхүүдтэй болсон байна. • Өрхийн хөгжлийн түвшингээ ахиулсан өрхүүдийн 30 хүртэлх хувийнх нь ололт, амжилт, туршлага, сургамжийг бусдад түгээн дэлгэрүүлсэн байна.
7.	Үр дүн 7: Өрхүүдийн амьжиргааны түвшин суурь үеийн түвшингээс өсч, өрхийн хөгжлийн түвшин ахисан байна.	• Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн 50-иас доошгүй хувийнх нь өрхийн хөгжлийн түвшин ахисан байна. • Өрхийн хөгжлийн түвшин ахисан өрхүүдийн 30-аас дээш хувийнх нь амьжиргааны түвшин ядуурлын шугамаас дээш гарсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн дарга:/Гарын үсэг//Нэр/

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн мэргэжилтэн:/Гарын үсэг//Нэр/

АЙМАГ, ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ ӨРХИЙН ТООНЫ ДООД ХЯЗГААР*

(Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 2 сарын 22-ны өдрийн А/26 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан)

Аймаг, дүүрэг	Хөтөлбөрийн хугацаанд хамруулах өрхийн тоо /2016-2020 онд/	Нэг жилд хамруулах зорилтот өрхийн тоо
Архангай	2050	513
Баян-Өлгий	1764	441
Баянхонгор	1873	468
Булган	1404	351
Говь-Алтай	1235	309
Говьсүмбэр	324	81
Дархан-Уул	1878	469
Дорноговь	1303	326
Дорнод	2128	532
Дундговь	898	225
Завхан	1597	399
Орхон	1993	498
Өвөрхангай	2514	629
Өмнөговь	1345	336
Сүхбаатар	1597	399
Сэлэнгэ	2023	506
Төв	1892	473
Увс	1626	406
Ховд	1655	414
Хөвсгөл	2845	711
Хэнтий	2161	540
Аймгийн дүн	36104	9026
Багануур	418	105
Багахангай	54	13
Баянгол	2858	714
Баянзүрх	4480	1120
Налайх	491	123
Сонгинохайрхан	4042	1010
Сүхбаатар	1788	447
Хан-Уул	2060	515
Чингэлтэй	2041	510
Нийслэлийн дүн	18231	4558
Улсын дүн	54335	13584

* УБСЕГ-аас газраас гаргасан бүсийн ядуурлын хамралтын хүрээ, тухайн аймаг, дүүргийн нийт өрхийн тоо, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг үндэслэн тооцож гаргасан болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль
- Ахмад настны тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Иргэний бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хуульд
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Суурь боловсролын тухай хууль
- Газрын тухай хууль
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”
- ХАХНХ-ын сайдын 2016 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот өрхийн хөгжлийн үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах, хянах аргачлал, зөвлөмж, маягтууд”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсөв боловсруулах журам”
- Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны нэгдүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүд
- ГХГЗЗГ-ын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”
- Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 126 дугаар тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт” хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх журам
- “Нүхэн жорлон, муу усны цооног”-ын техникийн шаардлага MNS 5924:2015 стандарт

Ном товхимол

- “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө-Нийгмийн ажилтны гарын авлага” 2013, ХАХНХЯ, НХҮЕГ, НҮБ-ын Хүүхдийн сан
- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, 2014 он, НХҮЕГ
- “Зорилтот өрхийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалтын модул” Багшийн гарын авлага, 2014 он, НХҮЕГ, Дэлхийн банк
- “Иргэн таны гэр бүлийн боловсролд” 2014 он, НХҮЕГ, Дэлхийн банк
- “Ариун цэврийн байгууламжийн төрлүүд” ЭМСЯ, WaSH, НҮБ-ын Хүүхдийн сан
- Б.Оюунсүрэн “Гэр бүлийн эдийн засгийн боловсрол” 2014 он
- Т.Намжил “Гэр бүл судлалын онол, арга зүй” 2013 он
- Г.Цэрэнжигмэд, Г.Сүхбат “Зан үйл эрүүл аж төрөх ёс” УБ, 2002 он
- Пол Брэг “Эрүүлжих ухаан эмгүй амьдрал” УБ, 2002
- Н.Цэцэгмаа “Идэвхтэй хөдөлгөөн эрүүл явахын үндэс” УБ, 2002 он
- М.Оюунбилэг “Насанд хүрэгчдийн хооллолт” 2013 он
- Ч.Зориггоо “Эрүүл мэндийн алтан ном” 2013 он
- “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” ЭМЯ
- “Заавал хэвшүүлэх 21 дадал” ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монголын эрүүл мэндийг дэмжих сан, 2014 он

Интернетээс

- Wikipedia.mn
- <http://legalinfo.mn>
- www.mlsp.gov.mn
- <http://www.ndaatgal.mn>
- <http://hudulmur-halamj.gov.mn>
- <http://www.fcy.gov.mn>
- Фэйсбүүк хуудас Land Owner LLC/Ланд Овнер ХХК



ISBN 999785314-8



9 789997 853141

ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.